



**“ ОРОН НУТГИЙН ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ
БАЙДЛЫГ ХАНГАХ ДЭД ХӨТӨЛБӨРТ
“ОРОЛЦООНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭ” ХИЙХ АРГАЧЛАЛ” сургалтын гарын
авлага**



Боловсруулсан: Д.Бүжин, ЛЭОС-ын Дорнод аймаг дахь салбарын тэргүүн
Н.Оюунханд, ЛЭОС-ын Дорнод салбарын УЗ-ын гишүүн
Хянасан: П.Даваанамжил, МОНЭС-ын ТОХ-ийн зохицуулагч

ДОРНОД АЙМАГ 2021 ОН

АГУУЛГА

Товчилсон үгийн жагсаалт	2
Өмнөх үг	3
Үндсэн ойлголтууд	
-Жендэрийн үндсэн ойлголтууд	4
-Оролцооны хяналт шинжилгээ, үнэлгээний ойлголт	5
-Хяналт шинжилгээ ба үнэлгээний ялгаа	6
Үе шат 1: Оролцооны хяналт шинжилгээ, үнэлгээг хэрхэн зохион байгуулж бэлтгэл ажлыг хангах вэ?	
1.1 ОХШҮ хийх баг бүрдүүлэх тухай	8
1.2 ОХШҮ-ний багийн гишүүдийн ажил үүргийн хуваарь	9
1.3 Багийн гишүүдийг бэлтгэх	10
1.4 Үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах	11
1.5 ОХШҮ хийх төсөв төлөвлөх, баримтжуулалт хийх	12
Үе шат 2: Батлагдсан ОНЖДХ-ийн хэрэгжилтэнд хийх ОХШҮ-ний бэлтгэл ажил	
2.1 Юунд ОХШҮ хийх вэ? Орон нутгийн ЖЭТБХДХ-ийг тодорхойлох нь	13
2.2 ОХШҮ-ний хамрах хүрээг тогтоох нь	22
2.3 ОХШҮ-ний зорилго	24
2.4 ОХШҮ-ээр цуглуулах мэдээллийн хүрээг тогтоох нь	26
2.5 ОХШҮ хийх арга зүйн талаар иргэд олон нийтгэй зөвлөлдөх	28
Үе шат 3. ОХШҮ хийх үеийн мэдээллийг хэрхэн цуглуулах вэ? ОХШҮ-ний мэдээлэл цуглуулах үйл ажиллагааны алхамууд	
3.1 Мэдээллийг цуглуулах аргууд	28
3.2 Мэдээллийн эх сурвалж, түүвэр тогтоох	29
3.3 Мэдээлэл цуглуулах аргуудын хэрэглэгдэхүүнийг боловсруулах	30
3.4 Мэдээлэл цуглуулах үйл ажиллагааны төлөвлөлт	37
Үе шат 4. Цуглуулсан мэдээллээ хэрхэн боловсруулж, шинжлэх вэ?	
Дорнод аймгийн ОХШҮ-ний мэдээллийн боловсруулалт:	
4.1 Хяналт шинжилгээний мэдээлэлд шинжилгээ хийх	39
4.2 Тоон мэдээлэлд шинжилгээ хийх	40
4.3 Чанарын мэдээлэлд дүн шинжилгээ хийх	41
Үе шат 5. ОХШҮ-ний үр дүнг танилцуулах, бодлогын зөвлөмж боловсруулах	
5.1 ОХШҮ-ний үр дүн	43
5.2 ОХШҮ-ний бодлогын зөвлөмж боловсруулах	45
Үе шат 6. ОХШҮ-ний үр дүнд тулгуурлан шийдвэр гаргагчдад хэрхэн нөлөөлөх вэ? Мэдээллийг хэрхэн түгээх вэ?	
6.1 Оролцогч талд мэдээллийг хэрхэн түгээх вэ?	48
6.2 Талуудын зөвлөлдөх уулзалтыг хэрхэн зохион байгуулах вэ?	50
6.3 Шийдвэр гаргагчдад хэрхэн нөлөөлөх	51
Ашигласан материал	56
Хавсралт /Арга зүй/	57

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АХБ	Азийн Хөгжлийн банк
ААН	Аж ахуйн нэгж
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
БСШУСЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам
ЖБ	Жендэрийн бодлого
ЖҮХ	Жендэрийн үндэсний хороо
ЖЭТБХ	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЗД	Засаг дарга
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ИНБ	Иргэний нийгмийн байгууллага
НБХСХ	Нийгмийн бодлого, хөгжлийн судалгааны хүрээлэн
НҮБХАС	Нэгдсэн Үндэсний байгууллагын хүн амын сан
ТББ	Төрийн бус байгууллага
ТАХ	Төрийн албан хаагч
ОНЖДХ	Орон нутгийн жендэрийн дэд хөтөлбөр
ОХШҮ	Оролцоот хяналт шинжилгээ, үнэлгээ
ХШ	Хяналт шинжилгээ
ХШҮ	Хяналт шинжилгээ үнэлгээ
ХЭҮК	Хүний эрхийн үндэсний комисс

ӨМНӨХ ҮГ

ХШҮ-ний асуудал төдийлөн шинэ ойлголт биш боловч ХШҮ-ний уламжлалт аргууд нь хөгжлийн бодлогын төлөвлөлт, хэрэгжилт, үр нөлөөг үнэлэхэд үр шим хүртэгчдийн хэрэгцээ сонирхол, тулгамдаж буй асуудал болон асуудлын шийдэл, арга замын талаар үзэл бодлоо илэрхийлэн, үнэлгээ өгөх боломжийг хязгаарладаг.

ОХШҮ-ний гол зорилт нь өөрчлөлт хийх үйл явцад талуудын адил тэгш оролцоог хангаж, тэдэнд өөрсдийн санал санаачилгыг дэмжих эрх мэдэл олгох замаар бодлого, хөтөлбөр, төсөл, үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжилтэнд хяналт тавихад татан оролцуулах явдал юм.

Оролцогч талуудын үр дүнтэй, тэгш эрхтэй, идэвхитэй хамтын ажиллагаа нь юуг хэрхэн хэрэгжүүлэх, ололт дутагдлаа хэрхэн үнэлж хэмжих вэ гэдгийг тодорхойлдог учраас хэн нэгэн мэргэжилтэн, экспертийн боловсруулж өгсөн бодлого хөтөлбөрөөс илүү амжилттай хэрэгждэг. Мөн хэрэгжих үйл явцдаа гаргасан алдаа, оноо, үр дүнгээ хамтдаа хэлэлцэж дүгнэдэг учраас тасралтгүйгээр суралцах, сайжрах боломжийг бий болгодог (ОНЖДХ-т ОХШҮ хийх аргачлал, 2020).

Иймээс энэхүү гарын авлагад оролцоот хяналт шинжилгээ, үнэлгээний үндсэн ойлголт, ОХШҮ хийх арга зүй болон нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулах талаар өгүүлэх бөгөөд төр, ИНБ болон бусад талуудын хамтын оролцоотойгоор хяналт шинжилгээ үнэлгээ хийх тохиолдолд ашиглах боломжтой юм.

Орон нутгийн ЖЭТБХ дэд хөтөлбөрт хийх аргачлалыг Дорнод аймгийн ЖЭТБХ дэд хөтөлбөрийн хэрэгжилтэнд хийсэн үнэлгээний материалаас жишээлэн, “Орон нутгийн жендэрийн дэд хөтөлбөрт оролцооны хяналт шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал” гарын авлагыг ашиглан боловсрууллаа.

Үндсэн ойлголтууд

ОХШҮ-ний аргачлалд суралцахаас өмнө Жендэр болон ОХШҮ –ний талаар үндсэн ойлголт, мэдлэгтэй байх хэрэгтэй юм. Жендэрийн үндсэн ойлголтууд болон ХШҮ-ний талаар Монгол улсын холбогдох хууль, бодлогын бичиг баримт болон бусад холбогдох гарын авлага номонд доор дурдсан байдлаар тусгасан байдаг. Үүнд:

1. Жендэрийн үндсэн ойлголтууд

Жендэр: Улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй хүний гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлага, тэдний нийгэмд эзлэх байр суурийн талаар уламжлагдан тогтсон, түүхэн явцад хувьсан өөрчлөгддөг ойлголт, үзэл, хандлагыг хэлнэ. /ЖЭТБХТХ, 2011/

Хүйс: Эрэгтэй эмэгтэй хүмүүсийн биологийн ялгаатай байдал, хэв шинжийг илэрхийлэх бөгөөд эрэгтэй эмэгтэй хүн гэж ялган ангилахыг хэлнэ. /БСШУСЯ, АХБ, ДБШТ/

Жендэрийн тэгш эрх: Эрэгтэй эмэгтэй хүмүүст ялгаваргүйгээр тэдний тусгай буюу өвөрмөц хэрэгцээ, сонирхлынх нь дагуу тэгш шударга хандах явдлыг хэлнэ. /МОНЭС, 2017/ Жендэрийн эрх тэгш байдлыг хангахаар тодорхой үр дүн гарах хүртэл эрэгтэй, эмэгтэйчүүдэд ялгаатай хандах зориудын тусгай арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлага гарч болно. /БСШУСЯ, АХБ, ДБШТ, 2019/

Жендрийн эрх тэгш байдал: Жендэрийн эрх тэгш байдал” гэж эрэгтэй, эмэгтэй хүн улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд тэгш эрхтэй оролцож, эдийн засаг, нийгэм, соёлын хөгжлийн үр шимээс тэгш хүртэж, хөгжилд эрх тэгш хувь нэмрээ оруулснаар жендэрийн ялгаварлан гадуурхалтаас ангид байхыг хэлнэ. /ЖЭТБХТХ, 2011/

Жендэрийн ялгаварлан гадуурхалт: “Жендэрийн ялгаварлан гадуурхалт” гэж улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд болон аливаа бусад салбарт эрэгтэй, эмэгтэй хүнийг хүйсийн шинж, гэрлэлтийн байдлаар ялгаварлах, үгүйсгэх, хязгаарлах үйлдэл, эс үйлдэхүйг; /ЖЭТБХТХ, 2011/

Жендэрт суурилсан хүчирхийлэл: Жендэрээс үүдэлтэйгээр бусдад бие махбодийн, бэлгийн, сэтгэл санааны гэм хор, эдийн хохирол учруулсан, учруулж болзошгүй үйлдэл, эс үйлдэхүйг; /ЖЭТБХТХ, 2011/

Жендэрийн хэвшмэл үзэл: Улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй хүний гүйцэтгэх үүрэг, эдлэх эрхийн талаар хүйсийн шинжээр уламжлагдан тогтсон ялгаатай ойлголт, хандлага /ЖЭТБХТХ, 2011/

Жендэрийн өрөөсгөл хандлага: Төсөл хөтөлбөр, бодлого үйл ажиллагаа, хүмүүс хоорондын харилцаанд зөвхөн нэг хүйстэнд давуутай, нөгөө хүйсийг ялгаварлан гадуурхалд өртүүлэхүйц шинжтэй хэт дөвийлгөсөн эсвэл хэт дорд үзсэн хэлбрээр илэрдэг, үзэл хандлага үйл ажиллагаа, интервенци болон арга хэмжээнд тусгагдаж, үр дагаварт нь шударга бус байдал, ялгаварлан гадуурхалтанд хүргэхийг хэлнэ./БСШУСЯ, ШХА, МУБИС, НБХСХ, АХБ, 2018/

Жендэрийн мэдрэмжтэй байдал: Эрэгтэй, эмэгтэйчүүдийн олон талт ялгаатай байдлыг харгалзан, тэдгээрийн ялгаатай хэрэгцээг тооцоолон, эрх тэгш байдлыг тогтоох шаардлагатай гэдгийг хүлээн зөвшөөрөх хандлага юм.

Жендэрийн харалган байдал: Эрэгтэй, эмэгтэйчүүдийн олон талт ялгаатай байдлыг харгалзан, тэдгээрийн ялгаатай хэрэгцээг тооцоолон, тэдэнд ирэх үр нөлөөг үл тоох, мэдэхгүй байх хандлага юм.

Жендэрийн төвийг сахьсан хандлага: Жендэрийн одоогийн байгаа жендэрийн харилцааг ямар нэг байдлаар хөндөлгүй, хэвээр нь хадгалж, үргэлжлүүлэхийг хэлнэ. Энэ нь ЖЭТБ-ын асуудлууд байгааг мэдэхгүй байх, эсвэл мэдэж, хүлээн зөвшөөрсөн ч өөрчлөх хүсэл сонирхолгүй байх хандлага юм.

Жендэрийн үзэл баримтлалыг бодлого, төлөвлөлт үйл ажиллагаанд тусгах: Жендэрийн үзэл баримтлалыг бодлого төлөвлөлт, үйл ажиллагаанд тусгах нь аливаа хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр болон хөгжлийн бүхий л санаачилгад эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн ялгаатай байдал, ялгаатай хэрэгцээг харгалзан тооцох замаар ЖЭТБ-ыг тогтооход чиглэсэн үйл явц, стратеги юм. /БСШУСЯ, ШХА, МУБИС, НБХСХ, АХБ, 2018/

Жендэрийн өөрчлөлт: Одоогийн байгаа аливаа төвийг сахьсан, жендэрийн өрөөсгөл хандлагатай, ялгаварлан гадуурхалд өртүүлэхүйц үр дүн, үр нөлөө бүхий байдлыг өөрчилж, эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн ялгаатай хэрэгцээг харгалзан, нахцол байдал, амьдралд сайнаар нөлөөлөхүйц өөрчлөлт гарах боломжтой жендэрийн бодлого, үйл ажиллагааг хэлнэ.

Жендэрийн мэдрэмжтэй хяналт шинжилгээ, үнэлгээ: Аливаа бодлого, төлөвлөлт, үйл ажиллагааны явц, хэрэгжилтийг түүнд оролцох эрэгтэй, эмэгтэйчүүдийн оролцоотойгоор тухайн бодлогын үр дүн, үр нөлөө /эерэг, сөрөг/ тэдэнд ялгаатай байгаа эсэх талаар шалгуур үзүүлэлт тогтоон, холбогдох нарийвчилсан мэдээлэл цуглуулах, хяналт үнэлгээ хийх үйл явцыг хэлнэ.

Хүйсээр ангилсан мэдээлэл: Эрэгтэйчүүд /хөвгүүд/ болон эмэгтэйчүүд /охид/-ээр нь ангилагдсан мэдээлэл

2. ОРОЛЦООНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ОЙЛГОЛТ

Хяналт шинжилгээ: Байгууллагын үйл ажиллагаа болон бодлогын зорилт, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явцыг урьдчилан тодорхойлсон шалгуур үзүүлэлтийн дагуу хянах, мэдээлэх тасралтгүй үйл ажиллагааг хэлнэ. /Засгийн газрын 2020 оны 206-р тогтоолын хавсралт/

Үнэлгээ: Байгууллагын үйл ажиллагаа, бодлогын баримт бичгийн зорилго, зорилтын хэрэгжилтийг төлөвлөсөн зорилтот түвшинд хүрсэн эсэхэд дүн шинжилгээ хийж үнэлэлт өгснийг хэлнэ. /Засгийн газрын 2020 оны 206-р тогтоолын хавсралт/. Үнэлгээ нь хөтөлбөр, төсөл, түүний бүрэлдэхүүн хэсэг тавьсан зорилгодоо хүрсэн эсэх, ямар үр дүн, үр ашиг, үр нөлөө гарч байгаа, юу нөлөөлсөн, сонгосон арга зам нь оновчтой эсэх, цаашдаа үргэлжлэн хэрэгжих боломжтой эсэхийг тодорхойлох зорилгоор хийдэг.

Хяналт шинэжилгээ ба үнэлгээний ялгаа: Хяналт шинжилгээ болон үнэлгээ нь бодлого үйл ажиллагааны төлөвлөсний дагуу хэрэгжиж байгаа эсэх, оновчтой бодлого боловсруулж байгаа эсэх, ямар туршлага, давуу тал бий болж, ямар сургамж байгаа, түүнийг цаашид

хэрхэн сайжруулах, шийдвэрлэх арга зам, хувилбаруудыг тогтооход анхаарал хандуулдгаараа төстэй.

Хяналт шинжилгээ нь: Бодлого төлөвлөсний дагуу хэрэгжиж байгаа эсэхийг хянадаг.

Үнэлгээ нь: Хэр зэрэг үр дүнтэйгээр хэрэгжиж байна вэ? гэдгийг тодорхойлохыг зорьдог.

Хүснэгт 1. Хяналт шинжилгээ ба үнэлгээний ялгаа

Хяналт шинжилгээ	Үнэлгээ
<ul style="list-style-type: none"> ➤ Суурь түвшний мэдээллийг цуглуулж юу хийснийг харах ➤ Зорилтуудыг шалгуур үзүүлэлтээр илэрхийлэх ➤ Хэрэгжилтийн явцын мэдээллийг тогтмол, системтэйгээр цуглуулж, шинжлэх ➤ Хэрэгжилтийн явцад тулгарах бэрхшээл, эрсдлийг тодорхойлох, бодлого, хөтөлбөр, төслийн төлөвлөлт, үйл ажиллагаанд өөрчлөлт оруулах 	<ul style="list-style-type: none"> ➤ Төлөвлөсөн зорилтот түвшинд хүрсэн эсэх, гарсан ахиц дэвшил, амжилтыг үнэлж, дүгнэлт өгөх ➤ Бодлого, хөтөлбөр, төсөл, үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөг үнэлэх ➤ Хэрэгжилтийн явцад гарах эрсдлийг бууруулах, сайжруулах санал дэвшүүлэх, төлөвлөх ➤ Нөөцийг зохистой ашиглах, төсөв хөрөнгө оруулалтын үр өгөөж, ашгийг үнэлэх

Үр дүнд суурилсан хяналт шинжилгээ, үнэлгээ

Хяналт шинжилгээ, үнэлгээ нь хэрэгжилтэнд анхаарсан уламжлалт аргаас үр дүнд суурилсан шинэ хандлага руу шилжих өөрчлөлт явагдаж байна. Үр дүнд суурилсан хяналт шинжилгээ нь тухайн төсөл, хөтөлбөр, бодлогын үйл явцыг хянах, бий болсон үр нөлөөг харуулахад бодлого боловсруулагчид, шийдвэр гаргагчдад туслах төрийн захиргааны удирдлагын арга хэрэгсэл гэж тодорхойлдог.

Оролцооны хяналт шинжилгээ, үнэлгээ: Аливаа бодлого шийдвэр, хөгжлийн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг хянах ба үнэлэх, хяналт шинжилгээний явц болон үнэлгээний үр дүнг гаргах, засч залруулах арга хэмжээ авах, тодорхойлох, ажлыг оролцогч талуудын оролцоотойгоор хэрэгжүүлэх үйл ажиллагааг хэлнэ.

ОХШҮ-нд оролцоог яагаад чухалчилдаг вэ? Уламжлалт ХШҮ-д талуудын оролцоог чухалчлан авч үздэггүй бол ОХШҮ-ний бүх үе шатанд талуудын оролцоог чухалчилж, бодит үйл хэрэг болгосноороо ОХШҮ болох юм гэдгийг бусад хөгжиж буй улс орнуудын туршлага харуулж байна. Энэ нь төлөвлөлт загварчлалаас эхэлж бүх оролцогч талуудын оролцоонд тулгуурлаж, ОХШҮ-ний бүх үйл явцад тэдний санаа бодлыг тусгаж, тэгш оролцоо, хамтын ажиллагааг хангаж, хамтад нь авч үзэж байж Оролцооны ХШҮ болох юм.

Оролцооны ХШҮ: Талууд хамтын, үр дүнтэй, тэгш эрхтэй байр сууринаас асуудлаа судалж, зохих шийдлийг төлөвлөн хэрэгжүүлж, үнэлэх үйл явц юм.

Оролцооны үнэлгээний хувьд төлөвлөлтөөс эхлээд мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх, тайлагнах, үнэлэлт дүгнэлт өгөх, бодлого шийдвэрийг сайжруулах, нөлөөлөх бүх шатанд талуудын оролцоонд тулгуурлан явагдана.

Шалгуур үзүүлэлт: Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн үе шат бүрд бий болох өөрчлөлтийг хэмжихээр төсөлд заасан тоон болон чанарын үзүүлэлтийг тусгах ойлголт юм /Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, 2020/. Шалгуур үзүүлэлт нь өөрчлөлт гарсан эсэхийг мэдээлэх зорилгоор цуглуулдаг тоон болон чанарын мэдээллийн хэлбэр юм. Тоон шалгуур үзүүлэлтүүд нь хүртээмж, цар хүрээ, түвшин,

өөрчлөлтийн талаарх мэдээллийг өгдөг. Тоон үзүүлэлтүүдийг хэмжихэд илүү хялбар байдаг ч чанарын үзүүлэлтүүд өөрчлөлтийг тайлбарлахад тусалдаг.

Суурь түвшин: Төслийг боловсруулах үеийн шалгуур үзүүлэлтийн тоон болон чанарын үзүүлэлтийг тусгасан ойлголт юм /Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, 2020/. Суурь түвшин нь үйл ажиллагаа эхлүүлэхээс өмнөх үеийн шалгуур үзүүлэлтийн суурь утга бөгөөд ХШҮ хийх эхлэлийн цэг юм. Суурь түвшний мэдээлэл нь одоогийн нөхцөл байдлыг ирээдүйд гарах өөрчлөлттэй харьцуулан хянаж, үнэлдэг тоон болон чанарын мэдээлэл юм.

ОХШҮ хийх үеийн түвшин: Суурь үеийн түвшинг тогтоосноос хойш аливаа үйл ажиллагаа хэрэгжсэний дараагаар ХШҮ хийсний үр дүнд гарч ирж буй түвшинг хэлнэ.

Зорилтот түвшин: Бодлогыг хэрэгжүүлэх явцад болон хэрэгжиж дуусахад хүрэхээр хүлээгдэж байгаа өөрчлөлтийг төсөлд тодорхойлсон шалгуур үзүүлэлтийн тоон болон чанарын үзүүлэлт юм. /Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, 2020/

ОХШҮ-ний үр ашиг: ОХШҮ нь гол оролцогч талуудыг бодлого төлөвлөлтийн үйл явцад оролцуулснаар тэдний ашиг сонирхол, санал бодлыг тусгаж, тухайн бодлогыг амжилттай хэрэгжих нөхцөлийг бүрдүүлдэг.

ОХШҮ-ний гол зарчим бол оролцоо байдаг тул оролцогч талуудыг бүрэн хамруулах хэрэгтэй. Үүнд:

- Тухайн бодлого, төсөл, хөтөлбөрийн үр шимийг хүртэгч бүлэг ОХШҮ-ний ажлын идэвхитэй оролцогчид байна.
- Оролцогч талуудын ялгаатай санаа бодол, үзэл баримтлал, зөвшилцөл дундаас оновчтой шийдвэр гарна.
- Өөрчлөлтийг талууд өөр өөрийн өнцгөөс үнэлж дүгнэснээр бүгдэд суралцах, чадавхжих боломжийг өгнө.
- Олон талын хамтын ажиллагаа нь ЖЭТБХ бодлого, хөтөлбөрийг хугацаандаа хэрэгжих боломжийг хангахад хувь нэмэр оруулна.
- Аливаа асуудал, үйл ажиллагаанд хатуу байр сууринаас хандах бус оролцооны зарчмын үндсэн дээр үйл ажиллагааг аль болох оновчтойгоор хэрэгжүүлэх арга зам хэрэгсэлийг сонгоно.

Хүснэгт 2. Уламжлалт ХШҮ болон ОХШҮ-ний харьцуулалт

Үндсэн асуултууд	Уламжлалт ХШҮ	ОХШҮ
Яагаад?	Дотооддоо хариуцлагыг сайжруулах зорилготой	-Бодлого, төлөвлөлтийг тасралтгүй сайжруулах зорилготой -Бодлогын үр нөлөөг сайжруулна. -Бүх түвшинд талуудын адил тэгш оролцоог хангана.
Юу?	Урьдчилсан тодорхойлсон шалгуур үзүүлэлтээр хэмжинэ	-Нийгэм, хамт олны оролцоотой тодорхойлсон шалгуур үзүүлэлтээр хэмжинэ
Хэн?	Хөндлөнгийн үнэлээч	Оролцогч талуудын оролцоотой ХШҮ хийнэ
Хэнд зориулж?	Санхүүжүүлэгч, захиалагч нарт	Оролцогч талуудад зориулна
Хэзээ?	Бодлого, төлөвлөлт, үйл ажиллагааны явц болон төгсгөлд хийнэ	Бодлогын бүхий л үйл явцад тогтмол хийнэ.
Хэрхэн, яаж	Оролцоот бус, хөндлөнгийн судлаачийн оролцоотойгоор олон хуудас үнэлгээний тайлан боловсруулна.	Асуудлыг тодорхойлохоос эхлээд ХШҮ хийх бүх үйл явцад

Орон нутгийн жендэрийн бодлогод ОХШҮ-ний тогтолцоог нэвтрүүлэх үйл явц:

1. Багаа бүрдүүлэх, гишүүдээ бэлтгэх, үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах
2. Орон нутгийн жендэрийн бодлого, төлөвлөлт, хэрэгжилт дэх ОХШҮ-ний зорилго, зорилт тодорхойлох, бэлтгэл хангах
3. Мэдээлэл цуглуулах
4. Цуглуулсан мэдээлэлд дүн шинжилгээ хийх
5. Тайлан, бодлогын зөвлөмж боловсруулах
6. Үр дүнд тулгуурлан шийдвэр гаргагчдад нөлөөлөх
7. Үр дүнг түгээн дэлгэрүүлэх

1. ҮЕ ШАТ 1: БАГАА БҮРДҮҮЛЭХ, ГИШҮҮДЭЭ БЭЛТГЭХ, ҮЙЛ АЖИЛЛАГААГ ТӨЛӨВЛӨХ, ЗОХИОН БАЙГУУЛАХ


Зорилго: ОХШҮ-ний багийг бүрдүүлэх, гишүүдийн ажил үүргийг хуваарилах бэлтгэл ажлыг ханган, ОХШҮ-ний баримтжуулалт хийх, төсвийг төлөвлөхөд суралцана.

ОНЖДХ-д ОХШҮ хийхээр орон нутгийн үйл ажиллагааны тухайн жилийн төлөвлөгөөнд тусгасан байвал зохино. ОХШҮ-г хийх давтамж, хугацааг орон нутгийн ЖЭТБХ дэд хөтөлбөрийн хяналт шинжилгээ үнэлгээний хэсэгт тусгасан байна.


Алхам 1. ОХШҮ хийх багийг бүрдүүлэх

ОХШҮ хийх баг бүрдүүлэхэд олон талын тэнцвэртэй оролцоог бий болгох нь чухал бөгөөд төр, ИНБ, хандивлагчид, иргэд, төслийн үр шимийг хүртэгч, зорилтот бүлэг зэрэг оролцогч талуудын төлөөллийг багтаадаг. Гэхдээ ОНЖДХ-т төр, ИНБ хамтарч ажиллах бол иргэдийг мэдээлэл өгөгч, үр дүнгийн талаар зөвлөгчийн байр сууринаас ажиллуулахаар төлөвлөнө. ОХШҮ-ний бүхий л үе шатанд оролцогч талууд идэвхитэй оролцогч болж ажиллана.

Зураг 1.1 ОХШҮ-ний багийн бүрэлдэхүүн



Жишээ 1.1 Дорнод аймгийн ОХШҮ багийн бүрэлдэхүүн




ОХШҮ-ний баг бүрдүүлэхэд:

- Орон нутгийн ИНБ чиглүүлж ажиллана
- ОХШҮ-ний багт багийн ахлагч, чиглүүлэгч, ХШҮ-ний мэргэжилтэн, мэдээлэл цуглуулагч, компьютерт мэдээлэл шивэгч гэсэн ажил үүргийг гүйцэтгэх гишүүдээс бүрдэнэ.
- ИНБ-ууд багт ажиллах гишүүнээ санал болгоно.
- Аймгийн ЗДТГ-аас 1-2 мэргэжилтэн /ХШҮ болон Жендэрийн асуудал хариуцсан/ бүрэлдэхүүнд орж ажиллана.
- ОХШҮ баг 5-7 хүний бүрэлдэхүүнтэй байх нь тохиромжтой

ОХШҮ-ний баг нь үйл ажиллагааг төлөвлөх, ОХШҮ-г зохион байгуулах, түүний үр дүнд шаардлагатай арга хэмжээг авах, хэрэгжүүлэх, шийдвэр гаргахдаа харилцан хүндэтгэл, итгэлцэл дээр тулгуурлаж хамтран ажиллана.

Багийн гишүүн бүр ОХШҮ-ний зорилго, ажлын байдал, үнэлгээний шалгуур үзүүлэлт, үүрэг, хариуцлага, үр дүнгийн талаар тодорхой мэдээллээр хангагдсан байх ёстой. /UNICEF, 2008/

Алхам 2. ОХШҮ-ний багийн гишүүдийн ажил үүргийг хуваарилах



ОХШҮ-ний багт чиглүүлэгч чухал үүрэгтэй бөгөөд бүх үе шатанд оролцогч талуудын идэвхитэй оролцоог хангахад анхаарч ажиллана. Чиглүүлэгч талуудтай хэлэлцээ хийх, маргааныг шийдвэрлэх, итгэлцлийг бий болгох, санал бодлоо хуваалцах, зөвлөлдөх хэлбэрээр оролцоог бүрдүүлж дэмжинэ.

Хүснэгт 1.1

№	ОХШҮ-ний хийгдэх ажлууд	Багийн ахлагч	Чиглүүлэгч	ОХШҮ-ний мэргэжилтэн	Мэдээлэл цуглуулагч	Бичиг хэргийн ажилтан
1	ОХШҮ-ний ажлыг зохион байгуулах, бэлтгэл ажлыг хангах	✓	✓			✓
2	Орон нутгийн жендэрийн бодлого төлөвлөлт дэх ОХШҮ	✓	✓	✓		
3	ОХШҮ хийх үеийн мэдээлэл цуглуулах		✓	✓	✓	
4	Цуглуулсан мэдээллийг боловсруулж шинэчлэх	✓	✓	✓		✓
5	ОХШҮ-ний үр дүнг танилцуулах, бодлогын зөвлөмжийг боловсруулах	✓	✓	✓		
6	ОХШҮ-ний үр дүнг шийдвэр гаргагчдад танилцуулах, нөлөөлөх	✓	✓	✓		
7	Олон нийтэд мэдээллийг түгээх	✓	✓	✓	✓	✓


Үе шат бүрээр задлан, багийн гишүүдэд нарийвчлан ОХШҮ-ний ажлыг хуваарилна.

Алхам 3. Багийн гишүүдийг бэлтгэх


ОХШҮ –ний ажлыг зохион байгуулахад багийн гишүүд ОХШҮ хийх аргачлал болон багаар ажиллах мэдлэг, чадвартай байх хэрэгтэй. Тиймээс багийн ахлагч, чиглүүлэгч нь багийн гишүүдэд ОХШҮ хийх аргачлал болон багаар үр дүнтэй ажиллах талаар сургалт зохион байгуулна.

ИНБ-ын зүгээс ОХШҮ-ний ажлыг зохион байгуулахад орон нутгийн төрийн байгууллагын асуудал хариуцсан мэргэжилтнүүд дараах хэлбэрээр дэмжиж туслан хамтран ажиллана.

Үүнд:



Зураг1.2 Багийн гишүүдийн мэдлэг, ур чадвар, харилцаа хандлага



Алхам 4. Үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах

Аливаа төслийн амжилттай хэрэгжих эсэх нь үр дүнтэй зохион байгуулалт, үйл ажиллагааны оновчтой төлөвлөлт, төсвийн зохистой хуваарилалт, тэдгээрийг хэрхэн алдалгүй дагаж мөрдөхөөс шууд хамааралтай байдаг (Мониторингийн гарын авлага, 2007). Иймээс ОХШҮ хийхэд үйл ажиллагааны нарийвчилсан төлөвлөгөө чухал бөгөөд хийх ажлуудыг жагсаан, хариуцах хүнийг томилж, хэзээ хийх хуваарийг гаргасан байна.

Төлөвлөгөөг гаргахдаа цаг хугацааг нарийн тооцож, цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалж үнэлгээний явцад саад учруулж болох эсэхийг харгалзах нь зүйтэй. **Тухайлбал:** Ковид- 19 цар тахал болон тэмдэглэлт үйл явдал, баяр ёслол гэх мэт

Хүснэгт 1.2 ОХШҮ-ний нарийвчилсан төлөвлөгөө хийх загвар:

Зорилт	Үйл ажиллагаа	Гүйцэтгэх ажил	Хариуцах хүн	Хугацаа					
				01	02	03	04	05	06
1	1.1	1.1.1							
		1.1.2							
	1.2	1.2.1							
		1.2.2							
2	2.1	2.1.1							
		2.1.2							
	2.2	2.1.1							
		2.1.2							

Алхам 5. ОХШҮ хийх ажлын төсвийг төлөвлөх

Төсөв: Аливаа төслийн үнэ цэнэ түүнийг хэрэгжүүлэхэд зарцуулсан хөрөнгийн хэмжээтэй харьцуулан дүгнэдэг. Тиймээс төсөл төлөвлөхөд аль болох бага хүч, зардлаар сайн үр дүнд хүрэх зарчмыг баримтлах ёстой. Төслийн санхүүжилтэнд дэмжлэг авах хүсэлт тавихад санхүүжүүлэгч байгууллагууд нь мөнгөний хэмжээг төслөөс гарах үр дүнтэй байнга харьцуулдаг. (Мониторингийн гарын авлага, 2007)

ЖЭТБХ үндэсний хөтөлбөрт хэрэгжүүлэх үйл ажиллагааг тухайн жилийн төлөвлөгөө, төсөвт тусгахаар заасан байдаг. Мөн орон нутгийн ЖЭТБ хангах дэд хөтөлбөрт хөндлөнгийн хяналт үнэлгээ хийх товолсон хугацаа болон зардлыг орон нутгийн төсвөөс гаргуулахаар тусгаж өгсөн байдаг. ОХШҮ хийх төсвийг дараах эх үүсвэрээр бүрдүүлж болно.

Зураг 1.3 ОХШҮ хийх эх үүсвэр



Хүснэгт 1.3 Төсвийн төлөвлөлтийг дараах хүснэгтийг ашиглан хийнэ.

№	Үйл ажиллагаа	нэгж	Тоо, ширхэг	Нэгж үнэ	Нийт үнэ

Багийн нэг гишүүнд төсвийн төлөвлөлт, зарцуулалтыг хариуцуулж, захиалагч байгууллагын шаардлагын дагуу санхүүгийн баримт бүрдүүлнэ.


Мэдээллийг баримтжуулж баталгаажуулах

Мониторингийн мэдээлэл баталгаатай бөгөөд баримтад тулгуурласан байх нь төслийн амжилтад шууд хамааралтай.

Мэдээ баримтын эх хувийг нэгдсэн дүн шинжилгээ хийж мониторингийн үйл ажиллагаа дуусаж, тайлан хэвлэгдсэнээс хойш ч устгаж, үрэгдүүлэхгүй найдвартай хадгалж хамгаалах нь зүйтэй (Хүний эрхийн мониторингийн гарын авлага, Хельсинкийн хүний эрхийн сан).

ОХШҮ-ний баримтжуулалт хийхэд анхаарах зүйл:

ОХШҮ-ний мэдээлэл баталгаатай, баримтанд тулгуурласан байх хэрэгтэй. ОХШҮ хийх асуудлыг сайжруулахад төрийн байгууллагын эрх мэдэлтэн болон албан хаагчдын оролцоо дэмжлэг чухал учраас тэдэнд танилцуулж буй мэдээлэл үнэн зөв, баталгаатай байх нь нэн чухал юм (ОНЖДХ-т ОХШҮ хийх аргачлал, 2020).



2. ҮЕ ШАТ 2: БАТЛАГДСАН ОНЖДХ-ИЙН ХЭРЭГЖИЛТЭНД ХИЙХ ОХШҮ-НИЙ БЭЛТГЭЛ АЖИЛ

Батлагдан хэрэгжиж буй ОНЖДХ-ийн хэрэгжилтэнд ОХШҮ-ний бэлтгэлийг хангахад доорх алхамууд та бүхэнд туслана.

Үүнд:

Алхам 2.1 ОНЖДХ-ийг тодорхойлох

Алхам 2.2 ОХШҮ-ний хамрах хүрээг тогтоох

Алхам 2.3 Ямар зорилгоор ОХШҮ хийх

Алхам 2.4 ОХШҮ-ний зорилго, зорилт, судлах арга зүйн талаар иргэдтэй зөвлөлдөх


Алхам 2.5 ОХШҮ-ээр цуглуулах мэдээллийн хүрээг тогтоох

Алхам 2.1 Юунд ОХШҮ хийх вэ? ОНЖДХ-ийг тодорхойлох нь

ОХШҮ хийх бэлтгэл ажлын хүрээнд ОНЖДХ-ийг сайтар судлах шаардлагатай. Учир нь дэд хөтөлбөр ямар зорилго, зорилт, хүлээгдэж буй үр дүндээ ямар стратегиар хүрэхээр зорьж буй, ямар үйл ажиллагааг хэрхэн, хэний оролцоотойгоор, ямар нөөц ашиглан

хэрэгжүүлэхээр, ямар шалгуур үзүүлэлтээр хяналт шинжилгээ, үнэлгээ хийхээр төлөвлөсөн талаар сайтар ойлгож авснаар ОХШҮ-г хэрэгжүүлэх боломжтой юм.

Дэд хөтөлбөрийн тодорхойлолтыг дараах асуултанд хариулан гурав хүртэлх хуудсанд багтаан бичнэ (ОНЖДХ-т ОХШҮ хийх аргачлал, 2020).




2.1.1 ОНЖДХ нь ямар асуудал руу анхаарсан зорилго, зорилтуудыг

дэвшүүлсэн байна вэ?

Аливаа бодлого нь олон асуудал дундаас хамгийн түрүүнд шийдвэл зохих ёстойг тодорхойлж, түүнд нөлөөлж буй хүчин зүйлс, сөрөг үр дагаварыг тодруулж, асуудлыг шийдвэрлэхийн тулд ямар өөрчлөлт хийх шаардлагатайг тогтоодог. Үүнийг асуудлыг тодорхойлох үйл явц гэдэг бөгөөд энэ нь ОХШҮ-ийн хүрээнд “Нийтлэг үндэслэл, нөхцөл байдлын тодорхойлолт” гэсэн томъёоллоор бичигдсэн байдаг. Энэ үйл явцад эрэгтэй, эмэгтэйчүүдийн ялгаатай хэрэгцээг хангах, бодлогоос эрэгтэй, эмэгтэйчүүдэд ирэх ялгаатай үр нөлөөг урьдчилан тооцоолоход хүйсээр ангилсан баримт, мэдээлэл ихээхэн чухал үүрэгтэй байдаг (ОНЖДХ-т ОХШҮ хийх аргачлал, 2020).

Бүдүүвч 2.1.1 Бодлогын асуудал, зорилго, зорилтын уялдаа холбоо



Аль асуудлыг орхигдуулсан бэ? гэдгийг олж харахын тулд “Нөхцөл байдлын тодорхойлолт”-ыг сайтар судлах шаардлагатай. Бодлогын баримт бичгийн зорилго, зорилтуудаас хамгийн чухал асуудлуудыг харж болно.

Жишээ 2.1.1 Бодлогын асуудал, зорилго, зорилтын уялдаа холбоо

БОДЛОГЫН ЗОРИЛГО: Бүх нийтэд жендэрийн боловсрол олгох, орон нутагт жендэрийн мэдрэмжтэй бодлого, төлөвлөлтийг нэмэгдүүлэх, жендэрийн эрх тэгш байдлыг хангах орон нутгийн чадавхийг бэхжүүлж, “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангах	
ЗОРИЛТУУД	ЧИГЛЭСЭН АСУУДАЛ
Бүх нийтэд жендэрийн боловсрол олгох сургалт, сурталчилгаа, нөлөөллийн цогц арга хэмжээг хэрэгжүүлэх	Хүн амын бүлгүүдийн бүх түвшинд жендэрийн талаарх ойлголт мэдлэг харилцан адилгүй байгаа
Төр, Иргэний нийгмийн байгууллагын түншлэлийн хүрээнд орон нутгийн тогтвортой хөгжлийг дэмжсэн жендэрийн мэдрэмжтэй бодлого, төлөвлөлт, төсөвлөлтийг нэвтрүүлж, хэрэгжүүлэх	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага болон удирдах албан тушаалтнуудыг жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлт, төсөвлөлт, хяналт шинжилгээ хийх тогтолцоо бүрдээгүй, ойлголт, мэдлэг, хандлагын зөрүүтэй байдал их байна.
Аймаг орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжилд жендэрийн эрх тэгш оролцоог хангаж, хөгжлийн үр шимээс эрэгтэй, эмэгтэй хүн тэгш хүртэх боломжийг нэмэгдүүлэх	Эрэгтэйчүүдийн эрүүл мэнд, боловсрол, нийгэм сэтгэл зүйн үйлчилгээг нэмэгдүүлэх, жендэрт суурилсан хүчирхийллийг бууруулахад төрийн байгууллага болон олон нийтийн оролцоог сайжруулах

/Эх сурвалж: Дорнод аймгийн ЖЭТБХ дэд хөтөлбөрт хийсэн ОХШҮ-ний материаллаас/

2.1.2 ОНЖДХ –ийн дэвшүүлсэн асуудлыг хэрхэн шийдвэрлэхээр төлөвлөсөн байна вэ?

Аливаа бодлогын зорилго, зорилтууд нь асуудлыг шийдэх хүрээнд ямар өөрчлөлт, үр дүнг яаж бий болгохоор зорьж байгааг харуулдаг. Дорнод аймгийн Орон нутгийн ЖЭТБХ дэд хөтөлбөрийн жишээн дээр авч үзвэл:

1. Аймаг, сумын төрийн болон хувийн хэвшлийн байгууллагын бодлогын баримт бичиг, дотоод журам жендэрийн мэдрэмжтэй боловсруулагдсан байна.
2. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах орон нутгийн чадавхи сайжирч, жендэрийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх нийгмийн салбарын хөтөлбөрүүдийн хамтын ажиллагаа хангагдсан байна.
3. Бүх нийтэд жендэрийн тухай мэдлэг олгох сургалт, эрүүл дадал хэвшүүлэх үйл ажиллагаа тогтвортой, үр дүнтэй явагддаг болсон байна.
4. Эрэгтэйчүүд судлал, эрэгтэйчүүдэд үзүүлэх цогц үйлчилгээний эхлэл тавигдсан байна.
5. Шийдвэр гаргах болон гүйцэтгэх түвшин дэх хүйсийн тэнцвэртэй байдал хангагдсан байна.
6. Жендэрт суурилсан хүчирхийллийн хохирогчид үзүүлэх чанартай үйлчилгээ бий болсон байна.

Бодлогын зорилт, үр дүнд тодорхой үйл ажиллагаа, арга замаар дамжуулан хүрдэг. Орон нутгийн ЖЭТБХ дэд хөтөлбөрт зорилт тус бүрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэлүүдийг сонгон оруулжээ. Тухайлбал:

Жишээ 2.1.2 /1/ ОНЖДХ-ийн хүрээнд шийдвэрлэхээр төлөвлөсөн ажлууд

ЗОРИЛТУУД	ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА
Зорилт 1:	<ol style="list-style-type: none"> 1. Орон нутгийн төрийн удирдах албан тушаалтан, төрийн албан хаагчид болон аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд зориулсан жендэрийн сургалтын модуль боловсруулж хэрэгжүүлэх; 2. Сургуулийн өмнөх насны хүүхдийн хүчирхийлэлгүй орчинг дэмжих, хүүхэд, өсвөр нас, оюутан залуус, гэр бүлд жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулах; 3. “Аз жаргал төв”, гэр бүлд зөвлөгөө өгөх төвүүдийн сургалт, зөвлөн туслах үйлчилгээнд жендэр судлал, нөхөн үржихүй, эрүүл мэнд, гэр бүл төлөвлөлт, гэр бүл судлал, охид эмэгтэйчүүдийг хүний наймаа, бэлгийн хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх сургалт судалгаа, нөлөөллийн үйл

<p>Бүх нийтэд жендэрийн боловсрол олгох сургалт, сурталчилгаа, нөлөөллийн цогц арга хэмжээг хэрэгжүүлэх</p>	<p>ажиллагааг тусгах; 4. Орон нутгийн төрийн удирдах албан тушаалтан, төрийн албан хаагчид болон аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд зориулсан жендэрийн сургалтуудыг зохион байгуулах, орон нутгийн сургагч багш нарыг чадавхжуулах 5. Хүн амын нийгэм, эдийн засаг, улс төр, соёлын талаар хүйсээр ангилсан статистик мэдээллийн орон нутгийн нэгдсэн санг бүрдүүлж, хэрэглээ болгон ашиглах; 6. Орон нутгийн иргэдийн амьжиргаа, хүний хөгжлийг тодорхойлдог шалгуур үзүүлэлтүүдийн талаарх төрийн байгууллагууд болон олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлж, хэрэглээ болгох ажлуудыг зохион байгуулах, 7. Бүх нийтийн жендэрийн мэдлэгийг нэмэгдүүлэхэд орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллах</p>
<p>Зорилт 2: Төр, Иргэний нийгмийн байгууллагын түншлэлийн хүрээнд орон нутгийн тогтвортой хөгжлийг дэмжсэн жендэрийн мэдрэмжтэй бодлого, төлөвлөлт, төсөвлөлтийг нэвтрүүлж, хэрэгжүүлэх</p>	<p>1. Аймгийн засаг даргын хэрэгжүүлэгч агентлагууд нь салбар бүртээ, зүүн бүс аймаг, орон нутгийн урт, дунд хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, салбарын жендэрийн нэгдсэн бодлого, үндэсний болон орон нутгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй болох 2. Аймаг, сумын хөгжлийн бодлого, байгууллагуудын хөгжлийн төлөвлөгөө, байгууллагын дотоод журам, хүний нөөцийн бодлого, хөтөлбөр, төслийг жендэрийн мэдрэмжтэй үзэл баримтлалыг нэвтрүүлэх, 3. Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг хамгаалах байрны үйл ажиллагааг чанаржуулж, жендэрт суурилсан хүчирхийллийн бүх хэлбэрт өртсөн хохирогчдын тоог эрс бууруулах 4. Аймаг сумын хэмжээнд ажиллах эрүүл мэнд-сэтгэл зүй-эрх зүйн зөвлөгөөг өгөх бүтэц, гэр бүл судлаач, сэтгэл зүйч болон хүний нөөцийг бэлтгэх, гэр бүлийн үнэ цэнэ, хамтын амьдралын утга учир, эцэг эхийн хамтын үүрэг хариуцлагыг таниулах чиглэлээр үр дүнтэй арга хэмжээ зохион байгуулах 5. Орон нутгийн ТББ, Иргэний нийгмийн байгууллагатай хамтран, “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилт, ЖЭТБ-ыг хангах үндэсний хөтөлбөр, аймгийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад зөвлөн туслах, сайн туршлагыг түгээх ажлуудыг зохион байгуулах</p>
<p>Зорилт 3: Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх бодлого, хөтөлбөрт жендэрийн эрх тэгш оролцоог дэмжиж, хөгжлийн үр шимээс эмэгтэй, эрэгтэй хүн тэгш хүртэх боломжийг нэмэгдүүлэх</p>	<p>1. Үндэсний хөтөлбөрийн хүрээнд улсын хэмжээнд эрэгтэйчүүдийн эрүүл мэнд, боловсрол, залуу малчдын нөхцөл байдалд хийгдэх жендэрийн судалгаанд тулгуурлаж, эрэгтэйчүүд болон хөвгүүдэд зориулсан кабинетийг байгуулан эрүүл мэндийн үзлэг оношилгоо сэтгэл зүйн зөвлөгөө болон бусад үйлчилгээг нэмэгдүүлэх 2. Залуу гэр бүл, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, өрх толгойлсон эцэг (эх), амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой иргэн, оюутан залууст чиглэсэн жендэрийн мэдрэмжтэй бодлогыг хэрэгжүүлж үр дүнг тодорхойлох, нийгмийн салбарын хөтөлбөрүүдийн уялдаа холбоог хангаж ажиллах; 3. Уул уурхайн салбар болон улирлын шинжтэй ажил, хөдөлмөр эрхэлж буй иргэдийн эрүүл мэнд, ахуй нөхцөл, гэр бүлийн амьжиргаа, тогтвортой байдалд жендэрийн дүн шинжилгээ хийж, нөхцөл байдлыг сайжруулах зөвлөмжийг оролцогч талуудад өгөх; 4. Төр, хувийн хэвшлийн ажлын байрыг жендэрийн мэдрэмжтэй болгох, эрэгтэй, эмэгтэй ажилтанд адил хэмжээний хөлс олгох, иргэнийг ажилд авахад хүйсээр ялгаварлахгүй байх, ажлын байран дахь хүчирхийллээс сэргийлэх ажлыг Төр, Иргэний нийгмийн байгууллагатай хамтран хэрэгжүүлэх; 5. Хүн амын нийгэм, эдийн засаг, улс төр, соёлын талаар орон нутгийн статистик мэдээллийн нэгдсэн санд хүйсээр ангилсан судалгааны нэр төрөл, тоог нэмэгдүүлж, хөгжлийн бодлого төлөвлөлтөнд хэрэглээ болгох</p>
<p>Эх сурвалж: Жендэрийн эрх тэгш байдлыг хангах Дорнод аймгийн дэд хөтөлбөр</p>	

2.1.3 ОНЖДХ-ийн оролцогчид, үр шим хүртэгчид нь хэн бэ? Хэнд чиглээгүй байна вэ?

ЖЭТБХ дэд хөтөлбөрийн оролцогчид, үр шим хүртэгчид нь хэн болох, оролцогч тал бүрт ямар ашиг сонирхол байгаа болон ямар ашиг сонирхол зөрчилдөх, оролцогч талууд ямар эрх

эдэлж, ямар үүрэг хүлээх, хэрэгжилтэд хэрхэн оролцож, яаж хамтарч ажиллах талаар зураглал гаргана.

Жишээ: 2.1.3 /1/ Дорнод аймгийн ЖЭТБХ дэд хөтөлбөрийн оролцогчид, үр шим хүртэгчид

Хэн	Ашиг сонирхол	Ашиг сонирхлын зөрчил хэнтэй гарч болох	Эрх, үүрэг	Оролцоо, хамтын ажиллагааны чиглэл
Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага	ИТХ-ын дарга, тэргүүлэгч, төлөөлөгч болон хурлын ажлын албаны ажилчдын жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт, төлөвлөлтийн талаарх мэдлэг, хандлагын зөрүүтэй байдлаас шалтгаалан хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хамтран ажиллах сонирхол бага байх, шаардлагатай төсвийг батлахгүй байх	ЗД ЗДТГ ИНБ ААН Иргэд Хэвлэл мэдээллийн байгууллага	ЖЭТБХ дэд хөтөлбөр хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, шаардагдах төсвийг баталж, хэрэгжилтэнд хяналт тавина	Аймгийн Засаг дарга ЗДТГ Агентлагууд Сум ИНБ Иргэд
Засаг дарга /Аймгийн ЖСХ-ны дарга/	ИТХ-д хязгаарлагдмал /зорилтыг хангаж чадахгүй/ төсөв өргөн барих Шийдвэр гаргахад эрх мэдэл, ажил, албан тушаалын байдал, танил талын хүрээгээ ашиглан шууд буюу шууд бусаар нөлөөлөх	Агентлаг, хэлтсийн удирдах ажилтан, мэргэжилтэн ИНБ ААН байгууллага Иргэн	Нэгдсэн удирдлагаар хангах, шийдвэр гаргах, төсөв өргөн мэдүүлэх, зарцуулах,	Аймгийн ИТХ ЖСХороо Агентлагууд Сум, ИНБ, иргэд, хэвлэл мэдээллийн байгууллага
ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэс	Хөтөлбөрийг хэрэгжүүлэх, үнэлэх үйл явцад оролцогчийн аль нэг талд хэт давуу байдал олгох; зөвлөн туслах, чиглүүлэх явцад хувийн ашиг сонирхол илэрхийлэх	Мэргэжилтэн ИНБ Иргэн Хэвлэл мэдээллийн байгууллага	ЖЭТБ хангах дэд хөтөлбөрийн хүрээнд хийгдэх ажлыг төлөвлөх, чиглүүлэх, зөвлөн туслах	Агентлагууд Сум ИНБ Иргэд
Орон нутгийн ИНБ	Ажлын туршлага, мэдээлэлд ойр байж бусдаас давуу байдал эдлэн нийтийн эрх ашигт харшлах шийдвэр гаргахад оролцох;	ЗД ЗДТГ ИНБ ААН байгууллага Иргэн	Дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах чиглэлээр хамтран ажиллах, иргэдийн санал санаачлагыг идэвхжүүлэх, хэрэгжилтэнд хөндлөнгийн хяналт үнэлгээ хийх	Аймгийн ИТХ Аймгийн ЗДТГ Агентлагууд Сум ИНБ ААН байгууллага Иргэд
Аж ахуйн нэгж байгууллага	Хувийн ашиг сонирхолд хөтөлгдөн бизнесийн болон хөрөнгө оруулалтын шинжтэй төсөл хөтөлбөрүүдэд ач холбогдол өгөх, байгууллагын төсөвлөлт, төлөвлөлтийг жендэрийн мэдрэмжтэй болгох шийдвэр гаргахгүй байх, төсөв хөрөнгө зарцуулахгүй байх	ЗДТГ ИНБ Иргэд ажилтан	Нийгмийн хариуцлагын хүрээнд дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, хамтарч ажиллах	Төрийн байгууллага ИНБ Иргэд
Орон нутгийн хэвлэл	Нийгмийн хариуцлагын хүрээнд олон нийтийг соён гэгээрүүлэх, мэдээллийг	Төрийн байгууллага ИНБ Иргэд	Орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллага нь	Аймгийн ИТХ Аймгийн

“ОРОН НУТГИЙН ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ ДЭД ХӨТӨЛБӨРТ “ОРОЛЦООНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ” ХИЙХ АРГАЧЛАЛ” сургалтын гарын авлага

мэдээллийн байгууллага	түгээн дэлгэрүүлэх үүргээ хангалттай биелүүлэхгүй байх;		ЖЭТБ-ыг хангах, жендэрийн ялгаварлан гадуурхалт, жендэрийн хэвшмэл ойлголтыг арилгах чиглэлээр олон нийтийг соён гэгээрүүлэх	ЗДТГ Агентлагууд Сум ИНБ ААН байгууллага Иргэд
Иргэд	Нийтийн эрх ашигт нийцсэн шийдвэр гаргах, соён гэгээрүүлэх үйл явцад оролцохоос татгалзах;	Төрийн байгууллага, Хэвлэл мэдээллийн байгууллага ИНБ	Хэрэгжилтэд оролцох, мэдээлэл авах, санал хүсэлт гаргах	Төр ИНБ-ууд

2.1.4 ОНЖДХ-ийн хэрэгжилтэнд хяналт шинжилгээ, үнэлгээг хэрхэн хийх вэ?

Жишээ 2.1.4 /1/ ОНЖДХ-ийн хэрэгжилтэнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх арга зүйг Дорнод аймгийн жишээн дээр авч үзвэл:

ХШҮ-г хийх гол субъект хэн бэ?	<i>ЗДТГ-ын хяналт үнэлгээ, дотоод аудитын хэлтэс, Төрийн бус байгууллага</i>
ХШҮ-ий шалгуур үзүүлэлтийг тогтоосон байна уу? (тийм бол +, үгүй бол -) +	
Хүлээгдэж буй үр дүн	<ul style="list-style-type: none"> Орон нутгийн төрийн болон хувийн хэвшлийн байгууллагын бодлогын баримт бичиг, дотоод журам жендэрийн мэдрэмжтэй боловсруулагдсан байна. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах орон нутгийн чадавхи сайжирч, жендэрийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх нийгмийн салбарын хөтөлбөрүүдийн хамтын ажиллагаа хангагдсан байна. Бүх нийтэд жендэрийн тухай мэдлэг олгох сургалт, эрүүл дадал хэвшүүлэх үйл ажиллагаа тогтвортой, үр дүнтэй явагддаг болсон байна. Эрэгтэйчүүд судлал, эрэгтэйчүүдэд үзүүлэх цогц үйлчилгээний эхлэл тавигдсан байна. Шийдвэр гаргах болон гүйцэтгэх түвшин дэх хүйсийн тэнцвэртэй байдал хангагдсан байна. Жендэрт суурилсан хүчирхийллийн хохирогчид үзүүлэх чанартай үйлчилгээ бий болсон байна.
Үйл ажиллагааны чиглэл	<i>Сургалт судалгаа, мэдээлэл, нөлөөлөл, сурталчилгаа</i>
Үйл ажиллагаа	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар ахисан түвшний сургалт зохион байгуулах Сургуулийн өмнөх насны хүүхдийн хүчирхийлэлгүй орчинг дэмжих 24 багц цагийн модуль, ЕБС-ийн өсвөр насны хүүхдийн жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх 8 модуль сургалтын хөтөлбөрийг түгээн дэлгэрүүлэх Жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр үр дүнтэй ажилласан аж ахуй нэгж байгууллага, бүлэг, олон нийт, иргэдийн үйл ажиллагааг сурталчлах, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх Эмэгтэйчүүдийг чадваржуулах, манлайллыг нэмэгдүүлэх чиглэлээр эмэгтэйчүүдийн ТББ-уудтай хамтран ажиллах ЖЭТБ-ыг хангах аймгийн дэд хөтөлбөрийг иргэд, олон нийтэд таниулан сурталчилах
Үнэлгээ хийх хугацааг хэрхэн тогтоосон байна вэ?	2 жилд 1 удаа үнэлгээ хийнэ.
ХШҮ хийсэн үү?	Үгүй

2.1.5 ОНЖДХ-ийг хэн хангаж ажиллах вэ?

ОНЖДХ-ийн хэрэгжилтийг хангахад чухал үүрэг бүхий субъектийг тодорхойлно.

Жишээ 2.1.5 /1/ Дорнод аймгийн ЖЭТБХ дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах талууд

ОНЖДХ-ийн хэрэгжилтийн удирдлагыг хангах субъект нь хэн бэ?	ЖЭТБХ аймгийн салбар хороо
ОНЖДХ-ийн хэрэгжилтийг тайлагнахад гол үүрэгтэй субъект хэн бэ?	Аймгийн засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар
Тайлагналыг хүлээн авч, үнэлэлт дүгнэлт өгөх субъект хэн бэ?	Жендэрийн Үндэсний хорооны ажлын алба Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага

2.1.6 ОНЖДХ-ийг хэдий хугацаанд, ямар эх үүсвэрийн хэдий хэмжээний төсөв, хөрөнгө зарцуулж хэрэгжүүлэх вэ?

ОНЖДХ-ийн үйл ажиллагааны төсвийн эх үүсвэр, хэмжээг тодорхойлно. Дорнод аймгийн ЖЭТБХ дэд хөтөлбөрийн жишээн дээр авч үзвэл:

Жишээ 2.1.6 /1/ Дорнод аймгийн ЖЭТБХ дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах арга хэмжээний төсвийн эх үүсвэр, хэмжээг тодорхойлвол:


ОНЖДХ-ийг хэрэгжүүлэх хугацаа, үе шат	Төсвийн эх үүсвэр	Төсвийн хэмжээ
2018-2020 он	Орон нутгийн төсөв	2018 онд 5 сая 2019 онд 3 сая 2020 онд 8 сая

“Жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөр” хэрэгжүүлэх арга хэмжээнд 2018-2020 онд нийт 16 сая төгрөгний төсөв батлагдаж, дэд хөтөлбөрийн үндсэн зорилтуудын хүрээнд доорхи үйл ажиллагаа явуулсан.

Үүнд:

- Хүний эрх, жендэрийн талаарх хууль, тогтоомж үндэсний болон аймгийн дэд хөтөлбөрийн талаар иргэд, олон нийтэд таниулан сурталчлах, уулзалт хэлэлцүүлэг, нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулах - 7 400 000төг
- Жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар сургалт зохион байгуулах /сум албан байгууллагуудад/-1 942 000 төг
- Эмэгтэйчүүдийн шийдвэр гаргах түвшинд ажиллахад бэлтгэх, чадваржуулах, манлайллыг бий болгох чиглэлээр эмэгтэйчүүдийн ТББ-уудтай хамтран ажиллах, сургалт, мэдээллийн ажил зохион байгуулах- 2 431 000төг
- Сургуулийн өмнөх насны хүүхдийн хүчирхийлэлгүй орчинг дэмжих 24 багц цагийн модуль, ЕБС-н өсвөр насны хүүхдийн жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх 8 модульт сургалтын хөтөлбөрийг түгээн дэлгэрүүлэх- 2 527 000төг
- Жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр үр дүнтэй ажилласан аж ахуйн нэгж байгууллага, бүлэг, олон нийт, иргэдийн үйл ажиллагааг сурталчлах, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, урамшуулах -800 000төг
- “Аз жаргал”-ын индексийн талаарх иргэдийн ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх зорилгоор мэдээлэл сурталчилгааны ажил зохион байгуулах -500 000 төг
- Эрэгтэйчүүдийн дундаж наслалт, хорт хавдар, нас баралтад нөлөөлж буй хүчин зүйлс, нийгэм, соёл, эдийн засгийн идэвхи оролцоо, тэднийг үнэлэх үнэлэмж, хандлага, гэр бүлийн хүрээнд тулгамдаж буй асуудалд судалгаа хийх -400 000 төг

График 2.1.6 /1/ Жендэрийн төсвийн задаргаа (2018-2020 он)



2.1.7 ОНЖДХ-ийг хэрэгжүүлэхээр хэдий хугацаанд ямар, ямар үйл ажиллагааг төлөвлөсөн байна вэ?

ОНЖДХ-ийн үйл ажиллагааны чиглэлийг тодорхой үйл ажиллагаануудаар дамжуулан хэрэгжүүлнэ. Дорнод аймгийн жишээн дээр авч үзвэл, ЖЭТБХ дэд хөтөлбөрийг 2 үе шаттайгаар зорилт бүрийг хэд хэдэн үйл ажиллагааны чиглэлээр хэрэгжүүлэх ажлуудыг төлөвлөн гаргасан.

Эхний үе шат: Бүх нийтэд жендэр болон жендэрийн эрх тэгш байдлын талаар анхан шатны ойлголт мэдлэг олгох, Үүнд: оюутан сурагчид болон цэцэрлэгийн насны хүүхдүүдийг түлхүү хамруулсан.

2 дахь үе шат: Жендэрийн талаар ахисан түвшний сургалт мэдээллийн ажиллагаа зохион байгуулах, Үүнд: Төрийн байгууллагын удирдах албан тушаалтан болон мэргэжилтэн нарыг хамруулсан.

Хүснэгт 2.1.7 /1/ Зорилт, үйл ажиллагааны чиглэл, хэрэгжүүлэх үйл ажиллагаа, түүний шалгуур үзүүлэлтийг хоёр үе шатны зураглал

Зорилт	Үйл ажиллагааны чиглэл	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа
Зорилт 1: Бүх нийтэд жендэрийн боловсрол олгох сургалт, нөлөөллийн цогц арга хэмжээг хэрэгжүүлэх	Сургалт, мэдээлэл	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар ахисан түвшний сургалт зохион байгуулах Сургуулийн өмнөх насны хүүхдийн хүчирхийлэлгүй орчинг дэмжих 24 багц цагийн модуль, ЕБС-ийн өсвөр насны хүүхдийн жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх 8 модульт сургалтын хөтөлбөрийг түгээн дэлгэрүүлэх Жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр үр дүнтэй ажилласан аж ахуй нэгж байгууллага, бүлэг, олон нийт, иргэдийн үйл ажиллагааг сурталчлах, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх
	Сургалт, мэдээлэл	
	Сурталчилгаа	
Зорилт 2: Төр, Иргэний нийгмийн байгууллагын түншлэлийн хүрээнд орон нутгийн тогтвортой хөгжлийг дэмжсэн жендэрийн мэдрэмжтэй бодлого, төлөвлөлтийг нэвтрүүлж, хэрэгжүүлэх	Сургалт, мэдээлэл, бодлого төлөвлөлт	Орон нутгийн удирдах ажилтан болон төрийн албан хаагчдад жендэрийн төлөвлөлт, төсөвлөлт, хяналт шинжилгээний чиглэлээр Мерит төсөлтэй хамтран сургалт мэдээллийн ажиллагаа зохион байгуулах, хэрэгжилтийг ханган ажиллах

<p>Зорилт 3: Аймаг, орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжилд жендэрийн эрх тэгш оролцоог хангаж, хөгжлийн үр шимээс эрэгтэй, эмэгтэй хүн тэгш хүртэх боломжийг нэмэгдүүлэх</p>	<p>Сургалт мэдээлэл, шинжилгээ, судалгаа</p>	<p>Эмэгтэйчүүдийг чадваржуулах, манлайллыг нэмэгдүүлэх чиглэлээр эмэгтэйчүүдийн ТББ-уудтай хамтран ажиллах</p>
---	--	--

2.1.8 ОНЖДХ-ийг батлагдсанаас хойш ямар, ямар үйл ажиллагааг хэрэгжүүлж байна вэ?

ОНЖДХ батлагдаж хэрэгжсэнээс хойш хэдий хугацаанд ямар, ямар үйл ажиллагааг хэрэгжүүлж байгаа бүрэн зургийг гаргаж тодорхойлноор ОХШҮ-г юунд хийх вэ гэдгээ тогтооно.

Жишээ 2.1.8 /1/ Дорнод аймгийн ЖЭТБХ дэд хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн үйл ажиллагаа

Зорилт	Үйл ажиллагааны чиглэл	Хэрэгжүүлсэн үйл ажиллагаа
<p>Зорилт 1: Бүх нийтэд жендэрийн боловсрол олгох сургалт, нөлөөллийн цогц арга хэмжээг хэрэгжүүлэх</p>	<p>Сургалт, мэдээлэл, хууль сурталчилах, нөлөөллийн үйл ажиллагаа</p>	<p>Дэд хөтөлбөрийн зорилтуудыг хангах ажлын хүрээнд 48 удаагийн сургалт үйл ажиллагаагаар 6349 хүүхэд, насанд хүрэгчдийг хамруулан жендэрийн боловсрол олгох сургалт нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулан ажилласан ба 180 хүнд сэтгэл зүйн болоод хууль эрх зүйн зөвлөгөөг өгч ажилласан байна.</p> <p>Орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагаар дамжуулан иргэдэд жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 4 удаагийн давтамжтайгаар мэдээлэл, сурталчилгаа хийсэн. Бүх нийтэд “Бага насны хүүхдийг хүчирхийллээс ангид байх орчинг дэмжих” төслийн хүрээнд орон нутгийн телевизээр цуврал “Аюулын дохио - Авралын дүрэм” хүүхэлдэйн киног цувралаар хүргэж байна.</p>
<p>Зорилт 2: Төр, Иргэний нийгмийн байгууллагын түншлэлийн хүрээнд орон нутгийн тогтвортой хөгжлийг дэмжсэн жендэрийн мэдрэмжтэй бодлого, төлөвлөлтийг нэвтрүүлж, хэрэгжүүлэх</p>	<p>Бодлого төлөвлөлт, үйлчилгээний чанарыг сайжруулах, зөвлөн туслах үйлчилгээг хөгжүүлэх, сайн туршлагыг түгээх</p>	<p>Зорилтыг хангах хүрээнд “Сэтгэл зүйн зөвлөгөө” өгөх төвөөр анхан шатны зөвлөгөөг 800 хүнд, сэтгэл зүйн оношлогоо үйлчилгээг 10 хүнд, гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг хамгаалах “Нэг цэг”-ийн үйлчилгээний төвөөр 34 хүнд хамгааллын үйлчилгээ үзүүлэн, шүүхийн журмаар гэр бүлээ цуцлуулж буй 3 өрхийн 9 хүүхдэд асран хамгаалагч тогтооход шинжээчийн дүгнэлтийг гарган ажиллалаа.</p> <p>Нийт 15 удаагийн сургалтаар гэр бүлд зөвлөгөө үзүүлэх чиг үүрэг бүхий 4488 үүрэг хүлээгчдийг бэлтгэн сэтгэл зүйн чиглэлээр зохион байгуулагдсан сургалт зөвлөгөө өгөх хүний нөөцийг чадавхжуулах зорилгоор 2608 хүнд сэтгэл зүйн сургалтуудыг зохион байгуулаад байна.</p> <p>Жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлтийг бий болгох зорилгоор байгууллагын ахмадын зөвлөлийг хүйсийн хувьд тэнцвэртэйгээр сонгон ажиллаж байгаагаас гадна “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах” дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах төлөвлөгөөг боловсруулан байгууллагын үйл ажиллагааны төлөвлөлтөд тусган хэрэгжүүлж ажиллаж байна.</p>
<p>Зорилт 3: Аймаг, орон нутгийн нийгэм, эдийн засгийн</p>	<p>Нийгмийн салбарын хөтөлбөрүүдийн уялдаа холбоог хангах, жендэрийн мэдрэмжтэй төр, хувийн хэвшлийн</p>	<p>Аймгийн хэмжээнд 14-19 насны эрэгтэй хүүхдүүдийг эрүүл мэндийн үзлэгт бүрэн хамруулсан бөгөөд тус газрын дэргэдэх “Аз жаргал төв”-ийн үйл ажиллагаагаар дамжуулан 43 хөвгүүнийг эрүүл мэндийн үзлэгт хамруулан бэлгийн эрүүл мэндийн боловсрол олгох сургалтанд, залуу ээжүүдийг дэмжих клубуудын үйл ажиллагаанд хамруулах</p>

хөгжилд жендэрийн эрх тэгш оролцоог хангаж, хөгжлийн үр шимээс эрэгтэй, эмэгтэй хүн тэгш хүртэх боломжийг нэмэгдүүлэх	ажлын байрыг нэмэгдүүлэх, орон нутгийн статистик мэдээллийн нэгдсэн санд хүйсээр ангилсан мэдээллийн тоог нэмэгдүүлэх, сургалт мэдээлэл	зэргээр ажиллаж байна. Мөн орон нутгийн хэмжээнд хийгдсэн судлагаа, хүн амын статистик мэдээлэлд дүн шинжилгээ хийж байгууллагын бодлого төлөвлөлтөд ашиглан ажиллаж байна. Нэгдсэн Үндэстний байгууллага, Хөдөлмөр Нийгмийн хамгааллын яамны дэмжлэгтэйгээр Олон улсын жишигт нийцсэн Нэг цэгийн үйлчилгээний төвтэй болсноор 2018 онд 25, 2019 онд 59 хүүхэд, насанд хүрэгчдийн аюулгүй байдлыг хамгаалж, хамгааллын үйлчилгээ үзүүлж, зөрчигдсөн эрхийг ханган ажиллаж байна.
---	---	--

2.1.9 ОНЖДХ-т ОХШҮ хийхэд чиглэх асуудал, анхаарал татаж буй асуудал.

ОНЖДХ-т ОХШҮ хийхэд чиглэх асуудал, анхаарал татаж буй асуудлыг гаргаж ирэхийн тулд доорх асуултуудад хязгаарлахгүйгээр олон талаас нь нягтлан харна. Үүнд:

- Дэвшигдэж буй асуудалд хөтөлбөрийн зорилтууд чиглэсэн байна уу? Ингэхдээ хүйсээр ангилсан мэдээллийг нотолгоо болгон хэр зэрэг ашигласан байна вэ?
- Төлөвлөсөн үйл ажиллагаа бүр хугацаандаа хэрэгжсэн байна уу? Ямар үйл ажиллагаа хугацаандаа сайн хэрэгжиж, ямар үйл ажиллагаа хэрэгжээгүй байна вэ? Яагаад?
- Оролцогч талууд бодлогын үйл ажиллагаанд хэрхэн оролцож байна вэ? Хэний оролцоо хангагдаад, хэнийх нь орхигдсон байна вэ? Яагаад?
- Төлөвлөсөн үйл ажиллагаа хэрэгжүүлэх цаг хугацаа хэр оновчтой байна вэ? Аль нь цаг хугацаандаа хэрэгжээд аль нь хэрэгжиж чадахгүй үлдсэн бэ? Яагаад?
- Төлөвлөсөн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд төсөв, хөрөнгө хэр зарцуулсан байна вэ? Тэр нь хангалттай байна уу? Ямар үйл ажиллагааг санхүүжүүлээд алийг нь орхигдуулсан байна вэ? Яагаад?
- Бодлогын хэрэгжилтэнд хяналт шинжилгээ хийсэн үү? Хийсэн бол ямар дүгнэлт гарсан вэ? Хяналт шинжилгээг хэн хийсэн бэ? Оролцогч талуудыг аль хэр оролцуулсан бэ? Хяналт шинжилгээний үр дүнд ямар өөрчлөлт гарсан вэ? Хяналт шинжилгээ шалгуур үзүүлэлтэйгээ хэр тохирч байна вэ? Хүйсээр ангилсан мэдээллийг хэр зэрэг ашигласан бэ?

Дээрх дүн шинжилгээнд тулгуурлан Дорнод аймгийн ЖЭТБХ дэд хөтөлбөрт ОХШҮ хийхээр чиглэсэн асуудлыг үзүүлвэл:

Жишээ 2.1.9 /1/ ОХШҮ-ний судлах асуудал

ЖЭТБХ дэд хөтөлбөрийн үндсэн гурван зорилтын хүрээнд 2018-2020 оны хооронд нийт 15 үйл ажиллагааны хэрэгжилтийг хялбаршуулж харвал:

- Зорилт 1-ийн хүрээнд 5 үйл ажиллагаа тусгагдснаас бага насны хүүхдүүд, ЕБС-ийн сурагчид, оюутан залуус болон төрийн удирдах болон гүйцэтгэх албан тушаалтныг чадвахжуулах сургалт, мэдээлэл, хууль сурталчилах, нөлөөллийн үйл ажиллагаануудыг олон улсын төсөл хөтөлбөр болон орон нутгийн төсвийн санхүүжилтээр хийсэн байна. Харин ААН байгууллага, иргэдэд зориулсан жендэрийн мэдлэг олгох сургалт, мэдээллийн ажиллагаа тодорхой хугацаанд, давтамжтай хийгдээгүй, үүнд зарцуулах төсөв нь байхгүй байна.
- Зорилт 2-ын хүрээнд 5 үйл ажиллагаа тусгагдснаас жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлт, төсөвлөлтийг нэвтрүүлэх, нийгмийн төсөл, хөтөлбөрийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхэд Канадын Меррит төслийн техник арга зүйн тусламж, дэмжлэгийг авч хамтран ажиллаж байна. Төр, ИНБ-уудын хамтын ажиллагааны хүрээнд нийгмийн шинжтэй хөтөлбөрүүдийн жендэрийн мэдрэмжтэй төлөвлөлтийн

байдалд шинжилгээ хийж ажилласан байна. “Хохирогчийг хамгаалах байр”-д хохирогчийг түр болон урт хугацаагаар байршуулж, нийгмийн ажлын болон хууль, эрх зүй, сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлж цаашид эрсдлээс өөрийгөө урьдчилан сэргийлэх чадвар ойлголт нэмэгдсэн эерэг өөрчлөлтүүдэд анхаарч ажилласан байна. НҮБ-ийн хүн амын сангийн дэмжлэгтэйгээр орчин нөхцөл, үйлчилгээг сайжруулсан байна. Тухайлбал хохирогчийг хамгаалах байр нь тусгай гал тогооны өрөөтэй болсон, ариун цэврийн өрөөний нөхцлийг сайжруулсан, хүүхдийн тоглоомын талбайг шинээр байгуулсан, аюулгүй байдлыг ханган блокон өндөр хашаатай болсон, сэтгэл зүйчийн орон тоог нэмж ажиллуулсан байна. Мөн 2018-2020 онд орон нутгийн төсвөөс нийт 30.5 сая төгрөгний санхүүжилт өгч хамгаалах байрны үйлчилгээний тогтвортой байдлыг ханган ажилласан байна.

Харин хөтөлбөрт туссан жендэрт суурилсан хүчирхийллийн бүх хэлбэрт өртсөн хохирогчдын тоог эрс бууруулах үйл ажиллагааг хэмжиж, үнэлсэн байдал хангалтгүй байна.

- **Зорилт 3-ын хүрээнд 5 үйл ажиллагаа тусгагдснаас үндэсний болон олон улсын байгууллагуудын дэмжлэгтэйгээр төсөл хөтөлбөр хэрэгжсний үр дүнд гэр бүл, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, оюутан залуусын хөгжил, нийгмийн асуудлыг хангах дэд хөтөлбөрүүд нь жендэрийн мэдрэмжтэй төлөвлөгдсөн байна.** Хүн амын нийгэм, эдийн засаг, улс төр, соёлын талаар орон нутгийн статистик мэдээллийн нэгдсэн санд хүйсээр ангилсан судалгааны нэр төрөл, тоо нь 2017 онд 15 байсан бол 2019 онд 20 болж өссөн байна. Аймгийн ЭМГазар нь “Өсвөр үе, залуучуудын эрүүл мэндийг дэмжих” төслийн үйл ажиллагааг эхлүүлэн төслийн хүрээнд аймгийн ерөнхий боловсролын сургуулийн 14-17 насны хөвгүүдийг төрөлжсөн мэргэжлийн эмч нарын эрт илрүүлэг үзлэг, шинжилгээнд хамруулах үзлэг хийж 14-17 насны 1598 хөвгүүдийг хамруулан ажиллаж байна. Энэхүү үзлэг, шинжилгээнд шаардагдах эмнэлгийн тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас 30 сая төгрөгөөр санхүүжүүлсэн байна. Харин эрэгтэйчүүдийн тусгай кабинетийн үйл ажиллагаа тогтвортой биш, урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоо хангалтгүй байгаагаас эрэгтэйчүүд эрүүл мэндийн байдал хүндэрсэн үедээ эмнэлэгт хандаж байна. Дэд хөтөлбөрт туссан “Эрэгтэйчүүд судлалыг эхлүүлэх, эрэгтэйчүүдэд хүргэх цогц үйлчилгээг бий болгох” гэсэн үйл ажиллагааны биелэлт, баримт нотолгоо хангалтгүй байна.

Дээрх дүн шинжилгээнд тулгуурлан дараах 2 асуудлыг ОХШҮ-ний судлах асуудал болгон авч үзэж байна. Үүнд:

- **Асуулт 1.** Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн ажил олгогч болон ажиллагсдын ЖЭТБ-ын талаарх ойлголт мэдлэг болон жендэрийн мэдрэмжтэй төлөвлөлт, ажлын байрны нөхцөл байдлыг тодорхойлох
- **Асуулт 2.** Эрэгтэйчүүд судлал, эрэгтэйчүүдэд үзүүлэх цогц үйлчилгээний өнөөдрийн түвшинг тодорхойлох.

Алхам 2: ОХШҮ-ний хамрах хүрээг тогтоох

ОНЖДХ-ийн бүхий л зорилт, үйл ажиллагааны чиглэлд ОХШҮ –г хийж гүйцэтгэнэ. Гэхдээ сонирхож буй асуултын хүрээнд хязгаарлал тогтоон оролцооны үнэлгээг хийж болно. **Тухайлбал:** Дорнод аймгийн ЖЭТБХ дэд хөтөлбөрийн хүрээнд авсан анхаарал татсан 2 асуудлын хувьд оролцооны үнэлгээний хамрах хүрээг тогтоосон.

Жишээ 2.2 Оролцооны үнэлгээний хамрах хүрээ

Асуулт	Хариулт	Яагаад
ОНЖДХ-ийн үйл ажиллагааны аль чиглэлд ОХШҮ-г гүйцэтгэхийг хүсэж байна вэ?	<p>1. ЖЭТБ-ыг хангах, жендэрийн ялгаварлан гадуурхалт, хүчирхийлийг тэвчих, жендэрийн хэвшмэл ойлголт, хандлагыг арилгах чиглэлд</p> <p>2. Эрэгтэй эмэгтэй хүмүүсийн нийгмийн үйлчилгээг тэгш, хүртээмжтэйгээр хүртэх боломжийг нэмэгдүүлэх чиглэлд</p>	<p>Орон нутгийн ИНБ-уудын зүгээс 2019 онд хувийн компани эзэмшил газарт түрээсээр хөдөлмөр эрхэлж буй 200 иргэдээс санамсаргүй түүврийн аргаар авсан асуулга судалгаа, 65 иргэдтэй хийсэн ганцаарчилсан ярилцлага, 15 хүнтэй хийсэн фокус бүлгийн ярилцлагад оролцогчдын зүгээс эрүүл ахуй, ажлын байрны шаардлага хангаагүй, стандартын бус барилга байгууламжинд үйл ажиллагаа явуулах, нөхцөл байдлаа сайжруулах талаар тавьсан саналыг хүлээж авдаггүй, бүдүүлэг үг яриагаар доромжлох, түрээслэгч нарын зүгээс шаардлага тавихад хувийн өмчийг хураан авчлангуу чөлөөлүүлэх зэрэг зөрчлүүд байгаа талаар санал бодлоо хуваалцсан.</p> <p>ЛЭОС-ийн аймгийн салбараас 2018 онд “Ажлын байран дахь хүний эрхийн зөрчил” сэдвээр авсан асуулга судалгаанд Дорнод аймгийн төвийн 9 сургууль, 5 цэцэрлэгийн 210 багш ажилтан хамрагдсан. санал асуулганд оролцсон хүмүүсийн 51 хувь нь ямар нэгэн байдлаар ажлын байрны барамтанд өртдөг гэсэн бол 64,5 хувь нь байгууллага дээрээ ажилтан албан хаагчдын сэтгэл зүйд сөрөг нөлөөтэй, удирдах ажилтны арга барилтай холбоотой дарамт байдаг үүнд илүү өртдөг гэж хариулжээ. мөн байгууллагын ажилтан нарын эрх зөрчигдөх асуудлыг хүний эрхэд хамаарах асуудал гэж 62,2 хувь нь үзжээ. Иймээс төр, хувийн хэвшлийн байгууллагуудад ажлын байран дахь зөрчлийг арилгуулах, цаашдын хэрэгцээг бодитойгоор тодорхойлох хэрэгтэй юм.</p> <p>2017 онд ЖЭТБХ дэд хөтөлбөр боловсруулах ажлын хүрээнд орон нутгийн ИНБ-уудаас хийсэн судалгааны ажлын тайлангаас харахад: Дорнод аймгийн хувьд 2012 онд эрэгтэй хүний дундаж нас 61.87 байсан бол 2016 онд 64.73 болж 2.86 насаар, 2012 онд эмэгтэй хүний дундаж нас 70 нас байсан бол 2016 онд 72.95 болж 2.95 насаар тус тус нэмэгдсэн байна. 2016 оны байдлаар эмэгтэйчүүдийн дундаж наслалт улсын дунджаас 2.15 насаар бага, эрэгтэйчүүдийн дундаж нас 0.85 насаар бага байна. 2017 оны байдлаар гэмт хэрэгт холбогдсон хүний тоо 389 байгаагийн 339 /87.2%/ нь эрэгтэйчүүд, 50 /12.8%/ нь эмэгтэйчүүд эзэлж байна. Гэмт хэрэгт өртөж хохирсон хүүхдийн тоо 37 байгаагаас эмэгтэй 13 /бэлгийн хүчирхийлэл-7/, эрэгтэй-24 байсан бол гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн тоо 32, үүнээс 28 нь эрэгтэй, 4 нь эмэгтэй байна. Мөн эрүүлжүүлэгдэж саатуулагдсан хүний тоо 3809 байгаагийн 3543 нь эрэгтэй, 266 нь эмэгтэй байна Шинээр хорт хавдраар өвчлөгчид 2016 онд 165 тохиолдол байгаагийн 101 нь эрэгтэй [84.7%], хорт хавдраар нас барагчид 160 тохиолдол байгаа нь нийт нас баралтын 28.4 хувийг, хорт хавдраар нас барсан хүний 61.8 хувь нь эрэгтэйчүүдийн нас баралт эзэлж байна. 10000 хүн амд ногдох халдварт өвчнөөр өвчлөгчид 227.4 байгаа нь нь улсын дундажтай харьцуулахад 104,1-ээр зөрүүтэй байна Энэхүү тоо баримтаас харахад эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн асуудал тулгамдсан асуудлуудын нэг болсон.</p>
Тус үйл ажиллагааны чиглэлийн хүрээнд ямар асуултыг сонирхож байна вэ?	1. Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн ажил олгогч болон ажиллагсдын ЖЭТБ-ын талаарх ойлголт мэдлэг болон жендэрийн	Хувийн хэвшлийн байгууллагын ажил олгогч нар бизнесийн ашиг орлого олохыг чухалчилж, ажил хөдөлмөр эрхэлж буй ажилтан нарын ажиллах нөхцөл, эрүүл мэндийн асуудлыг хайхарч үзэхгүй байна. Иймээс тэдний жендэрийн талаарх ойлголт мэдлэг,

	<p>мэдрэмжтэй төлөвлөлт, төсөвлөлт болон ажлын байрны нөхцлийг тодорхойлох</p> <p>2. Эрэгтэйчүүд судлал, эрэгтэйчүүдэд үзүүлэх цогц үйлчилгээний өнөөгийн байдлыг тодорхойлж гаргах</p>	<p>хандлага, ямар байгаа талаар болон жендэрийн мэдрэмжтэй төлөвлөлт, төсөвлөлтийг ажлын төлөвлөгөөндөө тусгадаг эсэх талаар мэдээлэл авах шаардлагатай байна.</p> <p>Эрэгтэйчүүдийн ихэнх хувь нь эмнэлэгийн анхан шатны эмчилгээ үйлчилгээ авч чадахгүй, өвчнөө хүндрүүлж ирснээс болж чимээгүйгээр эрт нас баралтанд өртөж байгаа нь нууц биш юм. Эрэгтэйчүүд хүнд хүчир ажил эрхлэх, стресс болон сэтгэл гутралд орох, архи тамхи хэтрүүлэн хэрэглэх, хоол хүнсний зохисгүй хэрэглээ, хөдөлгөөний хомсдолд орох, өвчин эмгэгээ нуух, үзлэг шинжилгээнд үл хамрагдах зэрэг олон хүчин зүйлүүдээс шалтгаалж өвчилж байна. Эрэгтэйчүүдийн хөгжлийн талаар төрийн нэгдсэн бодлого байхгүй, эрэгтэйчүүд өөрийнхөө эрхийн төлөө тэмцэх мэдлэг, идэвхи санаачлага байхгүй, хувь заяатайгаа эвлэрэх хандлага давамгайлсан зэргээс болж эрэгтэйчүүдийн үнэлэмж жилээс жилд буурч биеийн эрүүл мэнд болон оюун санааны хөгжил доройтож байна</p> <p>Ажил хөдөлмөр байхгүй, архи тамхи хэтрүүлэн хэрэглэдэг, өвчин эмгэгтэй, гэмт хэрэг зөрчилд холбогдсон, гэр бүл нь салж сарнисан эрчүүд олширч байгаа нь өнөөгийн нийгмийн эмгэнэл болж байна. “Нөхөн үржихүйн асуудал” гэдэг сэдэвт эмэгтэйчүүдийг илүү анхаарч эрэгтэйчүүдийн нөхөн үржихүйн эрүүл мэнд гэдэг үгийг сонсож хэвшээгүй, энэ талаар зөвлөгөө мэдээлэл өгөх, үзлэг шинжилгээ хийх нөхцөл бүрдээгүй, эрэгтэйчүүдийн эмч, эмнэлэг, кабинет орон нутагт дутагдалтай байна. Мөн эрэгтэйчүүдийн өвчлөлд зүрх судасны эмгэгүүд, элэг, уушиг, хавдар, осол гэмтэл илүү их байна</p> <p>Иймээс эрэгтэй эмэгтэй хүмүүсийн тэгш боломж, эрхийг хангахын тулд тэдний хэрэгцээ шаардлагыг харгалзан үзэж, эрэгтэйчүүд судлалыг хөгжүүлэх, жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлт, төсвийг цаг алдалгүй хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай байна.</p>
--	---	--

Алхам 2.3 Ямар зорилгоор ОХШҮ хийх вэ?

Хяналт шинжилгээ, үнэлгээ нь өөр хоорондоо уялдаатай ч ялгаатай чиг үүрэг, зорилготой. Бүх үйл явцад ХШҮ хийхэд шалгуур үзүүлэлтүүд хэрэгтэй байдаг. Хяналт шинжилгээ нь хүссэн өөрчлөлт гарч байна уу, үгүй юу гэдэгт хяналт тавих үйл ажиллагаа юм. Өөрөөр хэлбэл хөтөлбөрийн амжилттай хэрэгжсэн хийгээд сайжруулах шаардлагатай хэсгүүдийн талаар шинэчилсэн мэдээллээр хангах үүднээс тогтолцооны орц, үйл ажиллагаа, гарц дахь ахиц өөрчлөлтөд хяналт шинжилгээ хийдэг. (Бүдүүвч 3.1 –ийг харна уу)

Бүдүүвч 2.3.1



Хүснэгт 2.3.1 Жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөрийн зорилт, үйл ажиллагааны хэрэгжилт (2019 он)

№	Шалгуур үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин
1	Бүх нийтийн жендэрийн ойлголтыг нэмэгдүүлэх сургалт, нөлөөллийн ажил	тоо	3	6	41
2	Жендэрийн орон нутгийн сургагч багш	тоо	157	257	180
3	Жендэрийн сургалтанд хамрагдсан удирдах ажилтан, төрийн албан хаагч	хувь	-	УА-70 ТАХ-150	УА-53 ТАХ-180
4	Орон нутгийн түвшинд хүйсээр ангилсан статистик үзүүлэлтүүд	тоо	15	25	20
5	Хөдөлмөрийн мөлжлөг ялгаварлан гадуурхалтаас заалтыг дотоод журамдаа тусгасан байгууллага, аж ахуйн нэгж	хувь		20	15
6	Орон нутгийн жендэрийн нөхцөл байдалд ТББ-аас хийсэн судалгаа, тайлан	тоо	1	1	1
7	Жендэрийн мэдрэмжтэй, салбарын хүний нөөцийн бодлого төлөвлөлт	тоо	-	2	4
8	Эрэгтэйчүүдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлдэг кабинет	тоо	-	1	-
9	Шийдвэр гаргах түвшинд ажиллаж буй эмэгтэйчүүд	хувь	22,8	-	
10	Хамгаалах байрны үйлчилгээг гэрээлэн гүйцэтгэсэн байгууллага	тоо	-	1	
11	Дэд хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнд суурилсан явцын болон эцсийн үнэлгээ, тайлан	тоо	-	1	1

Дээрх баримтуудад үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

Асуулт	Зорилт
Төлөвлөсөн болон бодит гүйцэтгэл хоорондын зөрүү их байгаа нь юунаас шалтгаалж байна вэ? Ямар өөрчлөлт шаардлагатай байна вэ?	<ul style="list-style-type: none"> Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийг нэмэгдүүлэх Хөтөлбөрийн оролцогч талуудын хамтын ажиллагаа, салбар дундын уялдаа холбоог сайжруулах Хөндлөнгийн үнэлгээг хэвшүүлэх Салбарын жендэрийн бодлогыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх
Тусгагдсан асуудал, түүнд хүргэсэн шалтгаанд үйл ажиллагаа үр дүнтэй чиглэж чадаж байна уу?	<ul style="list-style-type: none"> Дэд хөтөлбөрийн зорилтуудыг жигд хэрэгжүүлэхэд шаардлагатай төсвийг төлөвлөх, зарцуулах Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг талуудын оролцоотойгоор боловсруулах, хэрэгжүүлэх Үйл ажиллагаа, үйлчилгээний олон талт байдлыг хангах
Сонгосон загвар, арга үр дүнтэй байж чадаж байна уу? Яагаад?	<ul style="list-style-type: none"> Хөтөлбөрийн зорилтуудыг хангахад чиглэсэн сургалт, мэдээлэл, сурталчилгааны аргуудыг өргөжүүлэх, бусад аргуудыг түгээмэл ашиглах Бусдын сайн туршлагаас суралцах, түгээн дэлгэрүүлэх
Төлөвлөлт ба хэрэгжилт хооронд ямар уялдаа байна вэ?	<ul style="list-style-type: none"> Гүйцэтгэлийг төлөвлөлтэй хэрхэн уялдаж байгаад хяналт хийх Судалгаанд суурилсан төлөвлөлт хийх
Үйл ажиллагааг хэрэгжихэд орц буюу нөөцөөс юу нь хамгийн чухал үүрэг гүйцэтгэсэн байна вэ? Эсвэл юу нь хамгийн гол бэрхшээл болсон бэ?	<ul style="list-style-type: none"> Санхүүгийн хязгаарлагдмал байдалд нийцсэн үйл ажиллагааг оновчтой төлөвлөх, амжилттай хэрэгжүүлэх Хүний нөөцийн давуу байдалд тулгуурлан нийгмийн салбарын хөтөлбөрүүдийг жендэрийн мэдрэмжтэй болгож сайжруулах Материаллаг нөөцийг нэмэгдүүлж, хангалтгүй хэрэгжсэн үзүүлэлтийг сайжруулах (эрэгтэйчүүдийн кабинет)
Хэн үр шим хүртээд хэн нь хүртэхгүй байна вэ? Яагаад?	<ul style="list-style-type: none"> Жендэрийн тухай мэдлэг, мэдээлэлгүй байгаа иргэдэд чиглэсэн үйл ажиллагаануудыг тодорхойлох, хэрэгжүүлэх Олон нийтэд чиглэсэн үйл ажиллагааг тогтмол, давтамжтайгаар хэрэгжүүлэх

Алхам 2.4 ОХШҮ-ээр цуглуулах мэдээллийн хүрээг тогтоох нь

Тодорхой үйл ажиллагааны чиглэлд ОХШ хийхдээ дараах мэдээллийг бэлэн байгаа мэдээллээс цуглуулна. Үүнд:

- ОНЖДХ-ийн төлөвлөгдсөн үйл ажиллагаанаас аль нь ямар орцтойгоор хэрэгжиж байна вэ?
- ОНЖДХ-ийн аль нь хэрэгжихгүй байна вэ?
- ОНЖДХ-ийн төлөвлөгөөнд тусгагдаагүй ямар үйл ажиллагаа ямар орцтойгоор хэрэгжиж байна вэ?

Төлөвлөгдсөн үйл ажиллагаа, түүний шалгуур үзүүлэлтийг сайтар судлаад юуг хэрхэн нотлох хэрэгтэй шаардлагатай, нотолгоог мэдээллийн ямар эх сурвалжаас авч болохыг тодорхойлно. Үйл ажиллагааны шалгуур үзүүлэлтийн дагуу нотлох хэрэгсэл, мэдээллийн эх сурвалжийг Дорнод аймгийн ЖЭТБХ дэд хөтөлбөрийн жишээн дээр үзүүлэв.

Жишээ 2.4.1 Үйл ажиллагааны шалгуур үзүүлэлтийн дагуу нотлох хэрэгсэл, мэдээллийн эх сурвалж

Үр дүн	Шалгуур үзүүлэлт	Нотлох хэрэгсэл	Эх сурвалж
Аймаг, сумын төрийн болон хувийн хэвшлийн байгууллагын бодлогын баримт бичиг, дотоод журам жендэрийн мэдрэмжтэй боловсруулагдсан байна.	Хөдөлмөрийн мөлжлөг ялгаварлан гадуурхалтаас сэргийлэх заалтыг дотоод журамдаа тусгасан аж ахуйн нэгж байгууллага- 15 байна. Жендэрийн мэдрэмжтэй салбарын хүний нөөцийн бодлого төлөвлөлттэй төрийн байгууллага 4 байна.	-Боловсруулсан дотоод журам -Байгууллагын тайлан -Сайн туршлага	Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар, “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан, 2019.10.26
Жендэрийн эрх тэгш байдлыг хангах орон нутгийн чадавхи сайжирч, жендэрийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх нийгмийн салбарын хөтөлбөрүүдийн хамтын ажиллагаа хангагдсан байна	Нийгмийн салбарт хүн амын бүхий л бүлэгт чиглэсэн 16 хөтөлбөр хэрэгжүүлж, хөтөлбөр хоорондын уялдаа холбоог ханган ажилласнаар хөгжлийн үр шимээс тэгш хүртэх боломжийг бүрдүүлсэн. Зарцуулсан төсөв 110 сая	-Дэд хөтөлбөр -Үйл ажиллагааны тайлан	Аймгийн Нийгмийн бодлогын хэлтсийн тайлан, 2020.02.05
Бүх нийтэд жендэрийн тухай мэдлэг олгох сургалт, эрүүл дадал хэвшүүлэх үйл ажиллагаа тогтвортой, үр дүнтэй явагддаг болсон байна.	Бүх нийтийн жендэрийн ойлголтыг нэмэгдүүлэх сургалт, нөлөөллийн ажлын тоо- 41, Жендэрийн сургалтанд хамрагдсан удирдах ажилтаны тоо- 53, төрийн албан хаагчдын тоо - 180, Жендэрийн сургагч багшийн тоо-180	-Оролцогчдын бүртгэл -Баримтжуулалт -Сургагч багшийн гэрчилгээ -Тайлан	Аймгийн Нийгмийн бодлогын хэлтсийн тайлан, , 2020.02.05
Эрэгтэйчүүд судлал, эрэгтэйчүүдэд үзүүлэх цогц үйлчилгээний эхлэл тавигдсан байна.	Эрэгтэйчүүдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлдэг кабинетын тоо-1 /Үйл ажиллагаа тогтвортой биш/	БОЭТ-ийн захирлын албан тоот, Аймгийн ИТХ-ын тогтоол	Аймгийн Нийгмийн бодлогын хэлтсийн тайлан, 2020.02.05
Шийдвэр гаргах болон гүйцэтгэх түвшин дэх хүйсийн тэнцвэртэй	Аймгийн ИТХ-ын төлөөлөгч нарын 13,5 хувь, Хэрлэн сумын ИТХ-ын төлөөлөгч	Аймаг, сумын ИТХ-ын тогтоол	Аймаг, сумын ИТХ-ын ажлын алба, 2020 оны

байдал хангагдсан байна.	нарын 22,5 хувь нь тус тус эмэгтэйчүүд сонгогдсон байна. /14 сумын нэгдсэн мэдээлэл одоогоор гараагүй байна./		11-р сарын 05
Жендэрт суурилсан хүчирхийллийн хохирогчид үзүүлэх чанартай үйлчилгээ бий болсон байна.	Хохирогчдыг хамгаалах байрны ажилчдын тоо-3 Тоглоомын талбай-1 Гал тогоо болон ариун цэврийн өрөө-1	НҮБ-ын хүн амын сангийн төсөл	Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан, 2019.10.26

2.4.2 Оролцооны үнэлгээ хийх асуултын шаардлагатай мэдээллийн хүрээ, эх сурвалж, арга

Үр дүн	Мэдээллийн хүрээ	Эх сурвалж	Арга
Төлөвлөсөн болон бодит гүйцэтгэл хоорондын зөрүү их байгаа нь юунаас шалтгаалж байна вэ? ямар өөрчлөлт шаардлагатай байна вэ?	Төлөвлөсөн ажлуудаас хэрэгжихэд нөлөөлсөн хүчин зүйлс Төлөвлөөгүй атлаа хэрэгжсэн ажил, түүнд нөлөөлсөн хүчин зүйлс, -Төлөвлөсөн үйл ажиллагааны хэрэгжилтийг дэмжих өөрчлөлт	Хэрэгжилтийн тайлан Хэрэгжүүлэгчид	Баримт бичгийн дүн шинжилгээ Түлхүүр мэдээлэгчдийн ярилцлага
Дэвшигдсэн асуудал, түүний шалтгаанд үйл ажиллагаа үр дүнтэй чиглэж чадаж байна уу?	Бодлогыг төлөвлөх шатанд дэвшигдсэн асуудлууд Асуудал-үйл ажиллагаа хоорондын уялдаа холбоо	Бодлогыг төлөвлөх үеийн нөхцөл байдлын судалгааны тайлан ОНЖДХ-ийн баримт бичиг	Баримт бичгийн дүн шинжилгээ мэдээлэгчдийн ярилцлага
Сонгосон загвар, арга үр дүнтэй байж чадаж байна уу? Шалтгаан нь юундаа байна вэ?	А-1. ААН Байгууллагын дотоод дүрэм журам А-2. Эрэгтэйчүүд судлал, эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг дэмжих бодлого, төлөвлөсөн үйл ажиллагаа	Салбарын бодлого Байгууллагын жилийн ажлын төлөвлөгөө Хэрэгжилтийн тайлан	Ярилцлага Баримт бичигт дүн шинжилгээ хийх
Төлөвлөлт ба хэрэгжилт хооронд ямар уялдаа байна вэ?	Төлөвлөлт ба хэрэгжилт хоорондын уялдаа холбоо	Салбарын бодлого Үйл ажиллагааны тайлан Судалгаа, мэдээлэл	Баримт бичгийн дүн шинжилгээ Түлхүүр мэдээлэгчдийн ярилцлага
Үйл ажиллагааг хэрэгжихэд орц буюу нөөцөөс юу нь хамгийн чухал үүрэг гүйцэтгэсэн байна вэ? Эсвэл юу нь хамгийн гол бэрхшээл болсон бэ?	Орон нутгийн жендэрийн нөхцөл байдлын судалгаа, хууль, үндэсний хөтөлбөр Төрийн удирдах болон гүйцэтгэх албан тушаалтны мэдлэг, хандлага,	Санхүүгийн тайлан Хэрэгжүүлэгч хүний нөөцийн мэдээлэл Үйл ажиллагааны хугацааны сонголт, төлөвлөлт-хэрэгжилт	Ганцаарчилсан болон бүлгийн ярилцлага Баримт бичгийн шинжилгээ Статистик баримтын шинжилгээ
Хэн үр шим хүртээд хэн нь хүртэхгүй байна вэ? Яагаад?	Үйл ажиллагаа бүрийн үр шим хүртэгчдийн тухай төлөвлөсөн хийгээд бодит хэрэгжилтийн мэдээлэл	Хувь хүн, Албан тушаалтан Тайлан Баримт, нотолгоо, статистик мэдээлэл	Баримт бичгийн шинжилгээ Онооны карт

Алхам 2.5 ОХШҮ-ний зорилго, зорилт, судлах арга зүйн талаар иргэдтэй зөвлөлдөх

ОХШҮ-ний зорилго, зорилт, судлах арга зүйгээ тодорхойлсны дараа иргэд, олон нийттэй зөвлөлдөж, хэлэлцүүлэг хийх хэрэгтэй. ОХШҮ-ний зорилго, зорилт судлах арга зүйн талаар, иргэд олон нийттэй зөвлөлдөх уулзалт зохион байгуулах талаар:

1. Зөвлөлдөх уулзалтанд оролцох хүмүүсийн нэрс гаргана. Үүнд: Орон нутгийн иргэд, ИНБ, ААНБ болон төрийн албаны ажилтан нарын төлөөллийг жигд оролцуулна. Зөвлөлдөх уулзалтыг дараах ялгаатай бүлгүүдээр зохион байгуулна.

- Иргэд, ИНБ, ААНБ-ын ажилтнууд
- Төрийн албан хаагчид

2. Хэлэлцүүлэх илтгэлийг дараах агуулгатайгаар бэлдэнэ.

- ОНЖДХ-ийн тухай
- ОХШҮ-ний зорилго, зорилт
- ОХШҮ-г гүйцэтгэх арга зүй, аргачлал

3. Зөвлөлдөх уулзалтад илтгэл танилцуулах субъектийг сонгож, илтгэлийг 15-20 минутын хугацаанд танилцуулна.

4. Оролцогчид дараах 2 бүлэгт хуваагдаж асуудлаа хэлэлцээд, саналаа нэгтгэж танилцуулна.

- Зорилго, зорилтын талаар санал өгөх баг
- ОХШҮ-г явуулах арга зүй, аргачлалд санал өгөх баг

5. Зөвлөлдөх уулзалтын ажиллагааг стандарт арга хэмжээний протоколын дагуу бэлтгэл ажлыг хангахаас гадна ковид 19 –аас сэргийлэх зөвлөмжийн дагуу үйл ажиллагааг зохион байгуулна.

6. Зөвлөлдөх уулзалтын үр дүнг нэгтгэж, зохих саналыг тусган сайжруулна.

3. ҮЕ ШАТ 3. ОХШҮ ХИЙХ ҮЕИЙН МЭДЭЭЛЛИЙГ ХЭРХЭН ЦУГЛУУЛАХ ВЭ? ОХШҮ-НИЙ МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АЛХАМУУД:

Үе шат 3-ыг судалснаар ОХШҮ-д шаардлагатай мэдээллийг тодорхойлж, ангилах, мэдээллийг цуглуулахад тохиромжтой аргуудын талаар мэдлэгтэй болж, оновчтой аргыг сонгох, сонгосон аргын хэрэглэгдэхүүнийг боловсруулах чадварт суралцана.

ОХШҮ-ний мэдээлэл цуглуулах үйл ажиллагаа ямар алхамтайгаар хэрэгждэг вэ?

Үүнд:

Алхам 1. Мэдээлэл цуглуулах аргуудаас сонгох

Алхам 2. Мэдээллийн эх сурвалж, түүврийг тогтоох

Алхам 3. Мэдээлэл цуглуулах арга хэрэгслийг боловсруулах

Алхам 4. Мэдээлэл цуглуулах бэлтгэл ажил

Алхам 5. Мэдээлэл цуглуулах

Алхам 6. Мэдээлэл цуглуулах үйл ажиллагааны хяналт

Алхам 7. Мэдээлэл цуглуулах үйл ажиллагааны тайлан бичих

Алхам 1. Мэдээлэл цуглуулах аргуудаас сонгох

Мэдээлэл цуглуулах үйл ажиллагааг системтэй явуулах хэрэгтэй. ОХШҮ-ний зорилготой уялдаа багатай, замбараагүй цуглуулсан мэдээллийг багцалж, дүгнэлт гаргахад хүндрэлтэй байдаг. ОХШҮ хийхэд баттай, үнэн зөв баримт цуглуулах нь гол байдаг тул мэдээлэл цуглуулах аргуудыг оновчтой зөв ашиглах нь чухал юм. **Тухайлбал:** Ганцаарчилсан ярилцлага, ажиглалт, туршилт, баримт бичгийн шинжилгээ хийх аргуудыг баримт кейс

цуглуулахад голлон ашигладаг бол анкет, бүлгийн болон ярилцлага гэх мэт аргуудыг нэмэлт мэдээлэл олж авах болон судалж буй асуудлын талаар хүмүүсийн хандлагыг олж тогтооход ашиглана. Нийгмийн судалгаанд цуглуулах мэдээллийг баримтын, ойлголт хандлагын, санал зөвлөмжийн, үнэлгээ дүгнэлтийн гэсэн 4 төрөлд хуваадаг. (ОНЖДХ-т ОХШҮ хийх аргачлал, 2020).

Шигтгээ.

Баримтын мэдээлэл: 2019 оны хувьд та жендэрийн мэдлэг ойлголт дээшлүүлэх хэдэн цагийн сургалтанд хамрагдсан бэ?

Ойлголт хандлагын мэдээлэл: Таныхаар жендэр гэж юу вэ? Та жендэрийн мэдлэг ойлголт дээшлүүлэх сургалтанд дахин хамрагдах уу?

Үнэлэлт дүгнэлтийн мэдээлэл: Та жендэрийн мэдлэг ойлголт дээшлүүлэх сургалтын үр өгөөжийг үнэлнэ үү?

Санал зөвлөмжийн мэдээлэл: Та жендэрийн мэдлэг ойлголт дээшлүүлэх сургалтын чанарыг дээшлүүлэхийн тулд юу хийх шаардлагатай гэж бодож байна вэ?

Хүснэгт 3.1.1. Мэдээлэл цуглуулах аргуудыг сонгох

Мэдээлэл цуглуулах нийтлэг аргууд	Баримтын	Ойлголт хандлагын	Үнэлгээ дүгнэлтийн	Санал зөвлөмжийн
Асуулга	Зарим талаар тохиромжтой	Зарим талаар тохиромжтой	Зарим талаар тохиромжтой	Тохиромжгүй
Ганцаарчилсан ярилцлага	Зарим талаар тохиромжтой	Тохиромжтой	Тохиромжтой	Зарим талаар тохиромжтой
Бүлгийн ярилцлага	Тохиромжгүй	Зарим талаар тохиромжтой	Тохиромжгүй	Тохиромжтой
Ажиглалт	Тохиромжтой	Зарим талаар тохиромжтой	Зарим талаар тохиромжтой	Тохиромжгүй
Баримт бичгийн шинжилгээ	Тохиромжтой	Зарим талаар тохиромжтой	Зарим талаар тохиромжтой	Зарим талаар тохиромжтой

Алхам 2. Мэдээллийн эх сурвалж, түүврийг тогтоох

Шаардлагатай мэдээллийг өгч чадахуйц баримт бичиг, хувь хүн, өрх, бүлэг, байгууллагаас мэдээллийг бүрдүүлнэ. Хэрэв төлөвлөгдсөн үйл ажиллагааны гүйцэтгэлийн талаарх мэдээлэл хэрэгтэй бол тодорхой цаг хугацааны давтамжтай гарсан тайлангууд мэдээллийн гол эх үүсвэр болдог.

Түүврийн төлөвлөлт

Судалгаанд иргэд, олон нийтийг хамруулахдаа зорилтот түүврийн аргуудыг ашигладаг.

Дорнод аймгийн ОХШҮ-ний багийн түүврийн аргыг ашиглан хийсэн жишээг үзүүлэв.

Жишээ: 3.2.1 Дорнод аймгийн ОХШҮ-ний багаас түүврийг тогтоосон хүснэгт

Сонгосон аргууд	Сонгосон эх сурвалжууд						Нийт
	1.Аймгийн ИТХ	2.Аймгийн ЗДТГ-ын харьяа байгууллагын удирдлага, мэргэжилтэн	3.БОЭТ ЭМГ Хувийн эмнэлэг	4.Хүний эрхийн байгууллагууд	5. Хувийн хэвшил, Аж ахуйн нэгж	6. Иргэд, олон нийт	
Асуулга						200	200
Ганцаарчилсан ярилцлага	3	5	8	4	4	5	29
Бүлгийн хэлэлцүүлэг	2	7	8	5	4	8	34
Нийт	5	12	16	9	8	213	263

Алхам 3. Мэдээлэл цуглуулах арга хэрэгслийг боловсруулах

ОХШҮ-ний мэдээллийг цуглуулахад маягт ашиглана. Энэ аргачлалыг ашиглан ОНЖДХ-т бүхэлд нь ХШҮ хийх боломжгүй. Иймд ОХШҮ-ээр нэг асуудалд төвлөрсөн асуулт, дэвшүүлсэн зорилтын хүрээнд төрийн байгууллагын дотоод ХШҮ-ний тогтолцоогоор бүрдүүлдэг мэдээлэлд үндэслэнэ. Ингэхдээ дараах маягтыг ашиглаж болно.

Жишээ 3.3.1 ОНЖДХ-т ОХШҮ хийхдээ ашиглах маягт

Үйл ажиллагаа	Хэрэгжсэн үйл ажиллагаа	Зарцуулсан цаг хугацаа	Хэн хэрэгжүүлсэн	Хэнийг оролцуулсан	Төсөв	Үр шимийг хүртэгчдийн төрөл, тоо	Хэрэгжээгүй шалтгаан, тайлбар
1	2	3	4	5	6	7	8
1.Төлөвлөсөн үйл ажиллагаа							
2. Төлөвлөөгүй хэрэгжсэн үйл ажиллагаа							

Төлөвлөсөн болон төлөвлөөгүйгээр хэрэгжсэн үйл ажиллагааг ангилж мэдээлэл цуглуулна.

ЖЭТБХ тухай хуульд зааснаар аймаг, нийслэл, сум, дүүрэг нь ЖҮХ-нд 1.ЖЭТБХ талаар авч хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, үр дүнгийн тайлан, 2.ЖЭТБХ бодлогын хэрэгжилтийн тайлан, 3. Хүйсийн тэнцвэрт байдлын тайланг жилд 1 удаа хүргүүлэх үүрэг хүлээдэг. ЖҮСХ-оос 2020 оны 5-р сарын 19-нд ЖЭТБХ хүрээнд авч хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, үр дүнгийн тайлангийн албан ёсны маягт, хүйсийн тэнцвэрт байдлын маягт, түүнийг нөхөх зааврыг баталсан байна. ЖЭТБХ бодлогын хэрэгжилтийн тайланг бүх шатны төрийн байгууллага дараа оны 2-р сарын 20-ны дотор ЖҮХ-нд хүргүүлнэ. (ҮСХ, 2020)

Алхам 3. Мэдээлэл цуглуулах арга хэрэгслийг боловсруулах

ОХШҮ-д мэдээллийн олон янзын эх сурвалжаас ихэвчлэн чанарын болон тоон гэсэн хоёр аргыг хослуулан хэрэглэдэг.

Чанарын судалгааны арга нь уян хатан бөгөөд асуудлыг олон талаас нь ухаж тайлбарладаг. Чанарын судалгаанд яагаад, яаж, хэрхэн гэсэн асуултууд гололдог бөгөөд хүүрнэсэн бичмэл хэлбэрээр үр дүнг тэмдэглэдэг.

Тоон судалгааны арга нь судалгааны объектын хэмжээ, тархалт, харьцаа хамаарлыг тодорхой түвшинд тоон хэлбэрээр илэрхийлсэн үзүүлэлтүүд юм (Мониторингийн гарын авлага, 2007).

ОХШҮ-нд мэдээлэл цуглуулах дараах нийтлэг аргуудыг ашигладаг. Үүнд:

- 3.1 Баримт бичгийн шинжилгээ
- 3.2 Асуулгын арга
- 3.3 Ганцаарчилсан ярилцлагын арга
- 3.4 Бүлгийн ярилцлагын арга
- 3.5 Ажиглалтын арга

Баримт бичгийн шинжилгээ: ОХШҮ-гээр судлах сэдэв, асуудалд хамаарах баримт, материалын агуулгад дүн шинжилгээ хийх арга юм. Орон нутагт хэрэгжиж буй хууль тогтоомж, бодлогын баримт бичиг болон төрийн байгууллага болон хувийн хэвшлийн байгууллагуудын дүрэм, журам, тайлан мэдээнд жендэрийн эрх тэгш байдал хангагдаж буй байдлыг тодорхойлно.

1. Баримт бичгийн шинжилгээгээр ямар мэдээлэл цуглуулах хүрээгээ тогтоох: ОНЖДХ-ийн зорилтуудын хэрэгжилтийн байдал, (юу нь хэрэгжээд, юу нь хэрэгжээгүй) орон нутагт хэрэгжиж буй бодлогын баримт бичгүүдэд жендэрийн эрх тэгш байдлыг хангаж буй байдал

Асуулт	Мэдээллийн хүрээ	Эх сурвалж	Арга
Орон нутгийн жендэрийн бодлого, үйл ажиллагааны төлөвлөлт дэх ямар үйл ажиллагааны чиглэл, үйл ажиллагаа төлөвлөснөөр хэрэгжсэн байхад ямар нь хэрэгжээгүй байна вэ?	Хэрэгжсэн үйл ажиллагаа Хэрэгжээгүй үйл ажиллагаа Гарсан өөрчлөлт	Бодлогын баримт бичиг, хэрэгжилтийн тайлан	Баримт бичгийн шинжилгээ

Жишээ 3.1 Дорнод аймгийн ОХШҮ-ний багаас ЖЭТБХ дэд хөтөлбөрт хийсэн баримт бичгийн шинжилгээний материал

ОХШҮ хийх хоёр асуудалд хамаарах дараах баримт бичгүүдэд агуулгын болон гүйцэтгэлийн нөхцөл байдалд шинжилгээ хийсэн. Үүнд:

1. Захиргааны хэм хэмжээний акт, бичиг баримт [код-2]
 - 1.1. ЖЭТБХ дэд хөтөлбөр;
 - 1.2. ЖЭТБХ дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, 2018-2020;
 - 1.3. Хөтөлбөрийн санхүүгийн тайлан;
 - 1.4. Аймгийн ИТХ-ын нийгмийн чиглэлийн хөтөлбөрүүдэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, 2018-2020;
 - 1.5. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын тайлан: 2018,2019 оны ЖЭТБХ дэд хөтөлбөрийн хэрэгжилтэнд хийсэн хяналт-шинжилгээ үнэлгээний тайлан;

- 1.6. ЖЭТБХ дэд хөтөлбөрийн хэрэгжилтэнд хийсэн хөндлөнгийн үнэлгээний тайлан, 2018-2020;
- 1.7. Засаг даргын мөрийн хөтөлбөрийн биелэлт 2016-2020 он
- 1.8. Аймгийн 2018, 2019 оны эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт;
2. Байгууллагын дүрэм, журам, тайлан [код-3]
- 2.1. ЭМГ, БОЭТ-н жилийн ажлын төлөвлөгөө, тайлан мэдээ (2018-2020 он);
- 2.2. Цэргийн насны залуучуудын эрүүл мэндийн талаарх мэдээлэл (2018-2020 он);
- 2.3. Хувийн хэвшлийн болон ААН, байгууллагын дүрэм, дотоод журам, төлөвлөгөө, хүйсийн тэнцвэртэй байлын тухай тайлан (2018-2020 он);
- 2.4. Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн даатгалд хамрагдсан талаарх тайлан, мэдээ;
- 2.5. “Аз жаргал” төвийн үйл ажиллагаа, төсвийн тайлан мэдээ;
- 2.6. Өргөдөл гомдол шийдвэрлэсэн мэдээлэл (Аймаг, сумын ИТХ-ын нутгийн удирлага, өргөдөл. гомдол, хяналт үнэлгээний бодлогын хороо, аймаг, сумын ЗДТГ, ХЭҮК-ийн аймгийн салбар зөвлөл, аймгийн ҮЭХ, аймгийн Ажил олгогчдын эздийн холбоо);
- 2.7 Ажлын байран дахь хүний эрхийн зөрчлийг шийдвэрлэсэн талаарх мэдээлэл. (Хууль хяналтын байгууллага);
3. Тайлан мэдээ
- 3.1. ЖЭТБХ дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн тайлан-2018, 2019, 2020. (ЗДТГ-н НБХ-ийн Жендэрийн салбар хороо)
- 3.2. ЖЭТБХ дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн тайлан. (ЗДТГ-н НБХ)
- 3.3. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах орон нутгийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан. (2018-2020. ГБХЗХГ);

Хүснэгт 3.2.1 Дорнод аймгийн ОХШҮ багаас баримт бичиг судлах аргаар цуглуулсан мэдээллийн хүрээ:

ОХШҮ-ний чиглэл	ОХШҮ-ний чиглэлийн хүрээнд илрүүлэх асуулт	Судлах баримт бичиг, эх сурвалжуудын код
Асуудал 1: Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн ажил олгогч болон ажиллагсдын ЖЭТБ-ын талаарх ойлголт мэдлэг болон жендэрийн мэдрэмжтэй төлөвлөлт, ажлын байрны нөхцөл байдлын өнөөгийн байдлыг тодорхойлох		
ЖЭТБ-ын талаарх мэдлэг, хандлага	<ul style="list-style-type: none"> •Байгууллагын дүрэм журам жендэрийн мэдрэмжтэй төлөвлөлт •Ажлын байрны нөхцөл ба жендэрийн тулгамдсан асуудал 	2.1-2.8 3.3 3.6 3.7
Асуудал 2: Эрэгтэйчүүд судлал, эрэгтэйчүүдэд үзүүлэх цогц үйлчилгээний өнөөдрийн түвшинг тодорхойлох.		
Эрэгтэй эмэгтэй хүмүүсийн нийгмийн үйлчилгээг тэгш, хүртэх боломжийг нэмэгдүүлэх	<ul style="list-style-type: none"> •Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн үзүүлэлт, тулгамдсан асуудал •Эрэгтэйчүүдэд зориулсан нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмж 	2.1-2.8 3.1 3.2 3.4 3.5

2. Баримт бичгийн шинжилгээний удирдамж боловсруулах

- Орон нутгийн ЖДХ-ийн хэрэгжилтийг үнэлэхэд чиглэсэн холбогдох баримт бичгүүдийн жагсаалтыг гаргаж, шинжилгээ хийх шаардлагатайг нь сонгоно.

- Сонгосон баримт бичгүүдэд жендэрт хамаарах түлхүүр үгээр утгын нэгжээ тогтооно. Үүнд:

- Жендэр гэдэг үг орсон
- Жендэрийн дам агуулга орсон (Хүний эрх, нийгмийн бүлгүүдийн оролцоо гэх мэт)
- Ажил ар гэрийн тэнцвэр хангах
- Ажлын байрны бэлгийн дарамт, ёс зүй
- Жендэрийн асуудлаар чадавхжуулах үйл ажиллагаа

Хүснэгт 3.2.2 Баримт бичгийн шинжилгээ хийх баримт бичгийн жагсаалт

Орон нутгагт хэрэгжиж буй бодлогын баримт бичиг	код
1.	
2.	
3.	

Хүснэгт 3.2.3 “ЖЭТБХ үйл ажиллагааны тайлан”-г уншиж судалсны дараа эшлэл тайлбар оруулах хүснэгтийн загвар

№	Баримт бичгийн нэр	Дугаар, огноо	Хуудас	Эшлэл (Бичиг баримтаас шууд холбогдох эшлэлийг бичнэ)	Тайлбар (Бичиг баримтаас холбоотой заалтыг бичнэ)
1				
2					
	Дүгнэлт: Хэрэгжсэн үйл ажиллагаа, гүйцэтгэл, ямар үр дагавартай 1. Хэрэгжээгүй орхисон үйл ажиллагаа, яагаад, ямар үр дагавартай Зөвлөмж: (Юунд өөрчлөлт оруулах шаардлагатай)				

3. Баримт бичгийн шинжилгээгээр цуглуулсан мэдээлэлд нэгтгэл хийх

Баримт бичгийн шинжилгээгээр сонгож авсан материалуудыг ижил төстэй болон ялгаатай сэдвийг тодорхойлж тайлбарладаг.

3.2 Асуулгын арга

Асуулгын аргаар орон нутгийн жендэрийн бодлогын ямар асуудлыг шийдэх шаардлагатай болох буюу нөхцөл байдлын үнэлгээ хийх, хэрэгжүүлсэн үйл ажиллагаанд оролцогчдын сэтгэл ханамжийн үнэлгээ, орон нутгийн жендэрийн бодлогын суурь болон зорилтот түвшинг тогтоох суурь судалгаа, явцын болон төгсгөлийн үнэлгээнд өргөн ашиглах боломжтой. Хэрэв асуулгын аргыг сонгосон бол дараах үе шатын дагуу асуулгыг ашиглана.

1. Асуулгын аргаар ямар мэдээлэл тогтоох хүрээгээ тогтооно, Жбэл: Үр шим хүртэгчдийн сэтгэл ханамж
2. Ямар төрлийн асуулгын аргаар мэдээлэл цуглуулахаа тогтооно. Жбэл: Цахим болон утсаар, нүүр тулсан асуулга гэх мэт
3. Цуглуулах мэдээллийн хэмжилтийг боловсруулах, асуулгыг загварчлах
4. Боловсруулсан асуулгаар мэдээлэл цуглуулж турших, сайжруулах
5. Сайжруулсан асуулгаар мэдээлэл цуглуулах

Асуулгыг **оршил, эхлэл, үндсэн, төгсгөл** гэсэн бүтэцтэйгээр боловсруулах бол:

Жишээ 3.2.1 Асуулгын загвар

Оршил хэсэгт: Асуулгын аргаар хэнээс, ямар мэдээлэл авах зорилгоор ОНЖДХ-ийн хэрэгжилтийг ОХШҮ-ээр үнэлэх байгууллага болон асуулгад хэрхэн хариулах зааврыг багтаадаг.

Эхлэл хэсэгт: ОХШҮ-ний оролцогчдын нас, хүйс, боловсрол, эрхэлж буй ажил зэрэг зайлшгүй асуух шаардлагатай нийгэм, хүн ам зүйн мэдээлэл багтдаг.

Үндсэн хэсэгт: Үр шим хүртэгчдийн жендэрийн ойлголт, мэдлэгийг сайжруулах зорилгоор зохион байгуулсан сургалтын үйл ажиллагааны сэтгэл ханамжийг үнэлэх зорилготой үндсэн асуултуудыг багтаадаг

Төгсгөл хэсэгт: Оролцогчдоос тухайн асуудлын талаар сэтгэгдлээ нээлттэй илэрхийлэх асуулт байж болно

3.3 Ганцаарчилсан ярилцлагын арга

Оролцогчтой нүүр тулан, асуулт асуух хэлбэрээр ойлголт хандлага, зан үйл, үзэл бодол, үнэлэлт дүгнэлтийн шинжтэй гүнзгийрүүлсэн мэдээллийг цуглуулах хамгийн тохиромжтой арга юм. Ганцаарчилсан ярилцлагын аргаар орон нутгийн жендэрийн дэд хөтөлбөрийн ямар ямар зорилт, үйл ажиллагаа нь хэрэгжээд, ямар үйл ажиллагаа хэрэгжихгүй байгааг тодруулахдаа ашиглаж болно.

Хэрэв ОХШҮ-ний баг ганцаарчилсан ярилцлагыг сонгосон бол дараах үе шатын дагуу хийнэ. Үүнд:

1. Ганцаарчилсан ярилцлагад хэнийг хамруулахаа тодорхойлно.
2. Ганцаарчилсан ярилцлагын аргаар ямар мэдээлэл цуглуулах хүрээгээ тогтооно.
3. Ганцаарчилсан ярилцлагын удирдамжийг боловсруулах ба ерөнхий, үндсэн хэсэг, төгсгөл хэсгээс бүрдэнэ.
4. Боловсруулсан удирдамжаар мэдээлэл цуглуулж турших, сайжруулна.
5. Сайжруулсан ганцаарчилсан ярилцлагын удирдамжаар мэдээлэл цуглуулна.

Жишээ 3.3.1 Ганцаарчилсан ярилцлагын удирдамжийн загвар

Ганцаарчилсан ярилцлагын удирдамж

Ерөнхий хэсэг

Ганцаарчилсан ярилцлагын зорилго:

Аймаг, сумын нэр	Дорнод аймаг.....
Байгууллагын нэр
Албан тушаал, туршлага
Эхэлсэн цаг, дууссан цаг, хаана
Ярилцагч, тэмдэглэл хөтлөгчийн нэр	

Үндсэн хэсэг

1.ОНЖДХ-ийн хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн зорилтот үйл ажиллагаанаас юу нь хэрэгжихгүй орхигдоод байна вэ?

2.

3.

Төгсгөл хэсэг

Цаашид ОНЖДХ-ийн хүрээнд төлөвлөсөн үйл ажиллагааны хэрэгжилтийг дэмжихэд юун дээр анхаарах хэрэгтэй вэ? Саналаа хэлнэ үү?

Тэмдэглэл (ярилцлагад оролцогчийн зан үйл, хандлагын талаарх мэдрэмж, ярилцлагын үеийн сэтгэгдэл, анхаарах асуудлыг тэмдэглэнэ)

Ганцаарчилсан ярилцлагын аргаар мэдээлэл цуглуулахад анхаарах зүйл

- ОХШҮ-ний багийн гишүүдийг мэдээлэл цуглуулах арга техникт сургасан байх
- Ярилцлагад оролцогчоос зөвшөөрөл авч, мэдээллийн нууцлалыг хангах ёс зүйн дүрмээ танилцуулж мөрдөх
- Ярилцлагын үеэр тэмдэглэл хөтлөх, бичлэг хийх, фото зургаар баримтжуулалт хийхийг урьдчилан сануулж зөвшөөрөл авах
- Ярилцлагын удирдамжийг чанд баримтлах
- Ярилцагчийг идэвхижүүлж, дэлгэрэнгүй яриулах нээлттэй асуулт тавих
- Ярилцагчийн өгч буй мэдээллийг зөв буруу гэх шүүмжлэлтэй байр сууринаас хандахгүй байх, хүндэтгэлтэй харилцах
- Ярилцлагын явцад ярилцагчын зан үйл, үйлдлийг ажиглах, тэмдэглэх
- Төгсгөлд нь ярилцлагад оролцогчдоо талархал илэрхийлэх

3.4 Бүлгийн ярилцлагын арга

ОХШҮ-гээр судлах асуудал, сэдвийн хүрээнд хэсэг бүлэг хүмүүсийн хүрээнд хэлэлцүүлэг хийх замаар мэдээлэл цуглуулдаг чанарын судалгааны арга юм. Бүлгийн ярилцлагыг чиглүүлэгч, ажиглагч, тэмдэглэл хөтлөгч гэсэн бүрэлдэхүүнээр зохион байгуулах ба 60-90 минут үргэлжилнэ.

Дараах үе шатын дагуу бүлгийн ярилцлагыг хийнэ.

1. Бүлгийн ярилцлагад хүн амын аль бүлгийн төлөөллийг хамруулахаа тогтоно. Нас, хүйс, боловсрол, ажил мэрэгжил зэрэг нийгэм хүн ам зүйн шинжийг харгалзан оролцогчдыг сонгоно. Бүлгийн ярилцлагад 6-8 хүн оролцох нь тохиромжтой
2. Бүлгийн ярилцлагын аргаар ямар мэдээлэл цуглуулах хүрээгээ тогтоно
3. Бүлгийн ярилцлагын удирдамж ерөнхий, үндсэн, төгсгөл гэсэн бүтэцтэйгээр боловсруулагдана. Хэрэв ялгаатай бүлгүүдийг оролцуулах нөхцөлд өөр төрлийн удирдамж боловсруулна.
4. Боловсруулсан удирдамжаар мэдээлэл цуглуулж турших, сайжруулна.

5. Сайжруулсан бүлгийн ярилцлагын удирдамжаар мэдээлэл цуглуулна

Жишээ 3.4.1 Бүлгийн ярилцлагын удирдамжийн загвар

Бүлгийн ярилцлагын удирдамж					
Ерөнхий хэсэг					
Бүлгийн ярилцлагын зорилго: Хувийн хэвшлийн байгууллага болон аж ахуйн нэгжүүдийн ажилчдын ЖЭТБ-ын талаарх ойлголт мэдлэг болон ажлын байрны нөхцөл байдал, хөдөлмөрийн харилцаанд тулгарч буй жендэрийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх боломжуудыг тодорхойно.					
Аймаг нийслэл, сум дүүргийн нэр				
Ярилцлага эхэлсэн, дууссан цаг, хаана				
Бүлгийн ярилцлагад оролцогчдын категори					
Чиглүүлэгчийн нэр				
Ажиглагчийн нэр				
Танилцуулга					
Бүлгийн ярилцлагад оролцогчдын мэдээлэл					
N	Нэр	Нас	Хүйс	Эрхэлдэг ажил	Ажилласан жил
1
2
3					
Үндсэн хэсэг					
1.ОНЖДХ-ийн хэрэгжилтийг хангах хүрээнд төлөвлөсөн ямар ямар үйл ажиллагаанд оролцож байсан талаараа ярина уу?					
2.					
3.					
Төгсгөл хэсэг					
1.Цаашид ОНЖДХ-ийн хэрэгжилтийг хангах хүрээнд төлөвлөсөн үйл ажиллагааны хэрэгжилтийг дэмжихэд юун дээр анхаарахыг санал болгох вэ?					
2.					
Тэмдэглэл (ярилцлагад оролцогчийн зан үйл, хандлагын талаарх мэдрэмж, ярилцлагын үеийн сэтгэгдэл, анхаарах асуудлыг тэмдэглэнэ)					

Бүлгийн ярилцлагын аргаар мэдээлэл цуглуулахад анхаарах зүйл

- ОХШҮ-ний багийн гишүүдийг бүлгийн ярилцлагын аргаар мэдээлэл цуглуулах арга техникт сургасан байх
- Тэмдэглэл хөтлөгч ярилцлагад оролцогчийн яриаг засварлахгүйгээр байгаагаар нь бичиж тэмдэглэх
- Бүлгийн ярилцлагад оролцогчоос зөвшөөрөл авч, мэдээллийн нууцлалыг хангах ёс зүйн дүрмээ танилцуулж мөрдөх
- Бүлгийн ярилцлагын үеэр тэмдэглэл хөтлөх, бичлэг хийх, фото зургаар баримтжуулалт хийхийг урьдчилан сануулж зөвшөөрөл авах
- Бүлгийн ярилцлагын удирдамжийг чанд баримтлах
- Оролцогчдыг идэвхижүүлж, дэлгэрэнгүй яриулах нээлттэй асуулт тавих
- Оролцогчдын өгч буй мэдээллийг зөв буруу гэх шүүмжлэлтэй байр сууринаас хандахгүй байх, хүндэтгэлтэй харилцах, өөр үзэл бодлыг бусдад тулгахгүй байх
- Хэлэлцүүлгийн явцад ярилцагчийн зан үйл, үйлдлийг ажиглах, тэмдэглэх
- Төгсгөлд нь бүлгийн ярилцлагад оролцогчдоо талархал илэрхийлэх

3.5 Ажиглалтын арга

Ажиглалтын арга гэдэг нь хүмүүсийн хандлага, зан байдал, аливаа үйл ажиллагааны явцыг системтэй сонгож ажиллах, ажилласан зүйлээ тэмдэглэхийг хэлнэ.

Ажиглалт нь ил буюу холбогдох хүмүүст тэдний үйлдэл, зан байдал зэргийг ажиглаж байгаа талаараа мэдэгдэх, далд буюу өөрсдөд нь мэдэгдэхгүйгээр ажиглах хэлбэртэй байж болно.

Ярилцлага, санал асуулгын аргуудтай харьцуулбал ажиглалтын арга нь хүмүүсийн зан байдал, үйл явцын талаар баттай нарийн мэдээлэл олж авах боломж олгодог сайн талтайгаас гадна ярилцлагаас олж авсан мэдээллийн үнэн зөвийг батлах боломжтой.

Ажиглалтын аргыг мөн байшин барилга гэх мэт тодорхой объект дээр ашиглаж болно.

3.4 Мэдээлэл цуглуулах үйл ажиллагааны төлөвлөлт

Дорнод аймгийн ОХШҮ-ний багийн төлөвлөгөөг загвар болгон үзүүлж байна.

Жишээ 3.4.1. Дорнод аймгийн ОХШҮ-ний мэдээлэл цуглуулах үйл ажиллагааны

ТӨЛӨВЛӨЛТ

№	Үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах эзэн
1	ЖЭТБ-ыг хангах ажиллагааг зохицуулж буй хууль, хөтөлбөр, бодлогын бичиг баримт, тайлан мэдээг олох, цуглуулах, анализ хийх	2020.11.25-12.05	ОХШҮ-ний багийн гишүүд
2	Хувийн хэвшлийн байгууллага болон эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн асуудалтай холбоотой бичиг баримт, тоон мэдээлэл авах талаар холбогдох байгууллагуудад бичиг явуулах, хариу авах.	2020.11.25-12.01	ОХШҮ-ний багийн гишүүд
3	Судлах асуудлуудын шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулах, асуулга судалгааны асуумжийг боловсруулах, урьдчилсан асуумж (pre-test) авч сайжруулах, багийн гишүүдэд танилцуулах, батлах	2020.11.25-12.01	ОХШҮ-ний багийн гишүүд
4	Асуулга судалгаа авах хүмүүст зааварчилгаа өгөх, урьдчилсан байдлаар судалгаа авч үзэх	2020.11.25-28	ОХШҮ-ний багийн гишүүд
5	Асуулга судалгаа хийх /Сонгогдсон иргэдээс/	2020.12.01-12.10	ОХШҮ-ний багийн гишүүд
6	SPSS-д мэдээллийг оруулах	2020.12.10-12.15	ОХШҮ-ний багийн гишүүд
7	Судалгааны дүнг нэгтгэх	2020.12.15-12.20	ОХШҮ-ний багийн гишүүд
8	Чанарын судалгааны удирдамж боловсруулах	2020.11.17-11.23	ОХШҮ-ний багийн гишүүд
9	Ганцаарчилсан ярилцлагын чиглэл, асуултууд боловсруулах	2020.11.17-11.23	ОХШҮ-ний багийн гишүүд
10	Ганцаарчилсан ярилцлагуудыг хийх талаар албан бичиг явуулах эсвэл утсаар хугацааг товлох	2020.11.23-11.25	ОХШҮ-ний багийн гишүүд

11	Ганцаарчилсан ярилцлага хийх хүмүүсийг тодорхойлох	2020.11.25-11.27	ОХШҮ-ний багийн гишүүд
12	Ярилцлага авах гишүүдэд зааварчилгаа өгөх	2020.11.23	ОХШҮ-ний багийн гишүүд
13	Бүлгийн ярилцлагын чиглэл, асуултууд боловсруулах	2020.11.17-11.23	ОХШҮ-ний багийн гишүүд
14	ОХШҮ-ний багийн гишүүдээс санал авах	2020.11.21-23	ОХШҮ-ний багийн гишүүд
15	Чанарын судалгааны чиглэл, асуултуудыг эцсийн хувилбараар боловсруулах	2020.11.23	ОХШҮ-ний багийн гишүүд
16	Ярилцлага, бүлгийн хэлэлцүүлгийг хийх, баримтжуулах /диктофонд бичих, фото зураг авах	2020.11.25-12.15	ОХШҮ-ний багийн гишүүд
17	Судалгааны мэдээлэл цуглуулах	2020.11.25-12.15	ОХШҮ-ний багийн гишүүд
18	Судалгааны ажлын мэдээллийг шивэх	2020.12.15-20	ОХШҮ-ний багийн гишүүд
19	Чанарын судалгааны мэдээлэлд дүн шинжилгээ хийх	2020.12.20-23	ОХШҮ-ний багийн гишүүд
20	Чанарын судалгааны тайлан бичих	2020.12.23-25	ОХШҮ-ний багийн гишүүд
21	Нэгдсэн тайлан бичих	2020.12.25-12.30	ОХШҮ-ний багийн гишүүд

СУДАЛГААНЫ ЁС ЗҮЙН ХЭМ ХЭМЖЭЭ

Судлаач нь судалгааны ёс зүйн хэм хэмжээний үндсэн зарчмуудыг баримтлах ба судалгаанд оролцогчдын өмнө болон судалгааг санхүүжүүлэгчдийн өмнө хариуцлага хүлээнэ.

1. Судалгаанд оролцогчдод хохирол учруулахгүй байх: Бидний хийж буй энэхүү судалгаанд оролцогчдын тусын тулд ЖЭТБХ дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн үр нөлөөг сайжруулах хүрээнд хийгдэх бөгөөд судалгааны явц, үр дүн нь оролцогчдыг биеийн болоод сэтгэл зүйн эрсдэлд оруулахгүй байхаар зохион байгуулна.

2. Судалгаанд оролцогчид сайн дураараа оролцох: Судалгаанд оролцогчид бусдын эрхээр биш сайн дураараа оролцох ба ямар судалгаанд, яагаад оролцох болсныг нь дэлгэрэнгүй тайлбарлаж өгнө. Зорилтот бүлгийн иргэдээс судалгаа авахдаа заавал хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигчээс зөвшөөрөл авна.

3. Судалгаанд оролцогчдын талаарх судалгааны нууц: Судалгаанд оролцогчийн нэр төр, эрхийг хамгаалах үүднээс зохих боловсруулалт хийхээс өмнө судалгааг эрхлэн гүйцэтгэж байгаа хүмүүсээс өөр бусад хүмүүст судалгааны нарийн мэдээллийг өгөхгүй. Судалгаанд оролцогчийг хүндэтгэн нэрийн нууцлалыг хадгална.

4. ҮЕ ШАТ 4. ЦУГЛУУЛСАН МЭДЭЭЛЛЭЭ ХЭРХЭН БОЛОВСРУУЛЖ, ШИНЖЛЭХ ВЭ? :

Цуглуулсан мэдээллийн шинжилгээг доорх алхамуудаар хийнэ. Үүнд:

Алхам 1. Хяналт шинжилгээний мэдээлэлд шинжилгээ хийх

Алхам 2. Тоон мэдээллийн боловсруулалт, дүн шинжилгээ хийх

Алхам 3. Чанарын мэдээлэлд дүн шинжилгээ хийх

АЛХАМ 1. ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ МЭДЭЭЛЭЛД ШИНЖИЛГЭЭ ХИЙХ

ХШ-ний мэдээлэлд шинжилгээ хийхэд ХШ-ний зорилго, зорилт, ямар асуудал дээр ХШ-г хийсэн, суурь болон зорилтот түвшин юу болох, эдгээр мэдээллийн эх сурвалжийг хаанаас авсан бэ? гэсэн чухал асуултууд урган гардаг. Тиймээс суурь болон зорилтот түвшин нь ХШ-ний мэдээлэлд шинжилгээ хийхэд ихээхэн чухал юм. Орон нутгийн жендэрийн бодлогын баримт бичиг, төрийн захиргааны мэдээлэл, статистик мэдээлэл, суурь судалгааны тайлан болон холбогдох бичиг баримтаас бодлогын хэрэгжилтийн суурь болон зорилтот түвшний мэдээллийг нягтална.

Хяналт шинжилгээ хийхэд тухайн үеийн мэдээллийг цуглуулдаг. Энэ нь орон нутгийн жендэрийн бодлого хэрэгжиж эхэлсний дараа хяналт шинжилгээ хийснээр ямар өөрчлөлт гарсныг илэрхийлдэг. ОНЖДХ-ийн суурь түвшний шалгуур үзүүлэлтээ тодорхойлоогүй, харин зорилтот түвшингээ тодорхойлсон байгаа нь харьцуулах, явц, ахиц өөрчлөлтийг үнэлж дүгнэн, шинжлэхэд хүндрэл учруулдаг. Энэ тохиолдолд ОХШ хийх үеийн түвшинтэй харьцуулж шинжилгээ хийхээс өөр аргагүй юм. Бодлогын зорилтуудын суурь түвшний шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлохгүйгээр үйл ажиллагааг төлөвлөх нь ОХШ-ийн үйл явцыг хүндрүүлдэг.

Тиймээс орон нутгийн жендэрийн бодлогын баримт бичиг, төрийн захиргааны мэдээлэл, статистик мэдээлэл, суурь судалгааны тайлан болон холбогдох бусад баримт шинжилгээнд тулгуурлан бодлогын хэрэгжилтийн суурь болон зорилтот түвшний мэдээллийг нягтална.

Загвар 4.1.1 ОХШ-ний мэдээлэлд шинжилгээ хийхэд шаардлагатай мэдээллүүдийг цуглуулна.

Бодлогын баримт бичиг: Жендэрийн эрх тэгш байдлыг хангах аймгийн дэд хөтөлбөр											
Үйл ажиллагааны чиглэл: Жендэрийн эрх тэгш байдлыг хангах орон нутгийн чадавхыг бэхжүүлэх											
Үйл ажиллагаа	Гүйцэтгэлийн /шалгуур/ үзүүлэлт	Суурь түвшин 2017	Зорилтот түвшин 2021	Мэдээллийн эх сурвалж	Хэрэгжсэн үйл ажиллагаа	Зарцуулсан цаг хугацаа	Хэн хэрэгжүүлсэн	Хэнийг оролцуулсан	Зарцуулсан төсөв	Үр шимийг хүртэгчдийн төрөл, тоо	Хэрэгжээгүй бол шалгаан, тайлбар
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
1. Төлөвлөсөн үйл ажиллагаа											
1. Удирдах ажилтан манлайлагчдыг жендэрийн сургалтанд хамруулах	1. Жендэрийн сургалтанд хамрагдсан удирдах ажилтан, төрийн албан тушаалтан	6.1 хувь	100 хувь	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах аймгийн дэд хөтөлбөр							
	2										

ОХШ-ний мэдээлэлд хэрхэн дүн шинжилгээ хийх вэ?

- Төлөвлөсөн болон төлөвлөөгүй хэрэгжсэн нийт хэдэн үйл ажиллагаа байгааг тооцож, төлөвлөсөн болон төлөвлөөгүй хэрэгжсэн үйл ажиллагааны тус бүрийн тоон


мэдээллүүдийг маягтын баганын дагуу дүгнэж зохих хувийн жинг бодно. Тухайлбал: Нийт хэрэгжсэн үйл ажиллагааны хэдэн хувь нь төлөвлөсөн, хэдэн хувь нь төлөвлөөгүйгээр хэрэгжсэн байна вэ? гэдгийг харуулна. Төлөвлөсөн үйл ажиллагааны хэдэн хувь нь хэрэгжсэн байна гэдгийг шинжилнэ.

- Хяналт шинжилгээ хийхээр дэвшигдсэн асуудлын суурь түвшний мэдээлэл, ОХШ хийх үеийн түвшин, зорилтот түвшний мэдээлэл байгаа тохиолдолд эдгээр үзүүлэлтүүдийг нь харьцуулж шинжилнэ.
- ОХШ-ний маягтад тоон үзүүлэлтийг нэгтгэж, хувийн жинг тооцдог бол чанарлаг утгыг шаарддаг асуултуудын хариултыг чанарын шинжилгээний аргыг ашиглаж шинжилнэ.
- Төлөвлөсөн болон төлөвлөөгүйгээр хэрэгжсэн үйл ажиллагааг хэн хэрэгжүүлсэн, хэнийг оролцуулсан, хэн үр шимийг хүртсэн зэрэгт дүн шинжилгээ хийнэ.
- Төлөвлөсөн болон хэрэгжсэн үйл ажиллагаанд нийтдээ болон тус бүрийн төсвийн зарцуулалтыг тооцож, ямар зардлаар хэр хэмжээний үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлсэн болон эс хэрэгжсэнийг гаргана.
- ОХШ-ний үр дүнд үйл ажиллагааны төлөвлөлт болон хэрэгжилтийг сайжруулах, боломжийг илрүүлнэ.
- ОХШ-г тодорхой давтамжтайгаар, товлосон цаг хугацаанд төлөвлөн хийдэг. Их хэмжээний бэлэн мэдээлэл хуримтлагддаг учраас Excel программд боловсруулалтыг хийх боломжтой.
- ОХШ-гээр цуглуулагдсан мэдээллээ тоон болон чанарын судалгааны мэдээлэл боловсруулах арга зүйг ашиглан дүн шинжилгээ хийнэ.

ОХШ-ний тоон болон чанарын мэдээллүүд, шинжилгээний үр дүн, дэвшигдсэн тодорхой асуудлууд нь үнэлгээг хийх суурь болно.

АЛХАМ 2. ТООН МЭДЭЭЛЛИЙН БОЛОВСРУУЛАЛТ, ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ

Тоон мэдээллийн боловсруулалтыг дараах алхамтайгаар гүйцэтгэнэ.



2.1 Өгөгдлийг шивэлтэд бэлтгэх. Шивэлтэд бэлтгэхдээ дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:

- **Өгөгдлийг шалгах.** Цуглуулсан мэдээллийн чанарыг шалгах явцад хоосон орхисон болон дутуу бөглөсөн хариулт бүхий асуулгыг хасна. Шалгаж дууссаны дараа асуулга бүрийг дугаарлана.
- **Өгөгдлийг кодлох,** Үүнд:
 - а. Асуулгыг боловсруулах шатанд ихэнх асуултын хариултуудыг тоо, үсгээр урьдчилан кодолсон байдаг. Жишээ нь: “Хүйс” гэсэн хувьсагчийн хувьд эрэгтэй бол 1, эмэгтэй бол 2 гэсэн тоогоор кодлон тэмдэглэдэг.
 - б. Нээлттэйгээр асуусан хариултын хувилбаруудыг дахин бүлэглэж код оноож асуулгын хуудаст тэмдэглэнэ. Мөн Excel программд нээлттэй хариултуудыг байгаагаар нь бичиж оруулсны дараа дахин бүлэглэлт хийж болно. Асуултын хариултуудыг асуулгын хуудаст кодлох нь компьютерт өгөгдөл шивэх ажлыг хялбарчилдаг.

2.2 Мэдээлэл шивэх. Тоон өгөгдөл, мэдээллийг компьютерийн программ ашиглан дүн шинжилгээ хийнэ. Орчин үед мэдээлэл боловсруулахад зориулсан олон программ байдаг ч нийтлэг хэрэглэгддэг Excel программд өгөгдлийг шивж боловсруулах боломжтой.

2.3 Мэдээлэлд дүн шинжилгээ хийх. Мэдээлэлд харьцуулалт хийх, логик дүгнэлт хийх зорилгоор статистикийн аргуудыг ашигладаг. Мэдээлэлд дүн шинжилгээ хийхдээ: **а.** Нэг шинж тэмдгээр бүлэглэх буюу энгийн бүлэглэлтийн дүн шинжилгээ, **б.** Хоёр ба түүнээс дээш шинж тэмдгээр буюу солбицуулсан бүлэглэлтийн дүн шинжилгээ гэсэн 2 алхмаар гүйцэтгэнэ.

АЛХАМ 3. ЧАНАРЫН МЭДЭЭЛЭЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ

Чанарын судалгаа нь нээлттэй, хэв загварт оруулаагүй арга хэлбэрийг ашигладаг, уян хатан чанартай, урьдчилан таамаглал, төсөөлөлд захирагдахгүй бөгөөд асуудлыг олон талаас нь тайлбарлах боломжийг судлаачид олгодог. Чанарын судалгааны үед юу? яагаад? яаж? гэсэн асуултанд хариулагдах үг, өгүүлбэрээр мэдээлэл цуглуулдаг. Чанарын судалгааны мэдээллийг шинжлэх зориулалттай олон программ байдаг ч Excel программд их хэмжээний мэдээллийг шивж, боловсруулах боломжтой.

Ганцаарчилсан ярилцлага, фокус бүлгийн ярилцлага, ажиглалт болон бусад чанарын судалгааны аргаар цуглуулсан мэдээллийг шинжлэхэд дараах алхамуудыг хийж болно. Үүнд:

1.Мэдээллийг бэлтгэх, шивэх: Цуглуулсан мэдээллээ орхигдуулахгүйгээр хуулбарлан шивж бичнэ. Бүх мэдээллээ текст хэлбэртэй болгон хөрвүүлж нэг бүрчлэн дугаарлана.

2.Мэдээллийг ангилж цэгцлэх: Мэдээллээ шивсний дараа эмхэлж цэгцлэх шаардлагатай. Их хэмжээний мэдээллийг цэгцлэхдээ ОХШҮ-ний зорилго, асуултуудад үндэслэн шивсэн мэдээллийг зохион байгуулж байршуулна. Үүний тулд ОХШҮ-ний үндсэн асуултуудаа Excel программын хүснэгтэнд оруулан хариултуудын харалдаа байрлуулна. Мэдээлэл өгсөн оролцогч бүрийн хариултыг хүснэгтийн харгалзах нүдэнд оруулж мэдээллийг шинжлэхэд бэлтгэнэ.

Жишээ 4.3.1 Ганцаарчилсан ярилцлагын мэдээллийг шивэх загвар #1 /Дорнод аймгийн ОХШҮ баг/

Асуулт	код	Нас	Хүйс	Хариулт
1. Дорнод аймагт төрийн байгууллагын зүгээс эрэгтэй эмэгтэй хүмүүсийн эрүүл мэндийн онцлог хэрэгцээнд зориулсан үйлчилгээг бий болгоход хэрхэн анхаарч ажиллаж байна вэ?	14	53	эр	Тодорхойлж хэлэхэд их төвөгтэй байна. Эрэгтэйчүүдийн үзлэг шинжилгээнд хамрагдалт хангалтгүй байна.
	15	36	эр	Эрэгтэйчүүдийг хамруулсан амбулаторийн үзлэгийг 2018 оноос жигдрүүлсэн. Оношлогоог хувийн лабораториудаар шийдэж байна. Урьдчилан сэргийлэх үзлэг, багцын үзлэгээр нийт 150 хүн үзсэн. Урьдчилан сэргийлэх үзлэгийг хангалттай сайн гэж үзэхгүй
	16	36	эм	Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг дэвшилтэт технологи, мэс заслын хагалгааг дурангаар хийх, эмч бэлтгэх ажлыг эхлүүлсэн.
	17	50	эм	Аймгийн түвшинд эрүүл мэндийн онцлог хэрэгцээнд тохирсон үйлчилгээг бий болгоход эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг дэмжих чиглэлд анхаарч урологи андрологийн тусламж үйлчилгээг хөгжүүлэх , эмч бэлтгэх талаар ярьж байна.

3.Цуглуулсан мэдээллээ кодлох:

Цуглуулсан мэдээлэлд утгын кодыг тохируулах нь их хэмжээний мэдээллийг багасгаж, багцлах хамгийн сайн арга юм. Кодлох нь цуглуулсан мэдээллийн дахин давтагдах сэдэв, үзэл бодол, итгэл үнэмшлийг тодорхойлж, мэдээллийг утга, хэв маягаар нь ангилах, хуваарилах, дүн шинжилгээ хийх чухал алхам бөгөөд хариултуудаас давтагдаж буй гол гол утгыг нь түүвэрлэн авч кодлоно. Мөн давтагдахгүй байгаа харилтуудад код өгнө. Давтагдахгүй байгаа хариултууд нь тайланд бие даасан дүгнэлт болж орохгүй ч дурьдаж тайлбарлах боломжтой. Цуглуулсан мэдээлэлд нийтлэг болон ялгаатай тал, онцлог санаа, үзэл бодол байгааг анхаарна.

Жишээ 4.3.2 Ганцаарчилсан ярилцлагын мэдээллийг шивэх загвар #2/Дорнод аймгийн ОХШҮ баг/

Асуулт	код	Нас	Хүйс	Хариулт	Утгын код
1. Дорнод аймагт төрийн байгууллагын зүгээс эрэгтэй эмэгтэй хүмүүсийн эрүүл мэндийн онцлог хэрэгцээнд зориулсан үйлчилгээг бий болгоход хэрхэн анхаарч ажиллаж байна вэ?	14	53	эр	Тодорхойлж хэлэхэд их төвөгтэй байна. Эрэгтэйчүүдийн үзлэг шинжилгээнд хамрагдалт хангалтгүй байна.	1. Эрэгтэйчүүдийг хамруулсан урьдчилан сэргийлэх үзлэг хангалттай биш байна 2. Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг дэмжих урологи, андрологийн тусламж үйлчилгээг хөгжүүлэх бодлогын хүрээнд эмч бэлтгэх, 3. Дэвшилтэт технологит суурилсан үйлчилгээ үзүүлэх шаардлагатай багаж тоног төхөөрөмж худалдан авах
	15	36	эр	Эрэгтэйчүүдийг хамруулсан амбулаторийн үзлэгийг 2018 оноос жигдрүүлсэн. Оношлогоог хувийн лабораториудаар шийдэж байна. Урьдчилан сэргийлэх үзлэг, багцын үзлэгээр нийт 150 хүн үзсэн. Урьдчилан сэргийлэх үзлэгийг хангалттай сайн гэж үзэхгүй	
	16	36	эм	Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг дэвшилтэт технологи, мэс заслын хагалгааг дурангаар хийх, эмч бэлтгэх ажлыг эхлүүлсэн.	
	17	50	эм	Аймгийн түвшинд эрүүл мэндийн онцлог хэрэгцээнд тохирсон үйлчилгээг бий болгоход эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг дэмжих чиглэлд анхаарч урологи андрологийн тусламж үйлчилгээг хөгжүүлэх, эмч бэлтгэх талаар ярьж байна.	

4. Мэдээллээ дүгнэж тайлбарлах:

Судалгааны үр дүнг таамаглал эсвэл судалгааны зорилго, зорилттой холбох, мэдээллийг гол үзүүлэлттэй харьцуулах, зөрүүг тэмдэглэх, бусад асуудлыг тодорхойлох, аливаа асуудлын шалтгааныг олох, гол шийдлүүдийн хувилбаруудыг дүгнэж тайлбарладаг. Мэдээллийг хүснэгт, матриц хэлбэрээр илэрхийлэх, дүнг хөрвүүлэн тайлбарлах, дүгнэлт хийх, зөвлөмж хэлбэрээр тайлбарлаж тайланд ашиглана.

Жишээ 4.3.3 Ганцаарчилсан ярилцлагын мэдээллийг шивэх загвар #3 /Дорнод аймгийн ОХШҮ баг/

Асуулт	код	Нас	Хүйс	Хариулт	Утгын код	Дүгнэлт
1. Дорнод аймагт төрийн байгууллагын зүгээс эрэгтэй	14	53	эр	Тодорхойлж хэлэхэд их төвөгтэй байна. Эрэгтэйчүүдийн үзлэг шинжилгээнд хамрагдалт	1. Эрэгтэйчүүдийг хамруулсан урьдчилан сэргийлэх үзлэг	1. Эрэгтэйчүүдийн эмч бэлтгэх, багаж тоног төхөөрөмж худалдан авах

эмэгтэй хүмүүсийн эрүүл мэндийн онцлог хэрэгцээнд зориулсан үйлчилгээг бий болгоход хэрхэн анхаарч ажиллаж байна вэ?				хангалтгүй байна.	хангалтай биш байна	хэрэгцээ шаардлага байна.
	15	36	эр	Эрэгтэйчүүдийг хамруулсан амбулаторийн үзлэгийг 2018 оноос жигдрүүлсэн. Оношлогоог хувийн лабораториудаар шийдэж байна. Урьдчилан сэргийлэх үзлэг, багцын үзлэгээр нийт 150 хүн үзсэн. Урьдчилан сэргийлэх үзлэгийг хангалттай сайн гэж үзэхгүй.	2.Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг дэмжих урологи, андрологийн тусламж үйлчилгээг хөгжүүлэх бодлогын хүрээнд эмч бэлтгэх, 3.Дэвшилтэт технологит суурилсан үйлчилгээ үзүүлэх шаардлагатай багаж худалдан авах	2. Урьдчилан сэргийлэх болон багцын үзлэг хангалттай биш байна.
	16	36	эм	Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг дэвшилтэт технологи, мэс заслын хагалгааг дурангаар хийх, эмч бэлтгэх		
	17	50	эм	Аймгийн түвшинд эрүүл мэндийн онцлог хэрэгцээнд тохирсон үйлчилгээг бий болгоход эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг дэмжих чиглэлд анхаарч урологи андрологийн тусламж үйлчилгээг хөгжүүлэх бодлого ярьж байна.		

5. ҮЕ ШАТ 5. ОХШҮ-НИЙ ҮР ДҮНГ ТАНИЛЦУУЛАХ, БОДЛОГЫН ЗӨВЛӨМЖ БОЛОВСРУУЛАХ

Өмнөх үе шатуудад ОХШҮ хийх зорилго, арга зүйгээ тодорхойлон аргачлалын дагуу мэдээллээ цуглуулж, дүн шинжилгээ хийсэн байгаа. Энэ үе шатанд ОХШҮ-ний үр дүнг танилцуулах, бодлогын зөвлөмж боловсруулах аргуудаас суралцана. Дараах алхамаар ОХШҮ-ний үр дүнг бодлого боловсруулагч нарт хүргэнэ. Үүнд:

1. ОХШҮ-ний үр дүнг бичгээр танилцуулах
2. ОХШҮ-ний үр дүнг биечлэн уулзаж танилцуулах
3. ОХШҮ-ний үр дүнгээр бодлогын зөвлөмж боловсруулах

1.Үр дүнг бичгээр танилцуулах

Орон нутгийн ЖСХ-ны дарга болон бусад оролцогч талууд, үр шим хүртэгчдэд ОНЖДХ-ийн хэрэгжилтэнд хийсэн ОХШҮ-ний үр дүнг танилцуулахдаа ямар зорилгоор, ямар аргаар, ямар үр дүнд хүрч, ямар дүгнэлт, зөвлөмж гаргасан талаар танилцуулдаг. Иймд бичмэл тайланг арга зүй, үр дүн, дүгнэлт, зөвлөмж гэсэн үндсэн бүтэцтэйгээр боловсруулдаг.

ОХШҮ-ний тайлангийн загварыг Хүснэгт 5.1.1-ийн дагуу боловсруулж болно.

Хүснэгт 5.1.1 ОХШҮ-ний бичмэл тайлангийн бүтэц

№	Тайлангийн бүтэц	Тайлбар
---	------------------	---------

1	Нүүр хуудас	- ОХШҮ-ний тайлангийн нэр - Тайлангийн нэр урт биш, ойлгомжтой, ОНЖДХ дэх аль зорилтуудын хүрээнд асуудлыг шинжилсэн асуулга, байршил болон хугацааг бичнэ
2	Товчилсон үгийн жагсаалт	Тайланд ашигласан нэр томьёо, товчилсон үгийг цагаан толгойн дарааллаар задалж бичнэ.
3	Хураангуй	-Шийдвэр гаргагчид болон завгүй уншигчдад зориулсан товч, агуулгаар хураангуйлан бичнэ. -Энэ хэсэгт ОХШҮ-ний үр дүн, дүгнэлтийг түлхүү оруулдаг.
4	ОХШҮ-ний танилцуулга	-Үндэслэл, ОХШҮ-ний аргачлалаар ОНЖДХ-ийг яагаад үнэлэх болсон талаарх тайлбар -ОХШҮ-ний зорилго, зорилтууд, хамрах хүрээ
5	ОХШҮ-ний арга зүй	ОХШҮ-ний аргачлал, түүвэрлэлт, мэдээлэл боловсруулалт, дүн шинжилгээ
6	Үр дүн	ОХШҮ-ний үр дүнгээ 2 агуулгын хүрээнд бичнэ. Үүнд: 1. Оролцооны хяналт шинжилгээ 2. Оролцооны үнэлгээ)
7	Дүгнэлт	Үр дүнд тулгуурлан ОХШ-ээр болон ОУ-ээр дэвшүүлсэн асуултанд ямар хариулт буюу үр дүн гарсныг тайлбарласан байна.
8	Сургамж, хязгаарлагдмал тал	ОХШҮ-г хийх явцын бэрхшээл, сургамж, шийдвэрлэлт, цаашид анхаарах, асуудлын талаар дурдана. Үүнд: ОХШҮ хийхэд хүний нөөц, санхүүжилт, арга зүй, цаг хугацаа, оролцогчдын өгсөн мэдээлэлд хамаарах хязгаарлагдмал хүчин зүйлс гэх мэт
9	Зөвлөмж	ОХШҮ-ээс гарсан дүгнэлтэд тулгуурлан ОНЖДХ-ийн хэрэгжүүлэгч, үр шимийг хүртэгч талуудад чиглэсэн цаашид ямар өөрчлөлт хийхийг ач холбогдлоор нь эрэмбэлэн зөвлөмжилж болно. Шийдвэр гаргагч нарт бодлого, төлөвлөлт хийхэд нь зайлшгүй шаардлагатай нотолгоо, үр дүнд тулгуурлан боловсруулна.
10	Хавсралт	-Ярилцлагад хамрагдсан хүмүүсийн бүртгэл -ОХШҮ-д ашиглагдсан бичиг баримт -Оролцоот аргачлалын баримт -Асуулгын хуудас, чанарын судалгааны удирдамж -Багийн гишүүдийн дэлгэрэнгүй мэдээлэл -Зөвлөлдөх уулзалтад оролцогчдын бүртгэл -Үйл ажиллагааны зураг гэх мэт

2.ОХШҮ-ний үр дүнг танилцуулах

ОХШҮ-ний үр дүнг оролцогч талууд, үр шим хүртэгчдэд сонгох зорилгоор бэлтгэсэн эхийг илтгэл гэнэ. Илтгэл бэлтгэхдээ дараах үе шатны дагуу гүйцэтгэнэ. Үүнд:

1. Илтгэлийн агуулга болон ОХШҮ хийсэн багийг товч танилцуулах
2. ОХШҮ хийсэн зорилго, арга зүй
3. ОХШҮ-ний үр дүн
4. Дүгнэлт
5. Зөвлөмж

Таны слайдууд баримт бичиг биш самбар байх ёстой. /Lee Jackson/

Компьютерт илтгэл бэлтгэхэд анхаарах зүйл: Үүнд:

1. Энгийн, товч тодорхой, анхаарал татахуйц байлгах
2. Их хэмжээний текстээс татгалзаж, аль болох буллет поинт ашиглах, 6х6 дүрэм буюу нэг слайд 6 мөр, 6 баганаас хэтрэхгүй байх
3. Олон өнгө холих, ойлгомжгүй зураг, дүрслэл болон анимейшн ашиглахаас татгалзах

4. Зөв чанартай, тохиромжтой зураг, хүснэгт ашиглах, 3D график ашиглахаас татгалзах
5. Тохиромжтой үсгийн фонд сонгох, үсгийн хэмжээ нь хамгийн багадаа 24 pt, үндсэн 32 pt, үндсэн текст 28 pt байх
6. Тоон мэдээллийг инфографикаар харуулах
7. Цаг баримталж слайдаа бэлтгэнэ. Хэрэв 10 минутын илтгэл тавихаар төлөвлөсөн бол слайд бүрт нэг минут тооцоолон 10-15 слайд бэлтгэнэ.
8. Хэт хурдан эсвэл удаан ярихаас зайлсхийх, тоон мэдээлэл, гол үр дүн, мессежийг хүргэх тохиолдолд түр зогсолт хийж ярих
9. Асуултанд хариулахдаа оролцогчид руу хараагаа тогтоож хариулах
10. Төгсгөлийн слайдыг эерэгээр дуусгахад анхаарах

Сайн илтгэл гэдэг бол хэлэлцүүлэг байдаг. Шинэлэг, сонирхолтой, бөгөөд хэцүү асуулт эсвэл хэзээ ч сонгож байгаагүй баримт, жишээнээс эхлүүлж болно. Заримдаа илтгэлээ ямар нэгэн зураг, хүснэгт эсвэл графикаар эхлүүлэх нь тохиромжтой байдаг. Зураг, диаграмм, бүдүүвч схем зэргийг ашиглан үр дүн, дүгнэлт, зөвлөмжөө танилцуулах нь үр дүнтэй байдаг.

3.ОХШҮ-ний үр дүнгээр бодлогын зөвлөмж боловсруулах

Бодлогын зөвлөмж нь аймгийн Жендэрийн салбар зөвлөлийн дарга болон бусад шийдвэр гаргах албан тушаалтан нарт зориулсан бодлогын зөвлөгөө юм. Бодлогын зөвлөмж нь олон талаараа төрийн бодлого боловсруулах, нэвтрүүлэх, гаргасан бодлогоо эргэн харах, сайжруулахад нь нөлөөлөх учиртай. Энэ нь шийдвэр гаргагч нарт үр дүнтэйгээр нөлөөлөхүйц, товч тодорхой, үндэслэл бүхий нотолгоонд суурилсан тоо баримт, кэйсийг агуулсан байх ёстой.

Бодлогын зөвлөмж ямар бүтэцтэй байх вэ?

БЗ нь дараах стандарт хэлбэртэй байна. Үүнд:

- Бодлогын асуудлыг тодорхойлох
- Үндэслэл бүхий нотолгоо, нөхцөл байдлыг шинэчлэх
- Хувилбаруудыг тодорхойлох
- Хамгийг сайн бодлогыг сонгох
- Шаардлагатай зөвлөмжийг санал болгох

Эхний болон төгсгөл хэсгээс бусад нь дүн шинжилгээ бүхий хэсгүүд юм. БЗ-ийг 2 янзаар боловсруулдаг. Үүнд:

Шууд бүтэц	Шууд бус бүтэц
<ul style="list-style-type: none"> • Тулгамдсан асуудал • Зөвлөмж • Дүн шинжилгээ 	<ul style="list-style-type: none"> • Асуудал • Дүн шинжилгээ • Зөвлөмж

Хүснэгт 5.3.1 Бодлогын зөвлөмж боловсруулах зааварчилгаа

	ОНЖДХ-ийн хэрэгжилт	
	Анхаарах асуудал	Зөвлөмж
Төлөвлөлт	<ul style="list-style-type: none"> • Ахиц тодорхой бус • Нарийвчилсан төлөвлөгөө байхгүй, хэлбэр төдий боловсруулагдсан • Нотолгоонд суурилагагүй 	<ul style="list-style-type: none"> • Ахиц тодорхой байх • Нарийвчилсан төлөвлөгөөтэй байх • Нотолгоонд суурилсан байх
Хэрэгжилт	<ul style="list-style-type: none"> • Хараат бус байдал алдагдсан • Төлөвлөгөөний биелэлтийн хувийг дүнгээр хэмждэггүй • Санхүүжилт тодорхой бус • Иргэдийн дуу хоолой сул 	<ul style="list-style-type: none"> • Хараат бус байдал алдагдаагүй байх • Төлөвлөгөөний биелэлтийн хувийг дүнгээр хэмжих • Зарцуулсан санхүүжилт тодорхой байх • Иргэд, ИНБ-уудын оролцоотой ОХШҮ-ний багтай байх
Тайлагналт	<ul style="list-style-type: none"> • Ил тод мэдээлдэггүй • Иргэдийн санал хүсэлтийг харгалзах тогтолцоо бүрдээгүй • Мэдээллийн сан байхгүй • Зохион байгуулалт сул 	<ul style="list-style-type: none"> • Нийтэд ил тод мэдээлэх • Иргэдийн санал хүсэлтийг авах тогтолцоотой • Мэдээллийн сантай байх, тогтмол мэдээллээр хангах • Зохион байгуулалт, хамтын ажиллагааг сайжруулах

Сайн боловсруулсан БЗ-ийн шинжүүд:

- Товч тодорхой
- Агуулга нь тодорхой, уншихад ойлгомжтой, тодорхой
- Сүүлийн үеийн үнэн зөв, харьцуулсан бодит мэдээлэлд үндэслэсэн байх

Дорнод аймгийн ОХШҮ-ний багийн хийж гүйцэтгэсэн бодлогын зөвлөмжийг жишээ болгон хавсаргав.

Жишээ 5.3.1 Зөвлөмж

ЗӨВЛӨМЖ

ОХШҮ-ний дүгнэлтэнд тулгуурлан дараах санал, зөвлөмжүүдийг бодлого боловсруулагч болон шийдвэр гаргагчдад хүргүүлж байна. Үүнд:

-Жендэрийн хүний нөөц, чадавхийг нэмэгдүүлэх, салбар хоорондын жендэрийн бодлого, зохицуулалтыг үр дүнтэй хийж хэрэгжилтийг ханган ажиллах

-Төрийн байгууллагын төсөв боловсруулах, тайлан мэдээ гаргах, хяналт шинжилгээ хийх зэрэг ажлуудыг хариуцан хийдэг мэргэжилтэн нарыг чадавхжуулах

-ЖЭТБ-ыг хангах дэд хөтөлбөр болон бусад нийгмийн чиглэлийн төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилтэнд хөндлөнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг тогтмолжуулах, ОХШҮ-ний аргачлалыг нутагшуулах

-Орон нутгийн түвшинд гаргасан хүйсээр ангилсан статистик үзүүлэлтүүдийг холбогдох төр, иргэний нийгмийн байгууллагын ажилтан нарт хүргүүлэх, жендэрийн статистикийг орон нутгийн бодлого төлөвлөлтөнд ашиглах

- Дэд хөтөлбөрийн зорилтуудыг хангахуйц төсвийг төлөвлөж байх, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулахдаа хөтөлбөрийн үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлттэй уялдуулж, биелэлтийг түүнд нийцүүлэн үнэлж байх

-Гадаадын олон улсын байгууллагаас жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр хийж буй ажлуудын талаарх мэдээллийг олон нийтэд түгээн дэлгэрүүлэх

-Нийгмийн амьдралын хүрээнд жендэрийн эрх тэгш байдлын зарчмыг амжилттай хэрэгжүүлж буй улс орнуудын туршлагаас суралцах, үндэсний болон орон нутгийн хэмжээнд гарсан жендэрийн тэгш эрхийн талаарх сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх

-Дэд хөтөлбөрийн хэрэгжилийн явцад хийсэн хөндлөнгийн үнэлгээний ажлын дүгнэлт зөвлөмжийн дагуу ажлын төлөвлөгөө гарган хэрэгжилтийг ханган ажиллах

Дорнод аймгийн ЖЭТБХ дэд хөтөлбөрийн хүрээнд “Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн ажил олгогч, ажиллагсдын ЖЭТБ-ын талаарх ойлголт мэдлэг болон жендэрийн мэдрэмжтэй төлөвлөлт, ажлын байрны нөхцөл байдал, “Эрэгтэйчүүдэд үзүүлж буй эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж”-ийг орон нутгийн жендэрийн тулгамдсан асуудал хэмээн үзэж ОХШҮ-ний ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

1.Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн ажил олгогч болон ажиллагсдын ЖЭТБ-ын талаарх ойлголт мэдлэг болон жендэрийн мэдрэмжтэй төлөвлөлт, ажлын байрны нөхцөл байдлыг тодорхойлох асуудлаар:

- Ажлын байрыг жендэрийн мэдрэмжтэй болгоход чиглэсэн бодлогыг орон нутгийн ҮЭ-ийн байгууллагатай хамтран боловсруулж, аж ахуйн нэгжид мөрдүүлэх арга хэмжээ авах
- Хувийн хэвшлийн болон ААН байгууллагын ажиллагсдад жендэрийн асуудлаар сургалт мэдээллийн ажиллагаа зохион байгуулах, тэдэнд зориулсан жендэрийн цахим сургалтын модуль боловсруулан нэвтрүүлэх
- Төр, хувийн хэвшил болон олон нийтийн байгууллагын удирдах ажилтан нарт эрэгтэй, эмэгтэй ажилтан нарын ар гэрийн амьдралын тэнцвэрийг хангах талаар мэдлэг ойлголт өгч, зохицуулалт бий болгох
- Хувийн хэвшлийн байгууллага болон ААН байгууллагын хөдөлмөрийн харилцаан дахь жендэрийн тулгамдсан асуудал болон хөдөлмөрийн нөхцөл байдлыг тодорхойлсон үнэлгээ, судалгааны ажил хийх
- Ажил олгогч, хувийн хэвшлийн байгууллагын удирдах ажилтан нарт зориулсан цахим сургалтын модуль боловсруулан хэрэгжүүлэх, байгууллагын дотоод журам, бодлогын бичиг баримтуудыг жендэрийн агуулгатай болгох
- Жендэрийн аудитыг хувийн хэвшлийн байгууллагуудад хийж эхлэх, жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр төр, ИНБ-уудтай хамтарч ажиллах

2.Эрэгтэй эмэгтэй хүмүүсийн нийгмийн үйлчилгээг тэгш, хүртээмжтэйгээр хүртэх боломжийг нэмэгдүүлэх чиглэлийн хүрээнд “Эрэгтэйчүүдэд үзүүлж буй эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж”-ийг тодорхойлох

2.1 “Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг хамгаалах хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг ханган ажиллах, Үүнд:

Бүх шатны бодлого боловсруулагчид, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгчид, төр, ААН, хувийн хэвшлийн байгууллага, хамт олон, гэр бүл болон эрэгтэйчүүдэд, эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн асуудлын чухлыг сурталчлах, ойлгуулах зорилтын хүрээнд

- Шийдвэр гаргагчдад эрэгтэйчүүдийн эрүүл мэнд, түүнд сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлсийн талаар нөлөөллийн үйл ажиллагаа явуулах
- Эрэгтэйчүүд, гэр бүл, хамт олон, нийгэмд эрэгтэйчүүдийн эрүүл м эндийн тулгамдсан асуудлыг таниулж оролцоог нэмэгдүүлэх
- Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчдэд эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн онцлог хэрэгцээг ойлгуулахад чиглэсэн сургалт, сурталчилгаа зохион байгуулах

Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн онцлог хэрэгцээнд нийцсэн, гэр бүл, хамт олонд тулгуурласан эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хөгжүүлэх зорилтын хүрээнд:

- Эрэгтэйчүүд хөвгүүдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний багцыг тусламж үйлчилгээний шатлал бүрээр тодорхойлох
- Эрүүл мэндийн хоёрдах шатлалын байгууллагад эрэгтэйчүүд, хөвгүүдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний бүтцийг одоогийн тогтолцоонд түшиглэн байгуулах, түүнд шаардлагатай нөөцийг бүрдүүлэх
- Эрэгтэйчүүдэд эрүүл мэндийн ээлтэй тусламж, үйлчилгээ үзүүлэх хүний нөөцийг бэлтгэх, чадавхжуулах
- Эрэгтэйчүүдийн амьдралын эгзэгтэй мөчүүдэд тулгарах сэтгэл зүй, эрүүл мэндийн асуудлуудад зөвлөгөө өгөх бүтцийг төрийн болон төрийн бус, хувийн хэвшлийн байгууллагуудын хамтын ажиллагаанд түшиглэн хөгжүүлэх

Эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг эрчимжүүлэх замаар эрэгтэйчүүдийн эрсдэлт зан үйлийг өөрчлөх зорилтын хүрээнд:

- Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн эрсдэлтэй зан үйлийг өөрчлөхөд чиглэсэн мэдээлэл харилцаа, ухуулга нөлөөллийн үйл ажиллагааг бусад төсөл хөтөлбөрүүдтэй уялдуулах
- Жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эрүүл мэндийн дэмжих хөдөлгөөнийг бүх нийтэд өрнүүлэх
- Эрүүл зан үйлийг төлөвшүүлэх мэдээлэл, сургалт, сурталчилгааг оновчтой арга хэлбэрээр, тасралтгүй зохион байгуулах
- Цэргийн насны эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх үйл ажиллагааг хүчний байгууллагатай хамтран зохион байгуулах

Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн асуудлаар судалгаа, шинжилгээний ажлыг өргөжүүлж, эрэгтэйчүүд судлалыг хөгжүүлэх

- Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн байдлын дүн шинжилгээт мэдээллээр хангах
- Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн онцлог асуудлаар судалгаа хийх
- Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн асуудлаарх судалгааны чадавхийг дэмжих

2.2 “Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг хамгаалах” хөтөлбөрийн дээрх зорилтуудыг хангах арга хэмжээний хүрээнд 2021 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг гаргаж шаардлагатай төсвийг аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцэж батлах, хэрэгжилтийг ханган ажиллах

6. ҮЕ ШАТ 6. ОХШҮ-НИЙ ҮР ДҮНД ТУЛГУУРЛАН ШИЙДВЭР ГАРГАГЧДАД ХЭРХЭН НӨЛӨӨЛӨХ ВЭ? МЭДЭЭЛЛИЙГ ХЭРХЭН ТҮГЭЭХ ВЭ?

ОХШҮ-ний бодлогын зөвлөмжийг гаргасны дараагаар өөрчлөлтийг шийдвэрт тусгуулах буюу өөрчлөлтийг институтчлэхийн тулд нөлөөллийн үйл ажиллагаа явуулах шаардлага үүсдэг. ОНЖДХ-ийн ОХШҮ-г гүйцэтгэсэн баг үр дүнг шийдвэрт тусгуулахын тулд:

а. Оролцогч талд мэдээллийг хэрхэн хүргэх

б. Оролцогч талуудтай зөвлөлдөх,

в. Шийдвэр гаргагчдад нөлөөлөх гэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

1.Оролцогч талд мэдээллийг хэрхэн түгээх вэ?

Олон нийт, иргэд, үр шим хүртэгч зэрэг оролцогч талуудад мэдээлэл түгээхдээ эдийн засгийн өртөг багатай, хүртээмж сайтай сувгуудыг өргөн ашиглах хэрэгтэй.

Үүнд:

- **Цахим хэрэгсэл ашиглах** (Орон нутгийн төрийн байгууллагын цахим хуудас, facebook, twitter, instagram, youtube зэрэг мэдээллийн суваг ашиглах, пэйж хуудас бүлэг нээн танилцуулга/пост/ оруулах, блогт мэдээлэл бэлтгэн түгээх)
- **Бусад хэлбэрийг ашиглах** (Олон нийтийн хурал, уулзалт, хэлэлцүүлэг зэргийг зохион байгуулах, орон нутгийн ТВ, радио, сонин хэвлэл зэргийг ашиглах, хэвлэлийн мэдээ бэлтгэн түгээх, олон нийтийг хамруулсан флаш мобил, аян зохион байгуулах)

Хэвлэлийн мэдээ хэрхэн бэлтгэх вэ?

Хэвлэлийн мэдээ гэдэг нь хэвлэл мэдээллээр дамжуулахаар бэлтгэсэн мэдээллийн товчоон буюу зурвас юм.

Хэвлэл мэдээллээр дамжуулан орон нутгийн иргэд, олон нийтэд мэдээлэл түгээхдээ өргөн ашигладаг хэрэгсэл. Хэвлэлийн мэдээг дараах загвараар бэлтгэдэг.

Үүнд:

1. Хэвлэлийн мэдээний гарчиг нь хэвлэл мэдээллийн ажилтан, байгууллагын анхаарлыг татахуйц, мэдээллийн агуулгыг бүрэн дүүрэн илэрхийлсэн байна.
2. Хаанаас ямар байгууллагын дэмжлэг, захиалгаар ямар байгууллага, баг ОХШҮ-г гүйцэтгэсэн тухай өгүүлнэ.
3. **Үндсэн хэсэг:**
 - a. хэдий хугацаанд, хэн/баг/ОНЖДХ-т ОХШҮ-г ямар зорилтын хүрээнд хийсэн тухай
 - b. ОХШҮ хийснээр ямар гол үр дүнд хүрсэн тухай олон нийтэд илүү хамаатай хэсгийг
 - c. Цаашид юу хийх шаардлагатай зөвлөмж
4. Холбоо барих

Жишээ 6.1.1 Дорнод аймгийн ОХШҮ-ний багийн бичсэн хэвлэлийн мэдээ



ХЭВЛЭЛИЙН МЭДЭЭ
2021.02.10

ДОРНОД АЙМГИЙН ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ ДЭД ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТЭНД ОРОЛЦООТ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙЖЭЭ.

Дорнод Аймгийн “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөр”-ийн хэрэгжилтэнд “Оролцоот хяналт шинжилгээ үнэлгээний аргачлал”-аар үнэлгээ хийж, санал зөвлөмж боловсруулан, иргэд, олон нийттэй зөвлөлдөх үйл ажиллагааг зохион байгуулах зорилгоор “Иргэний нийгмийн оролцоотой жендэрийн тэгш байдлыг хангах” (TA9750-MON) техник туслалцааны төслийг Жендэрийн Үндэсний хорооны удирдлагаар Дорнод аймгийн ИНБ-уудаас 2020 оны 10-р сарын 02-ны өдрөөс 2021 оны 02-р сарын 10-ны өдрийг хүртэл хугацаанд хэрэгжүүлээ.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр ажиллаж буй төрийн байгууллага, түүний удирдах ажилтан, мэргэжилтнүүд болон хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах үүрэг бүхий бодлого тодорхойлогч,

бодлогыг хэрэгжүүлэгч нарын зүгээс орон нутгийн бодлогын бичиг баримт, холбогдох хууль дүрэм журмын хүрээнд 2018-2020 онд хийж гүйцэтгэсэн ажлын тайлантай танилцаж Аймгийн жендэрийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтэнд үнэлгээний ажлыг хийлээ.

ОХШҮ-ний ажлын дүн шинжилгээнд тулгуурлан ОНЖДХ дэд хөтөлбөрт тусгагдсан “Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн ажил олгогч болон ажиллагсдын “ЖЭТБ-ын талаарх ойлголт мэдлэг болон жендэрийн мэдрэмжтэй төлөвлөлт, ажлын байрны нөхцөл байдал” болон “Эрэгтэйчүүдэд үзүүлж буй эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх” гэсэн 2 асуудлыг орон нутгийн жендэрийн тулгамдсан асуудал хэмээн үзэж ОХШҮ-ний багаас тодруулан судалсан байна.

ОХШҮ-ний ажлын үр дүн, дүгнэлтэнд үндэслэн бодлого боловсруулагч, шийдвэр гаргагч нарт зориулан ОХШҮ-ний багаас бодлогын зөвлөмж гаргасан байна. Үүнд: ЖЭТБ-ыг хангах дэд хөтөлбөрийн удирдлага зохион байгуулалт, хяналт шинжилгээ үнэлгээний ажлын хэрэгжилтийг сайжруулах талаар зөвлөмжинд: Төрийн байгууллагын салбар, нэгжүүдэд жендэрийн асуудал хариуцсан мэргэжилтнийг ажиллуулах, ажил үүргийн тэнцвэрт байдлыг хангуулах талаар зөвлөмж, зааварчилгаа өгөх, Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагуудын салбарын жендэрийн нэгдсэн бодлогыг үндэсний болон орон нутгийн дэд хөтөлбөрийн зорилтуудтай уялдуулж төлөвлөх, ажлын гүйцэтгэлд хяналт тавих”, “Орон нутгийн төрийн байгууллагын бодлого боловсруулах, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, тайлан мэдээ гаргах, хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтнүүдийг жендэрийн асуудлаар чадавхжуулах”, “Орон нутгийн салбар, нэгжүүд өөрсдийн гаргаж буй хүйсээр ангилсан статистик мэдээллийн нэр төрлийг нэмэгдүүлэхэд тусгайлсан төлөвлөгөө, төсвийг гаргаж ажиллах” гэсэн саналуудыг тусгасан байна.

“Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн ажил олгогч, ажиллагсдын жендэрийн талаарх ойлголт мэдлэг болон жендэрийн мэдрэмжтэй төлөвлөлт, ажлын байрны нөхцөл байдлыг сайжруулах талаар зөвлөмжинд: “Хувийн хэвшлийн байгууллагын удирдах ажилтан болон ажиллагсдад жендэрийн асуудлаар сургалт мэдээллийн ажиллагаа зохион байгуулах, “Байгууллагын дотоод журам, бодлогын бичиг баримтуудыг жендэрийн агуулгатай болгох, Жендэрийн аудитыг хийж эхлэх, “Байгууллагын жендэрийн тулгамдсан асуудлаар үнэлгээ, судалгааны ажлыг хийх зэрэг асуудлыг санал болгожээ.

Эрэгтэй эмэгтэй хүмүүсийн нийгмийн үйлчилгээг тэгш, хүртээмжтэйгээр хүртэх боломжийг нэмэгдүүлэх чиглэлийн хүрээнд “Эрэгтэйчүүдэд үзүүлж буй эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж”-ийг сайжруулах ажлын талаар зөвлөмжид: Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчдэд эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн онцлог хэрэгцээг ойлгуулахад чиглэсэн сургалт, сурталчилгаа зохион байгуулах, Эрүүл мэндийн хоёр дахь шатлалын байгууллагад эрэгтэйчүүд, хөвгүүдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний бүтцийг одоогийн тогтолцоонд түшиглэн байгуулах, Эрэгтэйчүүдэд үзүүлэх нийгмийн эрүүл мэндийн тусламж, сэтгэл заслын зөвлөгөө өгөх болон андрологийн тусламж үзүүлэх эмч мэргэжилтнийг БОЭТ болон сум, өрхийн эрүүл мэндийн төвийн түвшинд бэлтгэх, чадавхжуулах, Хувийн хэвшлийн аль нэг үүдэн эмнэлгийг түшиглэн эрэгтэйчүүдийн үүдэн эмнэлэг байгуулах, Цэргийн насны эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн онцлог асуудлаар судалгаа хийх, “Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг хамгаалах” хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах арга хэмжээний хүрээнд төрийн болон ИНБ-уудын хамтарсан ажлын хэсэг байгуулан хэрэгжилтийг ханган ажиллах зэрэг асуудлыг тусгасан байна.

Цаашид ОХШҮ-ний ажлын тайлан, бодлогын зөвлөмжийг орон нутгийн удирдлагад хүргэх, зохих шийдвэр гаргахад нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулахаар орон нутгийн ИНБ-уудаас төлөвлөөд байна

Холбоо барих

1. Утас: 99286761, 99589989
2. И-мэйл хаяг: ngodornod@gmail.com
3. Page: “Дорнод аймгийн Иргэний нийгмийн байгууллагуудын зөвлөл” албан ёсны хуудас

2. Талуудын зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулах

Талуудын оролцоотой зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулснаар ОНЖДХ-т ОХШҮ хийснээр ямар дүгнэлтэд хүрч, цаашлаад ямар өөрчлөлтийг хийх шаардлагатай болохыг гүйцэтгэгч багаас товч танилцуулан, талуудын оролцоог тэгш хангаж, тэдний байр суурь, санаа бодлыг сонсож жендэрийн бодлогод талуудын оролцоо, хамтын ажиллагааг бүрдүүлэхэд чухал үүрэгтэй юм.

Зөвлөлдөх уулзалтыг дараах алхамаар төлөвлөж хэрэгжүүлнэ.

Үүнд:

- Зөвлөлдөх уулзалтаас юу хүлээж байгааг багийн түвшинд хэлэлцэн тохиролцоно. ОХШҮ-ний талаар нэгдмэл мэдээлэлтэй болж цаашид ямар өөрчлөлт хийх талаар оролцогчдын саналыг сонсох
- Зөвлөлдөх уулзалтыг талуудын ялгаатай байдлаар тус тусад нь бүлэглэн эсвэл нэгдмэл байдлаар зохион байгуулах уу гэдгээ өмнө нь сонгоно. Санхүүгийн нөөц хязгаарлагдмал тул талууд бие биенийхээ саналыг сонсох боломжийг олгон нэгдмэл уулзалтыг зохион байгуулах нь оновчтой байж болох юм.
- Хэнийг оролцуулахаа шийднэ. Үүнд: Нутгийн иргэд, ТАХ, ААНБ-ын ажилтан, ажил олгогч нарын төлөөллийг ижил тоотой байхаар заавал оролцуулна. Хэлэлцүүлэг дээд тал нь 30 хүний бүрэлдэхүүнтэй байвал зохино.
- Зөвлөлдөх уулзалт зохион байгуулах үйл ажиллагааг төлөвлөнө.
- Зөвлөлдөх уулзалтыг 2-3 цаг байхаар зохион байгуулах
- Зөвлөлдөх уулзалт зохион байгуулах өрөө тасалгааг урьдчилан бэлтгэх
- Зөвлөлдөх уулзалтанд оролцогчдын ая тухтай байдлыг хангаж, цай хөнгөн хооллох боломжийг бүрдүүлэх
- Зөвлөлдөх уулзалтын явцыг баримтжуулах, хэлэлцүүлэгийг бүрэн тэмдэглэхийн тулд оролцогчдоос зөвшөөрөл аван, аудио бичлэг хийх
- Санал авахдаа оролцогч талуудын оролцоог хангаж багаар ажиллуулах, карт ашиглах зэрэг оролцооны зарим аргачлалыг ашиглах
- Зөвлөлдөх уулзалтын үр дүнг нэгтгэн ажилдаа тусгах, тайлан бичих хэрэгтэй. Оролцогчдын саналыг ОХШҮ-ний тайлан, бодлогын зөвлөмжид тусган, шийдвэр гаргагчдад ямар өөрчлөлт гаргуулахаар нөлөөлөл үзүүлэхээ тогтоно.

3. Шийдвэр гаргагчдад нөлөөлөх

Жендэрийн бодлого, үйл ажиллагааны төлөвлөлтөд өөрчлөлт оруулах болон төсөвлөлтийг шийдүүлэхэд нөлөөллийн ажил чухал үүрэгтэй.

Нөлөөллийн үйл ажиллагаа нь ЖЭТБ-ыг тогтооход доорх дэмжлэгийг үзүүлдэг. Үүнд:

- Жендэрийн асуудал хөгжлийн амин чухал асуудал болохыг оролцогч талуудад ойлгуулан, хөгжлийн аливаа бодлого үйл ажиллагаанд орхигдуулахгүйгээр тусгах боломжийг олгоно.
- Улс төрчид, Төрийн болон ТББ-ууд жендэрийн төдийгүй нийгмийн орхигдсон бүлгүүдийн асуудалд анхаарлаа хандуулахыг дэмжих таатай орчныг бүрдүүлнэ.
- Холбогдох хууль тогтоомж, дүрэм журамд жендэрийн асуудлыг тусгахад эерэгээр нөлөөлөх нөхцлийг бүрдүүлэхэд тустай юм (БСШУСЯ, АХБ, 2019)

Жендэрийн мэдрэмжтэй нөлөөлөл гэдэг нь жендэрийн холбогдолтой бодлого, хууль, тогтоомж, стратеги, үйл ажиллагаа зэргийг шинээр нэвтрүүлэх, өөрчлөх эсвэл тэдгээртэй холбоотой дэмжлэг авахыг зорьсон санаа нэгтэй, тууштай бүлэг хүмүүс, байгууллагаас хэрэгжүүлж буй зорилтот үйл ажиллагаа юм. (НҮБХАС, 2008)

Жендэрийн мэдрэмжтэй нөлөөллийн үйл ажиллагааг дараах алхамаар хэрэгжүүлнэ.

Үүнд:

Алхам 1. Нөлөөлөл явуулах асуудлыг сонгох

Алхам 2. Нөлөөллийн ажлын зорилго, зорилтуудыг тодорхойлох

Алхам 3. Нөлөөллийн ажлын оролцогч тал, зорилтот бүлгийг тодорхойлох

Алхам 4. Нөлөөллийн үйл ажиллагаанд хамтран ажиллах, дэмжлэг үзүүлэх түнш, хамтран ажиллагч, тэдгээрийн сүлжээг бий болгон идэвхижүүлэх

Алхам 5. Шийдвэр гаргагч нарт хүргэх илгээлтийг бэлтгэх

Алхам 6. Нөлөөллийн тохиромжтой сувгийг сонгох

Алхам 7. Нөлөөллийн арга хэрэгслүүдийг сонгох

Алхам 8. Үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах

Алхам 9. Хүлээгдэж буй үр дүн, амжилтын үзүүлэлтийг тодорхойлон үнэлэх

Алхам 1. Нөлөөлөл явуулах асуудлыг тодорхойлно.

Жишээ нь: ОНЖДХ-ийг баталсан атлаа төсвийн төлөвлөлтөнд үйл ажиллагааны зардал зохих ёсоор багтаагүй тохиолдолд түүнийг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсвийг төлөвлөлтөнд тусгуулах шийдвэрт нөлөөлөх шаардлага зайлшгүй гарна.

Алхам 2. Нөлөөллийн ажлын зорилго, зорилтуудыг тодорхойлох


Нөлөөллийн ажлын зорилго бол ямар үр дүнд хүрсэн байх вэ? гэсэн асуултын хариултаар тодорхойлогдоно.

Богино хугацааны зорилт	Орон нутгыг хөгжүүлэх нийгэм-эдийн засгийн үндсэн чиглэлд ЖБ-ын үйл ажиллагааны зардлыг тусгуулах
Дунд хугацааны зорилт
Урт хугацааны зорилт

Алхам 3. Нөлөөллийн ажлын оролцогч тал, зорилтот бүлгийг тодорхойлох

Оролцогч тал бүрт тохирсон нөлөөллийн аргуудыг ашиглах хэрэгтэй. Тийм учраас оролцогч талуудын зураглал гаргах нь чухал байдаг.

Бүдүүвч 6.1 Нөлөөлөлд оролцогч талуудын зураглал гаргах(Сангийн яам, 2015)



Дэмжигчид: Тухайн бодлогын өөрчлөлтийг гаргуулах сонирхолтойгоос гадна амжилтанд хүргэх нөлөө, эрх мэдэлтэй хүмүүс. Иймд тэдэнтэй хамтрах нь чухал.

Хамгаалагчид: Бодлогын өөрчлөлтийг гаргуулах сонирхол өндөр ч нөлөөлөх эрх мэдэл бага хүмүүс. Тэднийг мэдээллээр хангаж, зөвлөлдөж, оролцуулж байх шаардлагатай.

Нуугдмал агент: Бодлогын өөрчлөлтөнд анхаарлаа хандуулаагүй, оролцоогүй байгаа хэрнээ сонирхол нь төрвөл нөлөөлөх эрх мэдэл бүхий хүмүүс. Тэдний сонирхолыг татахаар нөлөөлөл үзүүлж, бодлогын өөрчлөлтөд татан оролцуулахад анхаарах нь чухал.

Онцын ач холбогдолгүй хүмүүс: Бодлогын өөрчлөлтийг сонирхохгүй, мэддэггүй, мөн нөлөөлөх эрх мэдэлгүй хүмүүс. Тэдний хандлагыг ажиглаж, мэдээллээр хангаж, мэдлэгийг нэмэх шаардлагатай.

Алхам 4. Нөлөөллийн үйл ажиллагаанд хамтран ажиллах, дэмжлэг үзүүлэх түнш, хамтран ажиллагч, тэдгээрийн сүлжээг бий болгон идэвхижүүлэх

Нөлөөллийн үйл ажиллагаанд хамтран ажиллах субъектүүдээ тодорхойлон, сүлжээнд нэгдсэнээр техник арга зүйн тусламж, хүн хүч болон хөрөнгө нөөцийг дайчлах оновчтой зохион байгуулахад чухал ач холбогдолтой. ОНЖДХ-ийн хувьд бодлогыг боловсруулагч, хэрэгжүүлэгч, үр шим хүртэгч, бусад дэмжлэг үзүүлэгч нарын нягт хамтын ажиллагаа бүхий сүлжээг бий болгох шаардлагатай.

Алхам 5. Шийдвэр гаргагч нарт хүргэх илгээлтийг бэлтгэх

Зорилтот бүлэгт ямар мэдээллийг хүргэх гэж байгаагаа илгээлтэнд тусгадаг. Илгээлтийг тодорхой, энгийн ойлгомжтой, оновчтой томъёолох хэрэгтэй бөгөөд шаардлагатай тохиолдолд олон нийтийн харилцааны мэргэжилтний туслалцааг авах нь зүйтэй. Илгээлтийн агуулга нь юуг өөрчилснөөр ямар үр дүнд хүрэхээр зорьж байгааг бүрэн тусгасан байна.

Жишээ 6.2

Орон нутгийн хөгжил дэх бидний оролцоо-Тав тухтай амьдрал
Жендэрийн тэгш байдал- Хөгжлийн түлхүүр г.м

Алхам 6. Нөлөөллийн тохиромжтой сувгийг сонгох

Илгээлтийг зорилтот бүлэгт хэн, мэдээллийн ямар суваг илүү богино хугацаанд, үр дүнтэйгээр хүргэж чадах вэ гэдгийг сайтар нягтлан сонгодог. Дараах сувгуудыг ашигладаг. Үүнд:

- a. Хэвлэл мэдээлэл (сэтгүүл, сонин, радио, ТВ)
- b. Интэрнэт эх сурвалжууд
- c. Нийгмийн сүлжээ (фейсбүүк, инстаграмм, твиттер, ютүүб г.м)
- d. Байгууллагын дотоод сүлжээ
- e. Тараах материал, постер, зурагт хуудас, шторк
- f. Эрдэм шинжилгээний хурал, семинар, хэлэлцүүлэг, форум
- g. Аян, чуулган, флаш мобил зэрэг олон нийтийг хамруулсан үйл ажиллагаа г.м

Алхам 7. Нөлөөллийн арга хэрэгслүүдийг сонгох

Нөлөөллийн үйл ажиллагаанд лобби чухал үүрэгтэй. Лоббид хэвлэмэл болон хэвлэмэл бус хэлбэрээр мэдээллийг түгээх, илтгэл танилцуулга хийх, хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэл түгээх, богино хэмжээний видео, аудио, дижитал хэрэгсэл ашиглах, шахалт үзүүлэх (жагсах, захидал илгээх г.м) зэрэг аргуудыг ашигладаг.

Лобби хийхдээ дараах үндсэн арга замыг ашиглаж болно.

- **Нүүр тулсан уулзалт хийх.** Уулзалтанд сайтар бэлтгэх шаардлагатай. Уулзахаар зөвшөөрсөнд шийдвэр гаргагчид талархал илэрхийлэн асуудал, түүний шийдлийн талаарх санал, хувилбараа товч бөгөөд тодорхой илэрхийлнэ. (Үе шат 5)
- **Хэлэлцүүлэг зохион байгуулах.** Хэлэлцүүлэгийг яагаад хийх шаардлагатай болох, зохион байгуулахдаа хэнтэй, юуны тухай, хэзээ, хаана, яаж зохион байгуулах нь зүйтэйг төлөвлөж хэрэгжүүлэх шаардлагатай. ОХШҮ-ний хувьд шийдвэр гаргагчдад үр дүн, гаргасан бодлогын зөвлөмжийг танилцуулж, холбогдох шийдвэр гаргуулахад нь түлхэц болохуйц логик тайлбартайгаар сайтар бэлтгэж зохион байгуулна. Хэлэлцүүлэгийн үеэр нөлөөллийн үйл ажиллагаа төгсөх бус, хэлэлцүүлэгт оролцогчдын асуулт, саналд тулгуурлан засварласан танилцуулгыг шийдвэр гаргагчдад хүргүүлэн, шийдвэрт нөлөөлөх үйл ажиллагаа үргэлжилнэ.
- **Утсаар ярилцах.** Шийдвэр гаргагчтай нүүр тулан уулзах боломжгүй байгаа нөхцөлд энэ аргыг ашигладаг. Утсаар ярихдаа ярилцлагад бэлдэж байгаагийн адил бэлтгэлтэй байх ёстой бөгөөд баримтлах дэг, горим нь ижил байна.
- **Захидал бичих.** Лобби хийхэд хангалттай цаг хугацаа, хөрөнгө санхүүгийн боломжтой нөхцөлд захидал хэлбэрээр хийдэг.

Шийдвэр гаргагч ирүүлсэн мэдээллийг аваад үр дүн хийгээд үр ашгийн хувьд гарцаагүй чухал, зайлшгүй хэрэгжүүлбэл зохих арга мөн гэдэгт итгэл үнэмшил төрсөн тохиолдолд л шийдвэр гаргадаг.

Алхам 8. Үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах

Оролцогч талуудын оролцоотойгоор логик дараалал бүхий үйл ажиллагааг хаана, хэзээ явуулах тухай нарийвчилсан төлөвлөгөө гаргах шаардлагатай.

Төлөвлөгөөг дараах загвараар хийж болно.

Нөлөөллийн асуудал	Нөлөөллийн зорилт	Зорилтот бүлэг	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	хэзээ	хаана	Хэн хариуцах

Алхам 9. Хүлээгдэж буй үр дүн, амжилтын үзүүлэлтийг тодорхойлон үнэлэх

Нөлөөллийн үйл ажиллагааны алхам буюу үе шат бүр амжилттай хэрэгжсэн эсэхийг үнэлэн тодорхойлох чухал алхам.(НҮБХАС, 2008)

Бид одоогоор юу хийгээд байна?, юу энэ ажлыг илүү сайн үр дүнд хүргэх боломжтой байсан бэ?, бидний үйл ажиллагаанд хэн хэн хамрагдсан бэ?, нөөц адил тэгшээр хуваарилагдсан уу гэх мэт асуултанд хариулан, нөлөөллийн ажлыг сайжруулахад анхаарах асуудлыг тодруулна.

Ашигласан материал

ЖЭТБ тухай хууль (2011)

ДА (2018) ЖЭТБХДХ

ЖҮХ (2020) “Орон нутгийн Жендэрийн дэд хөтөлбөрт оролцооны хяналт шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал” сургалтын гарын авлага

ЖҮХ (2015) Жендэр судлал сэтгүүл

БСШУСЯ, ШХА, МУБИС, НБХСХ (2018) Боловсрол дахь жендэр

БСШУСЯ, ШХА, МУБИС, ДБШТ (2019) Дээд боловсролд ЖЭТБ-ыг хангах нь

ННФ (2007) Мониторингийн гарын авлага

МЕРИТ (2019) Жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлт

МОНЭС (2016) Жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх мэдлэг, хандлага, чадвар олгох хичээлийн гарын авлага I, II, III

МОНЭС (2017) Жендэрийн эрх тэгш байдал, эмэгтэйчүүдийн эрх

ДА (2018) ЖЭТБХДХ

Дэлхийн банк (2001) Хөгжлийг жендэрийн агуулгатай болгох нь

ЖҮХ (2016) Жендэрийн бодлогын баримт бичиг боловсруулах нэгдсэн удирдамж

ЖҮХ (2021) “Иргэний нийгмийн оролцоотой жендэрийн тэгш байдлыг хангах нь” төслийн тайлан

НҮБХАС (2008) Жендэрийн мэдрэмжтэй нөлөөллийн үйл ажиллагаа

ЛЭОС 2014 “Хүний эрх, жендэр, сайн засаглал” сургалтын гарын авлага

Дэлхийн банк (2017) Нийгмийн эгэх хариуцлагын арга хэрэгсэлүүд” гарын авлага I,II

ДЕМО (2014) “ Төрийн үйлчилгээг Иргэдийн онооны картын аргаар үнэлэх нь” гарын авлага

НДЭХ (2011) “Орон нутгийн хөгжилд иргэдийн оролцоо” гарын авлага

МЕРИТ (2020) Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн гарын авлага

1. Жендэр хэмээх ойлголтыг аль нь илэрхийлж байна вэ?

- Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах тухай ойлголт
- Эмэгтэйчүүдийн шийдвэр гаргах түвшин дэх оролцоог нэмэгдүүлэх тухай ойлголт
- Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн нийгэм, соёлын ялгаатай болохыг тайлбарласан ойлголт
- Хаана ч эрэгтэй, эмэгтэй хүмүүс тооны хувьд тэнцвэртэй байлгах тухай ойлголт
- Нийгэм дэх эрэгтэй эмэгтэй хүмүүсийн тэгш эрх, тэгш боломж, тэш оролцоо, тэгш байдал, эрх тэгш шийдвэрийн тухай ойлголт
- Бусад(бичнэ үү?)

2. Дараах бодомжуудыг уншаад зөв, буруу болохыг зохих нүдэнд нь ✓ тэмдэглэнэ үү?

Бодомж	Зөв	Буруу
1.Өрхийн тэргүүн эрэгтэй хүнийг илүү хүндэтгэх ёстой.		
2. Сайн эхнэр бол нөхрийнхөө үгэнд орох ёстой		
3. Эр хүн бол өрх гэр бүлээ авч явагч, тэжээгч		
4.Залуу эмэгтэйчүүд жирэмсэн болж, хүүхэдтэй болох тул ажилд авах хэрэггүй		

3. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах нь таны амьдралд хэр нөлөөтэй гэж үзэж байна вэ?

- Эерэг нөлөөтэй
- Ямар ч нөлөөгүй
- Сөрөг нөлөөтэй
- Мэдэхгүй

4. Та байгууллагынхаа хөдөлмөрийн харилцаан дахь жендэрийн эрх тэгш байдлыг дараах шалгуур үзүүлэлтүүдээр хэмжиж үнэлнэ үү?.

Үзүүлэлтүүд	Маш сайн	Сайн	Дунд	Муу	Маш муу
1.Хөдөлмөрийн эрүүл, аюулгүй байдал	5	4	3	2	1
2.Эрүүл мэндийг хамгаалах дэмжлэг	5	4	3	2	1
3.Ажлын ачааллын тэнцвэржүүлэлт	5	4	3	2	1
4.Албан тушаал ахих боломж	5	4	3	2	1
5.Ажлын байрандаа хөгжих боломж	5	4	3	2	1
6. Үзэл бодлоо илэрхийлэх	5	4	3	2	1
7.Шударгаар хөдөлмөрөө үнэлүүлэх, шагнал, урамшуулал авах	5	4	3	2	1
8.Нийгмийн хамгааллын тусламж дэмжлэг хүртэх	5	4	3	2	1
9.Мэдээллийн ил тод байдал	5	4	3	2	1
10. Ажил, ар гэрийн тэнцвэрийг хангах зохицуулалт хийсэн байдал	5	4	3	2	1

5. Танай байгууллагын хөдөлмөрийн харилцаанд жендэрийн эрх тэгш байдлыг алдагдуулсан дараах нөхцөл байдаг уу?.

Үзүүлэлтүүд	Их	Дунд	Бага	Байхгүй	Мэдэхгүй
1.Цалин хөлсийг ялгаатай тогтоох	5	4	3	2	1
2.Ажлын байрны дарамт, ялгаварлан гадуурхах	5	4	3	2	1
3.Хууль бусаар ажлаас халах, чөлөөлөх, ажилд авах	5	4	3	2	1
4. Авлига хээл хахууль өгөх, авах	5	4	3	2	1
5. Ажилчдын санал бодол шийдвэрт үл тусах	5	4	3	2	1

6. Танай байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд дараах хэм хэмжээнээс аль нь туссан байдаг вэ?. (олон сонголт хийж болно)

- Жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаархи ажил олгогч болон ажилтны эрх үүрэг хариуцлагын тухай
- Ажлын байранд жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, гарсан гомдлыг барагдуулах тухай
- Иргэнийг ажил авахад хүйсээр ялгаварлахгүй байх тухай
- Жендэрийн ялгаварлан гадуурхалт, бэлгийн дарамтын талаар ойлголт, мэдээлэл авах, сургалтад хамрагдах тухай
- Ар гэр, хүүхдийн асуудлаар чөлөө авах тухай

- f. Уурхайн ААН-ийн хувьд хүйсээр ангилсан ариун цэврийн өрөөгөөр хангах тухай
- g. Уурхайн ААН-н хувьд амьдрах байр, кempээр хангах тухай
- h. Уурхайн ААН-ийн хувьд эрэгтэй, эмэгтэй ажилтны росторыг ялгаатай тогтоох тухай
- i. Дээрх бүгд тусгагдаагүй
- j. Мэдэхгүй

7. Танай байгууллагын хамтын гэрээ, хэлэлцээрт дараах хэм хэмжээнээс аль нь туссан байдаг вэ?(олон сонголт хийж болно)

- a. Эмэгтэй, эрэгтэй ажилтанд ажил, гэр бүлийн үүргээ хослуулах тухай
- b. Хүүхэд төрүүлэх, асрах нөхцөл бололцоо олгох тухай
- c. Эрүүл мэнддээ анхаарах, хамгаалах тухай
- d. Хөдөлмөрийн аюулгүй нөхцөлд ажиллах тухай
- e. Ижил ажилд цалин, нэмэгдэл хөлс ижил хэмжээгээр тогтоох тухай
- f. Асуудал шийдэхэд талуудын оролцоог хангах, санал авах тухай
- g. Бусад.....(бичнэ үү?)
- h. Мэдэхгүй

8. Байгууллагын хөдөлмөрийн харилцаанд гардаг дараах асуудлуудаас танай байгууллагад аль нь байдаг вэ? (олон сонголт хийж болно)

- a. Ажлын байрны орон тооны зар мэдээнд нас, хүйс заах
- b. Мэдээлэл хүртээмжтэй авах боломжоор хангахгүй байх
- c. Аль нэг хүйсийг давуу гэж үзэх
- d. Ажил хөдөлмөр гүйцэтгэсэн өдрийн хөдөлмөрийн хөлсийг бүрэн олгохгүй байх
- e. Хүний нөөцийн бүртгэл судалгаа, хувь хүний ур чадвар, амжилтыг үл харгалзан ажилтныг албан тушаал дэвшүүлэх, шагнаж урамшуулах
- f. Шаардлагатай ажлын байр, нөхцөлд ажилтан авахдаа хүйсийн харьцааны тэнцвэртэй байдлыг харгалзахгүй байх
- g. Хөдөлмөрийн харилцаанд гарсан хүний эрхийн зөрчлийн талаарх өргөдөл, гомдлыг барагдуулахгүй байх, үл ойшоох

9. Таны ажил амралтын хоногийн харьцаа аль нь вэ?. (Уул уурхайн салбарт ажиллаж буй ажилтан хариулна)

- a. Ажил амралтын тэнцүү хуваарьтай
- b. Амрах хугацаанаасаа 7-20 хоногоор илүү ажилладаг
- c. Бусад.....(бичнэ үү?)

10. Таны өөрийн өмнө тулгамдаж буй асуудлаа сонгоно уу?

- a. Хөдөлмөрийн бүтээмж буурах
- b. Ажил мэргэжлээс шалтгаалах өвчин тусах
- c. Гэр бүлийн тогвортой харилцааг авч үлдэх
- d. Ажлын байр солих
- e. Бусад
(бичнэ үү?)

- f. Тулгамдсан асуудал байхгүй

11. Та Дорнод аймагт Жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөр хэрэгжиж байгаа талаар сонсож байсан уу?

- a. Тийм
- b. Үгүй

12. Та орон нутагт жендэрийн асуудлаар зохион байгуулсан ямар үйл ажиллагаанд хамрагдсан бэ? Үүнд:

- a. Сургалт
- b. Уулзалт, хэлэлцүүлэг
- c. Өдөрлөг арга хэмжээ
- d. Судалгаа
- e. Төсөл
- f. Хамрагдаж байгаагүй
- g. Бусад(бичнэ үү?)

c. Бүрэн дунд

d. Бүрэн бус дунд

e. Бага

f. Боловсролгүй

6. Та хэд дүгээр багт харъяалагддаг вэ?..... (бичнэ үү?)

7. Танай өрхийн ам бүлийн тоо: (бичнэ үү?)

8. Таны ажилладаг байгууллага дараах ангилалын алинд нь хамаарах вэ?

a. Төрийн өмчит уул уурхайн аж ахуйн нэгж

b. Хувийн өмчит уул уурхайн аж ахуйн нэгж

c. Төрийн өмчит ХХК

d. Барилгын салбар

e. Нийтийн худалдаа

f. Нийтийн хоол

g. Бусад.....(бичнэ үү?)

9. Таны эрхэлж буй ажил

a. Удирдах ажилтан

b. Нарийн мэргэжлийн

c. Туслах

d. Үйлчилгээний

e. Гэрээт

f. Бусад.....(бичнэ үү?)

10. Таны ажилласан жил:(бичнэ үү?)

11. Таны гэр бүлийн байдал:

a. Гэрлээгүй

b. Гэрлэсэн

c. Салсан

d. Бэлэвсэн

12. Та эрүүл мэндийн даатгалд хамрагдсан уу?

a. Тийм

b. Үгүй

ХОЁР. ҮНДСЭН АСУУЛТ

1. Жендэр хэмээх ойлголтыг аль нь илэрхийлж байна вэ?

a. Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах тухай ойлголт

b. Эмэгтэйчүүдийн шийдвэр гаргах түвшин дэх оролцоог нэмэгдүүлэх тухай ойлголт

c. Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн нийгэм, соёлын ялгаатай болохыг тайлбарласан ойлголт

d. Хаана ч эрэгтэй, эмэгтэй хүмүүс тооны хувьд тэнцвэртэй байлгах тухай ойлголт

e. Нийгэм дэх эрэгтэй эмэгтэй хүмүүсийн тэгш эрх, тэгш боломж, тэш оролцоо, тэгш байдал, эрх тэгш шийдвэрийн тухай ойлголт

f. Бусад (бичнэ үү?)

2. Дараах бодомжуудыг уншаад зөв, буруу болохыг зохих нүдэнд нь ✓ тэмдэглэнэ үү?

Бодомж	Зөв	Буруу
1.Өрхийн тэргүүн эрэгтэй хүнийг илүү хүндэтгэх ёстой.		
2. Сайн эхнэр бол нөхрийнхөө үгэнд орох ёстой		
3. Эр хүн бол өрх гэр бүлээ авч явагч, тэжээгч		
4.Залуу эмэгтэйчүүд жирэмсэн болж, хүүхэдтэй болох тул ажилд авах хэрэггүй		

3. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах нь таны амьдралд хэр нөлөөтэй гэж үзэж байна вэ?

a. Эерэг нөлөөтэй

b. Ямар ч нөлөөгүй

c. Сөрөг нөлөөтэй

d. Мэдэхгүй

4. Та сүүлийн 2 жилд эрүүл мэндийн ямар тусламж үйлчилгээ авсан вэ? Үүнд:

- a. Амбулаторын тусламж үйлчилгээ
- b. Стационарийн тусламж үйлчилгээ
- c. Өдрийн эмчилгээ
- d. Рашаан сувилалын тусламж үйлчилгээ
- e. Эмийн үнийн хөнгөлөлт
- f. Оношилгоо, шинжилгээ
- g. Уламжлалт эмчилгээ
- h. Хөнгөвчлөх эмчилгээ
- i. Өөр бусад(бичнэ үү?)
- j. Авч байгаагүй /Энэ хариултыг сонгосон бол 6 дугаар асуулт руу шилжинэ үү./

5. Та сүүлийн 2 жилд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авч байгаагүй шалтгаанаа сонгоно уу.

- a. Зав гардаггүй тул
- b. Өвдөх зовиурлах зүйл байдаггүй тул
- c. Өвдвөл очно
- d. Өвдсөн ч тоохгүй орхидог тул
- e. Оочер, үйлчилгээ нь чирэгдэлтэй тул
- f. Бусад..... (бичнэ үү?)

6. Дээрх үйлчилгээг та аль шатлалын эмнэлгээс ихэвчлэн авч байна вэ?

- a. Өрхийн эмнэлэг
- b. Аймгийн нэгдсэн эмнэлэг/БООТ
- c. Улсын 1, 2, 3 дугаар эмнэлэг
- d. Хувийн эмнэлэг
- e. Бусад.....(бичнэ үү?)

7. Танд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авахад хялбар байдаг уу?

- a. Хялбар байдаг /энэ хариултыг сонгосон бол 9 дүгээр асуулт руу шилжинэ үү/
- b. Ихэнхдээ төвөгтэй байдаг
- c. Төвөгтэй байдаг тул эмнэлэгийн тусламж, үйлчилгээ авдаггүй.

8. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авахад төвөгтэй байдаг бол шалтгааныг нь бичнэ үү?

.....
.....

9. Таны эрүүл мэндэд сөргөөр нөлөөлсөн хүчин зүйлийг сонгоно уу?

- a. Зохисгүй хооллолт
- b. Архи, тамхины хэрэглээ
- c. Орлогын хүрэлцээгүй байдал
- d. Гэр бүлийн уур амьсгал
- e. Бусдын халамж анхаарал
- f. Стресс
- g. Удамшил
- h. Ажлын нөхцөл
- i. Эрүүл мэндийн боловсролын талаарх хангалтгүй мэдлэг
- j. Ус, хөрс, агаар, байгаль орчны бохирдол
- k. Эрүүл мэндийн хувьд ямар ч асуудалгүй

10. Сүүлийн 2 жилд амь эрсдэхээр ямар нэгэн тохиолдолд өртөж байсан уу?.

- a. Тийм
- b. Үгүй /энэ хариултыг сонгосон бол 12 дугаар асуулт руу шилжинэ үү./

11. Амь эрсдэхээр ямар нэгэн тохиолдолд өртөж байсан бол

- a. Тохиолдлыг бичнэ үү:
.....
- b. Тохиолдлын тоо.....

12. Та бага байхдаа хүнд ажил хийж байсан уу?

- a. тийм
- b. үгүй

13. Одоогийн эрхэлж буй ажлынхаа эрүүл мэндэд нөлөөлөх эрсдлийн түвшинг үнэлнэ үү.

- a. эрсдэлгүй
- b. бага зэргийн эрсдэлтэй
- c. дунд зэргийн эрсдэлтэй
- d. өндөр эрсдэлтэй

14. Та өөрийн эрүүл мэндийн байдлаас шалтгаалан тусламж, үйлчилгээ авсан БОЭТ-ийн тасгийг сонгоно уу.(сүүлийн 1 жилийн дотор)

- a. Дотор
- b. Мэдрэл
- c. Шүд, чих, хамар, хоолой,эрүү нүүрний мэс засал
- d. Дотоод шүүрэл
- e. Мэс засал, гэмтэл
- f. Халдварт, сүрьеэ
- g. Хавдар
- h. Нүд
- i. Бусад.....

15. Та эрэгтэйчүүдэд зориулсан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг үнэлнэ үү?. (Дорнод аймгийн хүрээнд)

- a. маш сайн b. сайн c. дунд зэрэг d. муу e. маш муу

16. Та өөрийн эрүүл мэндээ хамгаалах, урьдчилан сэргийлэх талаар ямар арга хэмжээ авдаг вэ?

.....

.....

.....

17. Та орон нутагт Жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөр батлагдан, хэрэгжиж байгааг сонсож байсан уу?

- a. Тийм
- b. Үгүй

18. Та жендэртэй холбоотой мэдээллийг авдаг уу?

- a. Авдаг
- b. Авдаггүй

19. Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн онцлог хэрэгцээнд зориулсан ямар үйлчилгээг бий болгох шаардлагатай гэж үздэг вэ?

.....

.....

.....

СУДАЛГААНД ИДЭВХИТЭЙ ОРОЛЦСОН ТАНД БАЯРЛАЛАА.

3.ЧАНАРЫН СУДАЛГАА

Чанарын судалгааны аргаар хувийн хэвшлийн байгууллага болон аж ахуйн нэгжүүдийн удирдах ажилтан, ажиллагсдын ЖЭТБ-ын талаарх ойлголт мэдлэг болон жендэрийн мэдрэмжтэй төлөвлөлт, ажлын байрны нөхцөл байдал, эрэгтэйчүүдэд үзүүлж буй эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийн тухай фокус бүлгийн хэлэлцүүлэг болон ганцаарчилсан ярилцлага хийж, асуудлын учир шалтгаан, түүнийг шийдвэрлэх боломжуудын талаар тодруулан судлана.

Чанарын судалгааны хамрах хүрээ, гол мэдээлэгчдийн тоо

Ганцаарчилсан ярилцлага	Респондентын тоо	Бүлгийн ярилцлага	Респондентын тоо

1. Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн ажил олгогч болон ажиллагсдын ЖЭТБ-ын талаарх ойлголт мэдлэг болон жендэрийн мэдрэмжтэй төлөвлөлт, ажлын байрны нөхцөл байдлыг тодорхойлох			
Аймгийн ИТХ-ын дарга	1	Хувийн хэвшлийн ажилчдын төлөөллийн бүлэг	8
ИТХ-ын өргөдөл, гомдол, хяналт, үнэлгээний бодлогын хорооны дарга	1	Аж ахуйн нэгжийн ажилчдын төлөөллийн бүлэг	8
ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга	1		
ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн жендэрийн мэргэжилтэн	1		
Аймгийн ҮЭХ-ны дарга	1		
Ажил олгогчдын эздийн холбооны тэргүүн	1		
Хувийн хэвшил, ААНБайгууллагын удирдлага (Шин Шин ХХК, ДБЭХС ТӨХК, “Их тал” ХХК, “Онхоодой Өндөр” ХХК, НААҮГ)	6		
Хүний эрхийн үндэсний комиссын салбар зөвлөлийн ахлах мэргэжилтэн	1		
1. Эрэгтэйчүүдэд үзүүлж буй эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг тодорхойлох			
Аймгийн ИТХ-ын нийгмийн бодлогын хорооны дарга	1	Эрэгтэйчүүдийн төлөөллийн бүлэг (Хувийн хэвшилд ажиллаж буй эрэгтэйчүүдийн бүлэг)	8
ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга	1	Зорилтот бүлгийн иргэдийн төлөөлөл	8
ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн, жендэрийн клубын гишүүн	1	ИНБ-уудын төлөөллийн бүлэг	8
Цэргийн штабын дарга	1		
БОЭТ-ийн захирал	1		

“ОРОН НУТГИЙН ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ ДЭД ХӨТӨЛБӨРТ “ОРОЛЦООНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ” ХИЙХ АРГАЧЛАЛ” сургалтын гарын авлага

БОЭТ-ийн санхүү эрхэлсэн дэд захирал	1		
БОЭТ-ийн чанарын менежер	1		
БОЭТ-ийн мэс заслын эмч	2		
ЭМГ-ын дарга	1		
ЭМГ-ын статистикч, жендэрийн асуудал хариуцсан мэргэжилтэн	1		
Хувийн эмнэлэгийн удирдлага	1		
Орон нутгийн ИНБ-ын төлөөлөл	3		
Нийт	28	Нийт	34

ГАНЦААРЧИЛСАН ЯРИЛЦЛАГА

Ажлын хуудас 3.9

Ганцаарчилсан ярилцлагын удирдамж

Ерөнхий хэсэг

Ганцаарчилсан ярилцлагын зорилго: Хувийн хэвшлийн байгууллага болон аж ахуйн нэгжүүдийн удирдах ажилтан нарын ЖЭТБ-ын талаарх ойлголт мэдлэг болон жендэрийн мэдрэмжтэй төлөвлөлт, ажлын байрны нөхцөл байдлын талаар ганцаарчилсан ярилцлага хийж, асуудлын учир шалтгаан, түүнийг шийдвэрлэх боломжуудын талаар тодруулан судлана.

Аймаг, сумын нэр	Дорнод аймаг.....
Байгууллагын нэр
Албан тушаал, туршлага
Эхэлсэн цаг, дууссан цаг, хаана
Ярилцагч, тэмдэглэл хөтөлгчийн нэр	

Үндсэн хэсэг

1. Орон нутагт хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд жендэрийн эрх тэгш байдал ямар түвшинд байна гэж та боддог вэ?
2. Хувийн хэвшлийн ажлын байрыг жендэрийн мэдрэмжтэй болгох ЖЭТБ хангах дэд хөтөлбөрт тусгагдсан тодорхой заалтуудын талаар танай байгууллагад юу хийгдэж байна вэ?
3. Танай байгууллагад ЖЭТБХангахад чиглэсэн үйл ажиллагаа төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжиж байна уу?. Хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаар ажилтнуудад мэдээлэл хийдэг үү?
4. Хөдөлмөр эрхлэлт болон хөдөлмөрийн харилцаанд жендэрээр ялгаварлан гадуурхах, Монгол Улсын олон улсын гэрээ, хууль тогтоомжид зөвшөөрснөөс бусад тохиолдолд эрэгтэй, эмэгтэй хүйсийн аль нэгэнд давуу эрх олгох, хязгаарлалт тогтоох, мөн жирэмсэн, хүүхэд асарсан болон гэр бүлийн байдлын шалтгаанаар ажилтныг ажлаас халахыг хориглосон бөгөөд энэ заалт үр дүнтэй хэрэгжиж байна уу?
5. Танай байгууллагын хөдөлмөр эрхлэлтийн дотоод журам, хамтын гэрээ, хөдөлмөрийн гэрээнд ЖЭТБХ талаар ямар заалтууд орсон байдаг вэ?.

Төгсгөл хэсэг

1. “ААН байгууллага нь нийгмийн хариуцлагын хүрээнд дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд оролцож дэмжлэг үзүүлнэ” хэмээн ЖЭТБХ дэд хөтөлбөрийн 6.3.3-т хэрэгжүүлэхэд оролцогч талуудын чиг үүргийг тусгасан байдаг. Танай байгууллага энэхүү заалтыг хэрэгжүүлэхэд хэрхэн оролцож байна вэ?
2. Танай байгууллагын бодлого, төлөвлөгөө, үйл ажиллагааны төсөвлөлт жендэрийн мэдрэмжтэй хийгддэг үү?.
3. Танай байгууллагын зүгээс хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд ЖЭТБХ талаар санаачлан хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, туршлагаасаа хуваалцана уу?.
4. Танай байгууллагын хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд жендэрийн тулгамдсан асуудлыг хэрхэн шийдвэрлэж байна вэ?. Тухайлбал:

Тэмдэглэл (ярилцлагад оролцогчийн зан үйл, хандлагын талаарх мэдрэмж, ярилцлагын үеийн сэтгэгдэл, анхаарах асуудлыг тэмдэглэнэ)

Тайлбар: Ганцаарчилсан ярилцлагад оролцож буй хүний ажил албан тушаалын чиг үүгийг харгалзан дээрх асуултуудаас сонгож ярилцлага хийнэ.

ГАНЦААРЧИЛСАН ЯРИЛЦЛАГА

Ажлын хуудас 3.9

Ганцаарчилсан ярилцлагын удирдамж

Ерөнхий хэсэг

Ганцаарчилсан ярилцлагын зорилго: Эрэгтэйчүүдэд үзүүлж буй эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж, тулгамдсан асуудал түүнийг шийдвэрлэх боломжуудыг тодорхойлох.

Аймаг, сумын нэр	Дорнод аймаг.....
Байгууллагын нэр
Албан тушаал, туршлага
Эхэлсэн цаг, дууссан цаг, хаана
Ярилцагч, тэмдэглэл хөтлөгчийн нэр	

Үндсэн хэсэг

1. Дорнод аймагт төрийн байгууллагын зүгээс эрэгтэй эмэгтэй хүмүүсийн эрүүл мэндийн онцлог хэрэгцээнд зориулсан үйлчилгээг бий болгоход хэрхэн анхаарч ажиллаж байна вэ?
2. Дорнод аймгийн хэмжээнд хэрэгжиж буй нийгмийн хөтөлбөр төслүүдийн жендэрийн мэдрэмжтэй байдлыг үнэлнэ үү?
3. Дорнод аймгийн хэмжээнд эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах нь жендэрийн тулгамдсан асуудал мөн үү?
4. Бодлогын түвшинд эрэгтэйчүүдийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлийг бууруулахад ямар шийдвэрүүд гарсан бэ?
5. Эрэгтэйчүүдийн дунд зонхилон тохиолдож байгаа өвчлөлийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээнд шаардагдах санхүүжилтийг орон нутгийн болон улсын төсөвт аль хир тусгадаг вэ?
6. ЖЭТБХ хангах дэд хөтөлбөрийн 3.3.1-д “...Эрэгтэйчүүд болон хөвгүүдэд зориулсан кабинетийг байгуулан эрүүл мэндийн үзлэг оношилгоо, сэтгэл зүйн зөвлөгөө бусад үйлчилгээг нэмэгдүүлэх” гэсэн заалтын хэрэгжилт ямар түвшинд байна вэ?

Төгсгөл хэсэг

1. ЖЭТБХ дэд хөтөлбөрийн 4.1.4-т “Эрэгтэйчүүд судлал, эрэгтэйчүүдэд үзүүлэх цогц үйлчилгээний эхлэл тавигдсан байна” гэсэн хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийг гаргасан байна. Энэ ажлын хэрэгжилт, явцын талаар танилцуулна уу. Энэ асуудлын талаар цаашид хийхээр төлөвлөж буй ямар ажлууд байна вэ?

Тэмдэглэл (ярилцлагад оролцогчийн зан үйл, хандлагын талаарх мэдрэмж, ярилцлагын үеийн сэтгэгдэл, анхаарах асуудлыг тэмдэглэнэ)

Тайлбар: Ганцаарчилсан ярилцлагад оролцож буй хүний ажил албан тушаалын чиг үүгийг харгалзан дээрх асуултуудаас сонгож ярилцлага хийнэ.

БҮЛГИЙН ЯРИЛЦЛАГА

Бүлгийн ярилцлагын удирдамж
Ерөнхий хэсэг

Бүлгийн ярилцлагын зорилго: Хувийн хэвшлийн байгууллага болон аж ахуйн нэгжүүдийн ажилчдын ЖЭТБ-ын талаарх ойлголт мэдлэг болон ажлын байрны нөхцөл байдал, хөдөлмөрийн харилцаанд тулгарч буй жендэрийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх боломжуудыг тодорхойно.

Аймаг нийслэл, сум дүүргийн нэр				
Ярилцлага эхэлсэн, дууссан цаг, хаана				
Бүлгийн ярилцлагад оролцогчдын категори	Хувийн хэвшлийн ажилчдын төлөөллийн бүлэг, Аж ахуйн нэгжийн ажилчдын төлөөллийн бүлэг				
Чиглүүлэгчийн нэр				
Ажиглагчийн нэр				
Танилцуулга					
Бүлгийн ярилцлагад оролцогчдын мэдээлэл					
N	Нэр	Нас	Хүйс	Эрхэлдэг ажил	Ажилласан жил
1
2
3					

Үндсэн хэсэг

1. Жендэр болон жендэрийн ялгаварлан гадуурхалт гэдгийг юу гэж ойлгож байна вэ?
2. ЖЭТБХ дэд хөтөлбөр хэрэгждэг тухай сонсож байсан уу?
3. Хувийн хэвшил, аж ахуйн нэгж байгууллагын дотоод журам, хамтын гэрээ болон хөдөлмөрийн гэрээнд ЖЭТБХ тухай хэрхэн тусгасан байдаг вэ?
4. Ажлын байрны нөхцөл, хөдөлмөрийн харилцаанд гарч буй жендэрийн тулгамдсан ямар асуудал байна вэ?. Хэрвээ асуудал гарвал түүнийг хэрхэн шийдвэрлүүлэх вэ?
5. Байгууллагын дотоод журам, хамтын гэрээ, хөдөлмөрийн гэрээнд ЖЭТБХ ямар заалтуудыг тусгах шаардлагатай гэж үзэж байна вэ?

Төгсгөл хэсэг

1. ЖЭТБХ талаар байгууллага болон таны зүгээс цаашид юу хийх боломжтой байна вэ?

Тэмдэглэл (ярилцлагад оролцогчийн зан үйл, хандлагын талаарх мэдрэмж, ярилцлагын үеийн сэтгэгдэл, анхаарах асуудлыг тэмдэглэнэ)

БҮЛГИЙН ЯРИЛЦЛАГА

Бүлгийн ярилцлагын удирдамж
Ерөнхий хэсэг

Бүлгийн ярилцлагын зорилго: Эрэгтэйчүүдэд үзүүлж буй эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж, тулгамдсан асуудал түүнийг шийдвэрлэх боломжуудыг тодорхойлох.

Аймаг нийслэл, сум дүүргийн нэр				
Ярилцлага эхэлсэн, дууссан цаг, хаана				
Бүлгийн ярилцлагад оролцогчдын категори	Эрэгтэйчүүдийн төлөөллийн бүлэг (Хувийн хэвшилд ажиллаж буй эрэгтэйчүүдийн бүлэг) ИНБ-ын төлөөллийн бүлэг				
Чиглүүдлэгчийн нэр				
Ажиглагчийн нэр				
Танилцуулга Бүлгийн ярилцлагад оролцогчдын мэдээлэл					
N	Нэр	Нас	Хүйс	Эрхэлдэг ажил	Ажилласан жил
1
2
3					

Үндсэн хэсэг

1. Жендэр болон жендэрийн эрх тэгш байдал гэдгийг юу гэж ойлгож байна вэ?
2. ЖЭТБХ дэд хөтөлбөр хэрэгждэг тухай сонсож байсан уу?
3. Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн онцлог хэрэгцээнд нийцсэн эрүүл мэндийн үйлчилгээг төрийн зүгээс үзүүлж байна уу?
4. Эрэгтэйчүүд эрүүл мэндээ хамгаалах болон үйлчилгээ авахад гарч буй хүндрэл бэрхшээлүүдийн талаар ярилцана уу?
5. Эрэгтэйчүүдийн эрүүл мэндэд нөлөөлж буй хүчин зүйл юу байна вэ? (Эерэг болон сөрөг)
6. Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг дэмжих, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулахад юу хийх шаардлагатай байна вэ?

Төгсгөл хэсэг

1. Орон нутагт эрэгтэйчүүд болон хөвгүүдэд зориулсан кабинетыг байгуулан эрүүл мэндийн үзлэг оношилгоо, сэтгэл зүйн зөвлөгөө болон бусад үйлчилгээг нэмэгдүүлэхэд хамгийн чухал ямар шийдвэр гаргах шаардлагатай байна вэ?
1. Эрэгтэйчүүд судлал, эрэгтэйчүүдэд зориулсан цогц үйлчилгээг хөгжүүлэх тухай та саналаа хэлнэ үү.

Тэмдэглэл (ярилцлагад оролцогчийн зан үйл, хандлагын талаарх мэдрэмж, ярилцлагын үеийн сэтгэгдэл, анхаарах асуудлыг тэмдэглэнэ)